


Нээлттэй
Нийгэм
Форум


20

ЖИЛ





*Төрийн үйл хэрэгт иргэд, иргэний нийгмийн мэдлэг
мэдээлэлтэй, идэвхитэй оролцоог дэмжихэд бидний
эрхэм зорилго оршино.*





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

20

ЖИЛ



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

OPEN SOCIETY FORUM

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

П.Эрдэнэжаргал

Энэхүү тайланг уншиж буй эрхэм хүндэт таны амгаланг эрье.

Нээлттэй Нийгэм Форум үүсэн байгуулагдсан 20 жилийн тэртээг эргэн санахад манай улсад ардчиллын институциуд төлөвшиж, иргэд ардчилсан тогтолцоонд эдлэх эрх, үүрэх хариуцлагаа ухамсарлаж эхэлсэн ч төрийн үйл хэрэгт оролцох боломж, нөхцөлүүд үгүйлэгдсэн үе байв. Энэхүү цаг үед ардчилсан тогтолцооны амин сүнс болсон иргэдийн оролцоог дэмжих, нотолгоо судалгаанд суурилсан оновчтой төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилго дор Үндсэн хуулийнхаа дагуу эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэн бид Нээлттэй Нийгэм Форум (ННФ) хэмээх байгууллагыг үүсгэсэн билээ.

Тэр үеэс хойших хугацаанд манай улс Үндсэн хуулиараа тунхагласан ардчилсан тогтолцоогоо бэхжүүлэх, төрийн бодлогыг чанаржуулах, хяналтын институциудын хараат бус байдлыг дээшлүүлэх, иргэдийн оролцооны суваг, механизмүүдыг бүрэлдүүлэх талаар багагүй амжилт гаргаж ирснийг тэмдэглэхэд таатай байна. Энэ он жилүүдэд иргэний нийгэм төлөвшин чадавхиж, мэдлэг оюун, хүчин чармайлтаа нэгтгэн хүний эрх, нийтийн эрх ашиг, ардчилсан тогтолцоогоо хамгаалахад суралцаж, үнэтэй хувь нэмэр оруулж ирснийг энд онцлон тэмдэглэе.

Эх орныхоо ардчилсан хөгжлийг дэмжиж хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тоймыг олон нийтэд хүргэн 20 жилийн ойгоо тэмдэглэж буйдаа нэн баяртай байна. Бид энэ хугацаанд улс орныхоо тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон, тэдгээрийг шийдвэрлэхэд ахиц, түлхэц үзүүлэх үйл ажиллагааны хэд хэдэн стратеги боловсруулж хэрэгжүүллээ. Манай үйл ажиллагаа ардчиллыг гүнзгийрүүлэх, хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн ил тод хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, иргэдийн оролцоо, иргэний нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэж ирэв.

2024 онд Монгол Улс парламентын 9 дэх удаагийн ээлжит сонгуулиа амжилттай зохион байгуулж түүхэнд тайван замаар сонгууль явуулсан шинэ хуудас дахин нэгээр нэмэгдэв. Сонгуулийн легитим чанар нь ардчилсан тогтолцоонд бүхэлд нь нөлөө үзүүлдэг тул эрх зүйн орчныг чөлөөт, шударга сонгуулийн зарчимд нийцүүлэх, техник технологийн хурдацтай хөгжилтэй уялдуулах, сонгуулийн үйл явцад иргэний нийгмийн хяналт оролцоог нэмэгдүүлэхэд тасралтгүй анхааран, арга зүй, техникийн туслалцаа үзүүлж ирлээ. Иргэний нийгмийн байгууллагууд ННФ-ын дэмжлэгээр 2004 оноос эхлэн сонгуулийн үйл явцад хараат бус хяналт тавьж ирсэн нь маргаан зөрчлөөс сэргийлээд зогсохгүй сонгуулийн өрсөлдөөний тэгш гарааны зарчмыг хангаж, төрийн нөөцийг ашиглах явдлыг

хязгаарлах, сонгогчдын нэрийн жагсаалтын хяналтыг сайжруулах гэх мэтээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулсаар байна.

Форумын үйл ажиллагааны эхэн үеийн нэгэн чухал хэсэг нь эдийн засгийн хөгжлийн бодлогын асуудлаар судалгаа шинжилгээ хийх, үндэсний болон олон улсад нэр хүндтэй хөгжлийн эдийн засагчдын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх, эдийн засгийн хөгжлийн сценари боловсруулах зэрэг байв. Сүүдрийн эдийн засаг, бэлчээрийн мал аж ахуй, газрын шинэтгэл, өрсөлдөх чадвар, эрчим хүчний засаглалын чиглэлээр хийсэн судалгаанууд манай улс хөгжлийн бодлогоо тодорхойлохоор идэвхтэй ажиллаж байсан цаг үед эрэлт хэрэгцээтэй эх сурвалж болсон нь дамжиггүй. Сүүлийн жилүүдэд бид иргэдийн орлогын тэгш бүс байдлыг бууруулах хүчин зүйлсийг судлахад анхаарч, төсвийн орлого, зарлагын бүтэц, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлс болох татварын асуудлаар болон иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд халамжийн үзүүлэх нөлөө зэрэг судалгааг эрхлэн хэвлэн нийтлэв.

Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн чухал хэрэгсэл болох төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх нь манай улсын эдийн засаг сэргэж, төсвийн орлого эрс нэмэгдэж ирсэн 2000-аад оны дундуур нэн тулгамдсан асуудал болж байв. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд төсвийн ил тод байдалд ихээхэн ахиц дэвшил гаргахад иргэний нийгмийн байгууллагуудын тууштай хүчин чармайлт чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглүүштэй. Бид үндэсний болон орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, судлаачидтай хамтран төсвийн ил тод байдал, зарцуулалтад хяналт тавьж, төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийн, тодорхой санал зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагчдад хүргэж, улмаар бодлогын баримт бичгүүдэд тусгахад нөлөө

үзүүлж ирэв. Тухайлбал, бидний нөлөөллийн цогц ажиллагааны үр дүнд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд хэрэгжих хугацаанд үл өөрчлөгдөх кодтой болсон нь тэдгээрийн санхүүжилт болон хэрэгжилтийн явцад хяналт тавих нөхцөлийг хялбар дөхөм болгосон билээ.

Эрдэс баялгийн салбарын бодлого зохицуулалтыг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцүүлэх, газрын доорх баялгаа үр өгөөжтэй, хүртээмжтэй ашиглах сорилттой ид нүүр тулж байсан 2000-аад оны дунд үеэс бид тус салбарын татвар санхүүгийн дэглэм, хөрөнгө оруулалтын гэрээний асуудлаар олон улсын түвшний мэргэжилтнүүдтэй хамтран бодлогын зөвлөмжүүд гаргаж, олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэснээр энэ салбарт хэрэгжүүлж буй олон жилийн үйл ажиллагаа маань эхэлсэн түүхтэй. Улмаар эрдэс баялгийн салбарын засаглалыг сайжруулах, төсөвт орох нөөцийг бүртгэх, удирдах, хуваарилах процессыг хяналттай, ил тод болгох, орлогын удирдлагыг сайжруулах, төрийн өмчит компанийн засаглалыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд мониторинг хийх, байгаль орчинд учруулсан хохирлын асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх зэрэг санал санаачилгыг өрнүүлсэн нь нөхөн сэргэхгүй нөөц баялгаа улс орны өнөө ба ирээдүйн хөгжлийн зорилгод нийцүүлэн хариуцлагатай ашиглах суурийг бүрдүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн гэдэгт итгэж байна. Олборлох салбарыг ил тод болгох зорилго бүхий олон улсын санаачилгад манай улс нэгдэн орж, хэрэгжүүлэхэд гаргасан бидний хүчин чармайлт үр дүнд хүрч, уул уурхайгаас олж буй бүхий л орлогыг бүртгэх, тайлагнах, гэрээнүүдийг ил тод болгох стандарт бий болж, үүнийг дагалдан эцсийн өмчлөгчдийн мэдээлэл ил болсноор авлига, ашиг сонирхлын зөрчил, мөнгө угаахын эсрэг зэрэг олон улсын стандарт шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөл бүрджээ.

Ардчилсан хөгжлийн замыг сонгоод 10 гаруйхан жилийн нүүр үзэж байсан манай улсад ид өрнөсөн шударга ёсны тогтолцооны шинэтгэлийг дэмжин ихээхэн хүчин чармайлт гарган хэрэгжүүлж ирсэн хөтөлбөрийн нэг нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх цогц үйл ажиллагаа юм. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн явцыг үнэлэх судалгаанаас эхлээд шүүх хуралдааны мониторинг, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, шүүхийн индексийн үнэлгээ зэргийг олон улсын туршлага, өөрийн улсад өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийн үйл явцын онцлогийг харгалзан боловсруулсан арга зүйн дагуу хийж ирсэн нь шүүх эрх мэдлийн хүрээний бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой эх сурвалж нэгэнт болжээ. Олон жилийн туршид хэрэгжүүлсэн бодлогын судалгааны хөтөлбөр маань эрх зүйн салбарт судалгаа шинжилгээний үнэлэмжийг дээшлүүлэх, хэрэглээнд оруулах, судлаач хуульчдын туршлага, үр чадвар бэхжихэд багагүй хувь нэмэр оруулсан гэдэгт эргэлзэхгүй байна.

2008 оноос эрчимжсэн эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийг ардчиллын үнэт зүйл, зарчимд нийцүүлэн шинэчлэх, хууль сахиулах байгууллагууд хүний эрхийг дээдэлсэн, иргэдэд нээлттэй, ээлтэй болоход нь хувь нэмэр оруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл хүргэх нь бидний ажлын бас нэг чухал хэсэг байв. Тухайлбал, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны стандарт, дүрэм журмыг шинэчлэх, алба хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх, салбарын шинэ хуулиудын хэрэгжилтийг үнэлэх зэрэг цогц дэмжлэгийг оролцогч талуудад үзүүллээ. Иргэдэд хүртээмжтэй хууль зүйн туслалцааны тогтолцоог бий болгох санаачилга маань ч биеллээ олж, эрх зүйн орчин нь боловсронгуй болж, үйлчилгээний чанар, цар хүрээ нь тэлж байна.

Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох нийгмийн томоохон өөрчлөлтөд бид манлайлан оролцож, энэхүү шинэ тутам асуудлаар мэргэжлийн чадавх бүрдүүлэх, эцэг эхийн оролцоо, олон нийтийн дэмжлэгийг бий болгоход тууштай анхааран ажиллав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих болон боловсролд тэгш хамруулах шинэлэг ойлголт мэдлэг, арга зүйг эзэмшин, салбартаа танигдсан шинжээчид болж буй нь бахархалтай хэрэг юм.

Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэх болсон өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл нь хүүхдийн насан туршийн амьдралд ч нөлөө үзүүлж болзошгүйн зэрэгцээ олон нийтийн аюулгүй байдал, хувь хүний сэтгэцийн эрүүл мэндийн асуудал бөгөөд зорилтот бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх замаар урьдчилан сэргийлэх боломжтой юм. ННФ үр нөлөө нь нотлогдсон олон улсын стратеги, хөтөлбөрүүдийг нутагшуулах замаар залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг түгээж, багш бэлтгэдэг коллеж, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт суулган үг асуудлаар ажиллах мэргэжилтэн бэлтгэх суурийг тавилаа.

Ардчилал нь урагшлуулан хөгжүүлэх, ухралтаас сэргийлэхэд байнга анхаарч байх шаардлагатай динамик үйл явц тул бид хувьсал өөрчлөлтөөс хоцрохгүй байж, олон салбарт шинэчлэлийн санаа оноо сэдэж, хувь нэмрээ оруулж ирснийг ийнхүү хураангуйлан танилцууллаа. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд өөрсдийн оюун ухаан, эрдэм мэдлэг, цаг заваа харамгүй зарцуулж, ННФ-ын үйл ажиллагааг чиглүүлж ирсэн Удирдах зөвлөлийн гишүүд, энэхүү тайланд дурдсан олон ажлыг бүхий л цаг үед

хариуцан, мэдлэг оюунаа дайчлан, хичээл зүтгэл гарган, санал санаачилгатай гүйцэтгэж ирсэн нийт ажилтан, олон жилийн туршид үр бүтээлтэй хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагууд, зүтгэлтнүүд, санал санаачилгын ундарга болсон идэвхтэй иргэд, шинэчлэл өөрчлөлтийг үргэлж эрэлхийлж ажил хэрэг болгоход манлайлсан төр засгийн төлөөллүүдийн оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж энэхүү тайлангаа зориулж байна.

Бидний амьдарч буй өнөө цаг 20 жилийн өмнөхтэй харьцуулахад улам ярвигтай болж, олон улсын

харилцаа хурцдах хэрээр манай улсын геополитикийн нөхцөл байдал хүндэрч, эрдэс баялагт суурилсан эдийн засгийн эрсдэлүүд улам нарийсаж, 30 гаруйхан жилийн түүхтэй ардчилалд маань олон сорилт тулгарч байна. Бид цаашид ардчилсан Үндсэн хуулиа дээдлэн хүний эрх, эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, нийтийн баялгийг захиран зарцуулах төрийн хариуцлагыг дээшлүүлэх, хөгжлийн оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд бүхий л бололцоо нөхцөлөө дайчлан хувь нэмрээ оруулан ажиллах болно.

Хүндэтгэн ёсолсон ННФ-ын Гүйцэтгэх захирал



2024 оны 12 дугаар сар

Гарчиг

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.....	3
Товчилсон үг.....	8
Ардчилал, хүний эрх.....	9
Чөлөөт, шударга сонгууль.....	10
Ардчиллын институциуд.....	16
Мэдээллийн ил тод байдал.....	18
Хэвлэл мэдээллийн эрх чөлөө.....	19
Хүний эрхийг хамгаалахад иргэний нийгмийн оролцоо.....	21
Хариуцлагатай, ил тод төр.....	25
Төрийн хариуцлагын механизмууд.....	26
Төсвийн ил тод, хариуцлагатай байдал.....	29
Эрдэс баялгийн салбарын засаглалыг бэхжүүлэх нь.....	35
Шударга ёсны тогтолцооны шинэтгэл.....	47
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь.....	48
Эрүүгийн эрх зүйн шинэтгэл.....	54
Эрх зүйн туслалцаа.....	58
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь.....	60
Эдийн засаг, нийгмийн бодлого.....	63
Эдийн засгийн бодлогын асуудал.....	64
Боловсрол, нийгмийн бодлого.....	69
Иргэд, иргэний нийгмийн оролцоо.....	73
Иргэдийн оролцооны механизмуудыг бүрдүүлэх нь.....	74
Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих нь.....	79
Үйл ажиллагааны арга хэрэгслүүд.....	81
Хөгжлийн мэдээллийн төв.....	82
Портал сайт (www.forum.mn).....	83
“Форум ТВ” нэвтрүүлэг.....	85
Хэвлэн нийтлэл.....	87
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр.....	89
Удирдах зөвлөлийн гишүүд ба ажилтнууд.....	90

Товчилсон үг

АТГ	Авлигатай тэмцэх газар
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ББЗХ	Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХХ	Монголын хуульчдын холбоо
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ОНРТ	Олон нийтийн радио телевиз
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ТАН	Төлсөн Авсанаа Нийтэл
ТӨК	Төрийн өмчит компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
АСГ	Үндэсний аудитын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ШСХ	Шүүхийн сахилгын хороо
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль



АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХ

Чөлөөт, шударга сонгууль

Ардчиллыг бэхжүүлэх нь олон талт цогц үйл явц билээ. Сонгууль бол үүний эхлэл цэг төдий боловч түүний шударга байдал алдагдвал ардчиллын легитим чанар бүхэлдээ дагаж суларна.

- НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан

Бид ил тод, шударга сонгуулийн төлөө 20 жилийн хугацаанд иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудтай үр бүтээлтэй хамтран ажиллаж, бодлогын томоохон өөрчлөлт хийхэд багагүй хувь нэмэр оруулж ирлээ.

Шударга сонгуулийн нэг гол зарчим нь өрсөлдөөний тэгш гараа юм. Энэ зарчмын хүрээнд 2004 онд Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийг Сонгогчдын боловсрол төв, Глоб Интернэшнл Төв зэрэг төрийн бус байгууллага (ТББ)-тай хамтран зохион байгуулсан нь ардчилсан сонгуулийн түүхэнд анх удаа хийсэн хараат бус, хөндлөнгийн хяналт болов. 2004 оноос өмнөх сонгуулиудад төрийн эх үүсвэр буюу төрийн өмчийн байр, машин техник, төрийн өмчийн хэвлэл мэдээллийг ашиглах нь нэмэгдэж, төрийн албан хаагчдыг дайчлах явдал газар аваад байсан нь энэхүү мониторингийг санаачлах үндэслэл болсон юм.

ННФ-аас 2007 оны 12 дугаар сарын 12-нд зохион байгуулсан “Төрийн ил тод байдал: Шударга сонгууль” үндэсний форумын хуралдаан



2004 оны 4 дүгээр сарын 26-наас 6 дугаар сарын 27-ныг дүүстэл нийт 9 долоо хоног үргэлжилсэн мониторингийн явцад судлаачид 556 арга хэмжээнд ажиглалт хийсэн бөгөөд тухайн үед хараахан олон нийтийн болж шинэчлэгдээгүй байсан төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан сонгуулийн ил, далд сурталчилгааг нарийвчлан хянав. Ажиглалтын явцад төрийн өмчийн байрыг үнэгүй ашигласан тохиолдлын 80 хувь, төрийн унаа ашигласны 98 хувь, төрийн албан хаагчдыг дайчилсны 99 хувь нь эрх баригч намын арга хэмжээнд хамаарч байсныг баримтжуулан, ийм үйлдлийг хориглох зохицуулалт дутагдалтай байгааг хурцаар шүүмжилж байв. Сонгуулийн арга хэмжээнд урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийн үнэлгээг 3 тэрбум 157,7 сая гэж тооцоолсон нь анхаарал татна. Үүнээс гадна төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгуулийн сурталчилгаанд ашигласныг тооцоход 1,7 тэрбум хүрсэн байх ба үүний 96 хувь нь эрх баригч намд оногдож байгааг нотлон харуулж байжээ.

Энэхүү мониторинг нь төрийн эх үүсвэрийг сонгуульд ашиглахыг хориглосон заалтыг сонгуулийн хууль тогтоомжид тусгахад чухал нөлөө үзүүлсэн төдийгүй хэм хэмжээ болон өнөөг хүртэл үйлчилж байна. Түүнчлэн 2005 онд Олон нийтийн радио телевизийн

тухай хууль батлагдан 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн “төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэсэн чухал заалт “амилахад” дээрх мониторингийн үр дүн мөн түлхэц болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Сонгуулийн үр дүнгийн талаарх үнэн зөв мэдээлэл сонгогчдод шуурхай хүрэх нь сонгуулийн дүнг итгэж хүлээж авах урьдчилсан чухал нөхцөл болох тул 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг сонгогчдод шууд хүргэх студийг Eagle TV болон Транспэрэнси Интернэшнл байгууллагатай хамтран анх удаа ажиллуулав.

2008 оны Улсын Их Хурал (УИХ)-ын ээлжит сонгуулийн өмнөх чухал цаг үед төр засаг, иргэний нийгэм, улс төрийн намуудын төлөөлөл хамтран шударга сонгуулийн үндсэн нөхцөл болох ил тод байдлын талаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох нь чухал гэж үзэн ННФ-аас “Төрийн ил тод байдал: Шударга сонгууль” Үндэсний форумыг 2007 оны 12 дугаар сарын 12-нд зохион байгуулсан юм. Энэхүү форумд Улаанбаатар хот, орон нутгийн 200 гаруй төлөөлөгч оролцож, сонгуулийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин, үүнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, сонгуулийн үйл



явцад иргэний нийгмийн хяналт, сонгуулийн байгууллагын хараат бус байдал зэрэг сэдвээр санал бодлоо солилцон, хамтран зөвлөмж боловсруулсан юм.

Сонгуулийн эрх зүйн асуудлаар төр засаг, судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон ийм томоохон хэмжээний яриа мэтгэлцээн тун ховор байсан үед дээрх арга хэмжээ нь чухал ач холбогдолтой байсныг оролцогчид нь онцолж байсан билээ. Энэхүү Үндэсний форумд “Сонгуулийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин” сэдвээр тухайн үеийн УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Дондог, “Сонгуулийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт, баталгаа”-ны талаар Нээлттэй Академи ТББ-ын судлаач Г.Эрдэнэбат нар илтгэсний дээр Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ны ажлын албаны дарга Д.Баяндүүрэн сонгуулийн байгууллага болон сонгуулийн үйл явцын ил тод байдлын асуудал хууль тогтоомжид хэрхэн туссан талаар танилцуулан оролцож байв. Иргэний нийгмийг төлөөлөн Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож илтгэл тавьж сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах явцыг ажиглах эрх иргэний нийгмийн төлөөлөлд олгоогүй нь сонгуулийн ил тод

байдалд сөргөөр нөлөөлж байгааг шүүмжилж байв. Тус Үндэсний форумаас сонгуулийн үйл явцын ил тод байдлыг сайжруулахад зайлшгүй авч хэрэгжүүлэх хэд хэдэн арга хэмжээг тусгасан зөвлөмжид сонгуулийн хороод байгуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хянах боломж олгох, сонгуулийн компанит ажлын зардлыг ил болгох, саналын хуудасны нууцлал хамгааллыг сайжруулах; санал авах, санал тоолох, дүнг зарлах, саналын хуудсыг хүргэх үйл явцыг бүхэлд нь хянах бололцоог иргэний нийгмийн байгууллага, ажиглагчдад олгох; сонгуулийн дүнг нэгтгэж зарлахтай холбоотой сонгуулийн байгууллагуудын бүх шатны шийдвэр, протокол, бичиг баримтыг ажлын 5 хоногт багтааж олон нийтэд ил тод болгох, нэгтгэж хэвлэх, СЕХ-ны цахим хуудсанд нийтлэх зэрэг чухал саналуудыг тусгаж байв.

Үндэсний форумын үеэр яригдсан асуудлууд, гаргасан зөвлөмжөөс харахад сонгуулийг маргаан зөрчилгүй зохион байгуулах нь тухайн үед нэн тулгамдсан асуудал байсан ба эрх зүйн орчны шинэчлэл зайлшгүй шаардлагатай болсныг илтгэж байв. Гэвч зөвлөмжийн дагуу дорвитой өөрчлөлтүүд хийгдээгүй байсаар 2008 оны УИХ-ын сонгуультай золгов.

Үндэсний форумын зөвлөмжөөс...

- *Сонгуулийн хороодыг байгуулах орон нутгийн ИТХ-ын товыг нээлттэй зарлах;*
- *Хурлын протокол, шийдвэр, хэсгийн хороодын бүрэлдэхүүн, намын харьяаллын мэдээллийг нээлттэй зарлах;*
- *Нам, эвсэл, иргэний нийгмийн ажиглагчдад сонгогчдын нэрийн жагсаалтыг хянах боломж олгох;*
- *Компанит ажлын зардлыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд ерөнхийлөн гаргахын оронд цахимаар ил тод мэдээлэх;*
- *Саналын хуудасны хамгаалалт, нууцлалыг сайжруулж, хуулбарлах боломжгүй болгох, хэвлэлт, хүргэлтийг хянах, гарын үсэг зурж тэмдэг дарах.*

2008 оны 3 дугаар сард зохион байгуулсан “Ардчилсан сонгууль: Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт олон улсын бага хурал иргэний нийгмийн хяналт нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хамгаалахад нэн чухал болохыг онцлон хэлэлцсэн юм.

ННФ “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн эвсэл”-тэй хамтран 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр сонгуулийн кампанит ажил, хэвлэл мэдээлэл, сонгуулийн хороодын үйл ажиллагааны ил тод байдал, сонгогчдын нэрийн жагсаалтын аудит, саналын хуудас хэвлэх, хадгалах, хамгаалах, ашиглах процессыг хянах ажлыг зохион байгуулсны дээр 19-77 дугаартай шууд утас ажиллуулж, санал өгөх асуудлаар сонгогчдод мэдээлэл зөвлөгөө өгч ажиллав.


Хэдийгээр сонгуулийн өдөр санал хураах, дүн гаргах үйл явцад хөндлөнгийн бие даасан хяналт тавих боломжгүй, сонгогчдын нэрийн жагсаалт хаалттай, намын төлөөллөөс бүрдсэн сонгуулийн хороодын эсэргүүцэлтэй алхам тутамдаа тулгарсан амаргүй нөхцөлд иргэний нийгмийн байгууллагууд ажилласан ч сонгох эрхийн манаанд зогсох үүргээ амжилттай биелүүлсэн билээ.

2008 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 116568 сонгогч 432149 хаяг дээр давхар бүртгэгдсэн байгааг эрх бүхий байгууллагууд мэдээлээд байв. СЕХ-той харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар сонгуульд хамгийн их маргаан дагуулсан асуудлын нэг болоод байсан сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэгчилсэн мониторинг хийсэн нь мөн л анхных байв.

Сонгогчдын нэрийн жагсаалтын хяналтыг 10 үндсэн судлаач, 60 сайн дурын ажилтан оролцсон баг гүйцэтгэсэн бөгөөд 22 дугаар тойргийн 30 хорооны 47354 иргэний хаягийг тулгаж шалгахад бүртгэлтэй хаяг дээрээ ердөө 15411 сонгогч байгааг тогтоосон байдаг. Мониторингийн тайланд дурдсан мэдээллийг сөхөн үзвэл “Хилийн цэргийн дээд сургуулийн дотуур байранд 417 хүн, Баянзүрх дүүргийн 2 дугаар хороонд Цахим дээд сургуулийн дотуур байранд амьдардаг гэж 213 хүн бүртгэгдсэн байсан бөгөөд эдгээр хаягийн дагуу очиж тулгалт хийхэд “Цахим дээд сургууль огт дотуур байргүй, Хилийн цэргийн дээд сургууль нь бараг арваад жилийн өмнө Толгойт руу нүүсэн, сонсогчдын байр нь тус хороонд байдаггүй” гэсэн баримт дурдсан нь анхаарал татна.

Зорилго, үнэт зүйл нэгтэй төрийн бус байгууллагуудыг нэгтгэсэн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн эвсэл” 2008 оны 5 дугаар сард байгуулагдсан нь өнөөг хүртэлх бүх сонгуульд хяналт тавьж ирлээ.

УИХ-ын 2008 оны сонгуулийн 22 дугаар тойргийн 30 хорооны сонгогчдын нэрийн жагсаалтын мониторингийн дүнгээс





Энэ мэт ноцтой асуудлуудыг тухай бүр мэдээлж байсан ч дорвитой арга хэмжээ авагдалгүй байсаар сонгуулийн өдөр ирэв. 2008 оны УИХ-ын сонгууль бол Монгол Улсын ардчиллын түүхэнд ихээхэн гашуун сургамж дагуулсан сонгууль болсон юм.

Сонгуулийн процессын эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг хөндсөн “Сонгуулийн үйл явцын эрх зүйн асуудал” сэдэвт Иргэний нийгмийн форумыг 2008 оны 12 дугаар сарын 11-нд зохион байгуулав. Үүний дараа сонгуулийн процессын ил тод шударга байдлыг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох, сонгуулийн үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нарийвчилсан зөвлөмж гарган, бодлого боловсруулагчдад хүргэх, олон нийтээр хэлэлцүүлж, мэдээлэл өгөх ажлыг шат дараатай зохион байгуулан ажиллалаа. Үүний үр дүнд:

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг боловсронгуй болгох, алдаа шалгах аргуудыг нэвтрүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх өөрчлөлт хуульд тусав.
- Иргэний нийгмийн байгууллагууд сонгууль ажиглаж мониторинг хийх эрхийг хуульд тусган баталгаажуулав.

- Сонгуулийн саналын хуудасны нууцлал, хамгаалалт, аюулгүй байдал эрс сайжрав.
- Сонгуулийн автоматжуулсан систем нэвтрүүлэн, сонгуулийн үр дүнг хэд хэдэн аргаар давхар хянаж тулгах боломжтой байдлаар эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд хичээн ажиллав.

2012 оны УИХ-ын сонгуульд залуучуудын оролцоог хангаж, сонгуулийн талаарх тэдний мэдлэгийг нэмэгдүүлэх, ажиглагч хийх замаар сонгуулийн эрхээ хамгаалахад нь бодитоор тусалж, 200 гаруй сайн дурын залуусыг сурган, сонгуульд ажиглагчаар ажиллуулав. Ажиглагчдын сургалт нь Филиппин Улсын 1970-аад оноос эхлэлтэй НАМФРЕЛ байгууллагын туршлагатай мэргэжилтнүүд заасныг нутагшуулж сайжруулсан хувилбараар явагдсаар өнөөг хүрлээ. 2012-2024 оныг хүртэл УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд залуусыг сурган ажиглалт хийх ажлыг Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд, Бодлогод залуусын хяналт зэрэг ТББ-уудтай хамтран зохион байгуулж ирсэн бөгөөд эдүгээ 1400 орчим залуусыг сурган ажиглагчаар ажиллууллаа.

Сонгуулийн маргаанаас сэргийлэхэд сонгуулийн

автоматжуулалтын мониторинг, сонгуулийн санхүүжилтийн мониторинг, сонгогчдын нэрийн жагсаалтын хяналт, сонгуулийн тэгш гарааны чухал үзүүлэлт болох хэвлэл мэдээллийн мониторинг зэрэг нь тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн гэж найдаж байна.

Мөн энэ хугацаанд дээрх асуудлуудын хүрээнд сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чамлахааргүй өөрчлөлтүүд гарав. Үүнд, сонгуулийн зардлын тайланг гаргах журам, төрийн аудитын зүгээс хянаж дүгнэлт гаргах процесс нарийсаж, мэдээллийн илтөд байдалд ахиц гарлаа. Хэвлэл мэдээллийн мониторингийн үр дүнд үндэслэн сонгуулийн зардлын тайлангийн үнэн зөв

байдалд ерөнхий дүн шинжилгээ хийх, мөнхүү өрсөлдөөний гараа тэгш бус байсаар байгааг шүүмжлэн засаж сайжруулах санал боловсруулан ажиллаж байна.

Техник технологийн хөгжилтэй уялдан нийгмийн сүлжээг сонгуулийн зорилгоор ашиглах нь 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш эрс нэмэгдэв. Энэ нь нэг талаас сонгогчдод мэдээлэл хүргэх хямд төсөр, хурдан шуурхай хэрэгсэл боловч нөгөө талаас хуурмаг ташаа мэдээлэл сонгогчдыг төөрөгдүүлэх, саналд нөлөөлөх эрсдэл дагуулдаг. Иргэний нийгмийн зүгээс үүнд хяналт тавьж, хуурамч мэдээлэл тархах аваас баримтаар нягтлан, сонгогчдод шуурхай мэдээлж ажиллах нь ач холбогдолтой тул

2020, 2021 оны УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвд дэмжлэг үзүүлэн нийгмийн сүлжээний мониторинг хийсэн нь бүс нутагтаа анхдагч жишээ болов.

Манай улс ардчиллын замыг тууштай сонгон бэхжүүлэхээр хичээнгүйлэн чармайсан гуч гаруй жилийн хугацаанд сонгуулийн үйл явц улс төрийн институциудын хөгжил, төлөвшил, төрийн чадавх, нөөц, техник технологийн хөгжил гэх мэт олон хүчин зүйлээс хамааран хувьсан шинэчлэгдсээр ирсэн бөгөөд ННФ бусад иргэний нийгмийн байгууллагатай хамтран сонгох, сонгогдох эрхийн манаанд тууштай зогсож, шинэчлэлд хувь нэмрээ оруулахын төлөө ийнхүү тасралтгүй ажиллаж ирлээ.

2020 оны УИХ-ын сонгуулийн иргэний нийгмийн ажиглагчид



Ардчиллын институциуд

Дэлхий даяар ардчиллын давлагаа эрчимтэй өрнөсөн 1990-ээд оны эхээр олон улс орон ардчиллын замаар замнаж эхэлсний нэг нь Монгол Улс билээ. Харин сүүлийн арав гаруй жилийн хугацаанд ардчиллаас ухрах хандлага олон улсад газар авч буй бөгөөд үүний зарим нөлөө ч мөн биднийг тойрсонгүй. Энэ ээдрээтэй цаг үед ННФ-аас ардчиллын институциудыг бэхжүүлэх асуудлыг чухал зорилго болгон ажиллаж байна.

Ардчиллын үхралтаас сэргийлэх, саармагжуулж зогсооход Үндсэн хуульт байгууллын цөм болох эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах, хүний эрх болон нийтийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий институциуд чухал нөлөөтэй билээ. ННФ-ын зүгээс парламент дахь цөөнхийн асуудал, улс төрийн намын шинэчлэл, төрийн аудит, хүний эрхийн комисс болон үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, цуврал хэлэлцүүлэг зохион байгуулах, эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж боловсруулах, хуулийг шинэчлэх явцад техникийн туслалцаа үзүүлэх гэх зэрэг ажлыг зохион байгуулж ирлээ.

Бид ардчиллын институциудыг бэхжүүлэх зорилгын хүрээнд юуны түрүүнд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах асуудалд анхаарал хандуулж, 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад гадаад, дотоодын эрдэмтэн судлаач, олон улсын байгууллагуудын болон дотоодын мэргэжилтнүүдийг татан оролцуулж, шаардлагатай

техникийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ хуулийн төслийг боловсруулах Ажлын дэд хэсэгт багтаж ажиллав. Тухайлбал, 2018-2019 онд Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнтэй хамтран Европын Холбооны дэмжлэгээр “Улс төрийн санхүүжилт: ёс зүй, оролцоо, хариуцлага” төсөл хэрэгжүүлсэн ба “Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: дүн шинжилгээ санал зөвлөмж” сэдэвт суурь судалгааг хийж, сонгууль, улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоонд нэн түрүүнд тулгамдаж байгаа, зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлууд болон тэдгээрийг олон улсын стандартуудад нийцүүлэн хэрхэн засаж залруулах талаар тодорхой саналууд боловсруулж тусгав. Улс төрийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэхэд оролцогч талуудын дунд, ялангуяа улс төрийн намуудын дунд зөвшилцөл бий болох нь чухал тул улс төрийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөхөд нэн тэргүүний гэж үзсэн тодорхой асуудлуудаар намуудын төлөөллийг оролцуулан тогтмол хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээллээр хангах, нөгөө талаар тэдний байр суурийг сонсон, санал солилцох боломж олгох ажлыг шат дараалалтай хийв. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Ардчиллыг хуулиар бэхжүүлэх Европын комисс (Венецийн комисс), Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагуудаас санал дүгнэлт авах ажлыг мөн зохион байгууллаа.

2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуульд улс төрийн санхүүжилтийн хяналт, ил тод байдлыг

сайжруулах асуудлаар нарийвчилсан зохицуулалтууд багтаж, намууд санхүүгийн тайлангаа хэзээ, ямар хэлбэрээр олон нийтэд танилцуулах, төрийн зүгээс хэрхэн хяналт тавих, хууль зөрчсөн нөхцөлд ямар хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлыг тусгасан нь цаашид улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөөллийг бууруулж арилгах, улс төрийн намууд төлөвшин хөгжихөд тус нэмэр болно гэж найдаж байна.

Үндсэн хуульт ардчиллын тулгуур институт болох Үндсэн хуулийн цэцийн шинэчлэлийн асуудлыг 2020-2024 онд ажилласан парламентын үеэс нэлээд нухацтай хэлэлцэх боллоо. Үүнд Цэцийн бүрэлдэхүүний хараат бус байдлыг нэмэгдүүлэх, Цэцийн гишүүдийг сонгож, томилох процессыг ил тод, боловсронгуй болгох, Цэцийн гишүүнд тавигдах ёс зүйн болон мэргэжлийн шалгуурыг нарийвчлах шаардлага байгааг онцлох болсон. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 1992 онд баталсан бол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг 1997 онд баталснаас хойш дорвитой өөрчлөлт тусалгүй өнөөг хүрчээ.

ННФ-ын зүгээс энэ асуудлаарх бодлогын мэтгэлцээнийг бүтээлч байдлаар өрнөхөд мэдээлэл болгох үүднээс үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн олон улсын туршлагыг нэгтгэсэн “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгаануудын эмхэтгэл” бүтээлийг МУИС-ын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран Монгол хэлнээ хөрвүүлээд байна. Түүнчлэн үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал болон үндсэн

хуулийн процессын эрх зүйн асуудлаар бүс нутагтаа жишээ болохуйц сайн туршлагад тооцогддог Өмнөд Солонгос Улсын Үндсэн хуулийн шүүхээс туршлага судлах ажлыг Үндсэн хуулийн цэц болон УИХ-тай хамтран 2023 оны 4 дүгээр сард зохион байгууллаа. УИХ-аас боловсруулсан Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөл Венецийн комиссын гаргасан болон олон улсын бусад стандарт, сайн туршлагад нийцэх байдалд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулахад холбогдох олон улсын байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Монгол Улсад хүний эрхийг сахин хамгаалахад ХЭҮК-ын гүйцэтгэх үүрэг оролцоо нэн чухал билээ. Тус байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход идэвхийлэн оролцож, 2020 онд шинэчлэн найруулж батлуулсан ХЭҮК-ын тухай хуулийн дагуу комиссын шинэ гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулж, томилох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, сонгон шалгаруулалтын Ажлын хэсэгт орж ажиллалаа. Уг үйл ажиллагаа манай улсад томилгооны сонсголын эхлэлийг тавьсан чухал алхам байв.

ННФ-аас цаашид хяналтын хараат бус институциудын томилгооны асуудалд онцгойлон анхаарч, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг сайжруулах, нээлттэй сонсгол зохион байгуулахад оролцох, дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд бие даасан судлаач, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран идэвхийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Мэдээллийн ил тод байдал

Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг

Нээлттэй нийгэм нь мэдээллийн чөлөөт урсгал, олон ургалч үзэл, мэтгэлцээн, шүүмжлэл өрнөх иргэний орон зайгүйгээр оршин тогтнох боломжгүй.

Эрх зүйн орчны шинэчлэлийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ардчилсан Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн мэдээлэл авах эрхийг баттай хангах явдал юм. Манай улсад 1990-2000 оны дунд үе хүртэл шийдвэр гаргагчдын зүгээс мэдээлэл авах эрхийн асуудлыг хэвлэлийн эрх чөлөөний асуудалтай хутган ойлгох, мэдээллийг нууцалж ирсэн социализмын үеэс уламжлалтай соёлын нөлөө хүчтэй хэвээр, мэдээллийг ил болгохоос болгоомжлох, цааргалах хандлага зонхилж байсан нь шинэчлэлийн гол саад байв. 2005 онд ННФ болон Глоб Интернэшнл Төв ТББ Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн анхны төсөл боловсруулах УИХ-ын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан ба 2007 онд тус хуулийн хоёр дахь төслийг боловсруулах ажлын хэсэгт мөн оролцов. Засгийн газар хуулийн төслийг хэлэлцээд хоёр удаа буцаасан нь төрийн мэдэлд байгаа мэдээллийг ил тод болгох улс төрийн хүсэл зориг дутмаг байсны илрэл агаад үүнийгээ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэр байхгүй, мэдээллийн аюулгүй байдлын асуудалтай хамтад нь авч үзэх шаардлагатай гэх зэргээр тайлбарлаж байв.

ННФ-аас Глоб Интернэшнл Төв тэргүүтэй энэ асуудлаар мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран удаа дараа хэлэлцүүлэг зохион байгуулах, мониторинг хийхэд дэмжлэг үзүүлэх, бодлого боловсруулагчдад зөвлөмж хүргүүлэх гэх зэргээр тасралтгүй ажилласны дүнд УИХ-аас 2011 оны 6 дугаар сард Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан нь төрийн ил тод байдлын эрх зүйн үндсийг тавьж Үндсэн хуульд заасан иргэдийн мэдээлэл авах үндсэн эрхийг бататгасан томоохон өөрчлөлт дэвшил болсон юм. Хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн төрийн бус байгууллагуудын оролцоотой мониторинг хийж, хийдэл гаргасан төрийн байгууллагуудад шаардлага мэдээлэл хүргүүлэх ажлыг мөн санаачлан гүйцэтгэв.

ННФ-ын энэ чиглэлээрх ажил одоо ч үргэлжилсээр байгаа бөгөөд нууцын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн эрин үед нээлттэй өгөгдлийн стандартыг нэвтрүүлэхэд төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрөөс ил болгосон мэдээллийн сангуудыг холбон хайлт хийх боломжтой нэгдсэн сан үүсгэх замаар сонирхлын зөрчил, нийтийн баялгийн зарцуулалтад сэтгүүлчид болон иргэд хяналт тавих нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Хэвлэл мэдээллийн салбарт 2005 онд шинэлэг үйл явдал тохиолдсон нь Монголын Үндэсний Радио, Телевизийг олон нийтийн болгох эрх зүйн орчин бүрдэв. Олон нийтийн радио телевиз (ОНРТ)-ийн тухай хуулийг боловсруулахад ННФ анхнаас нь идэвхтэй оролцож хэрэгжилтийг зохион байгуулахад мөн дэмжлэг үзүүлж ажиллав. ОНРТ-ийн удирдлагууд, шинэ тутам байгуулагдсан Үндэсний зөвлөлийн гишүүдийг мэдээлэл, арга зүйгээр хангах цуврал арга хэмжээг зохион байгуулсны нэг нь Швейцарийн Өргөн Нэвтрүүлгийн Корпорацын ерөнхий захирал асан Антонио Рива тэргүүтэй мэргэжилтнүүдийг урин авчирч мэдээлэл болон агуулгын чанар, ёс зүй, хараат бус байдал, удирдлагын ил тод байдал гэх мэт сэдвүүдээр зөвлөгөө өгөн хуулийн хүрээнд

батлан хэрэгжүүлэх ёстой Ерөнхий захирлын гэрээ, ёс зүйн дүрэм зэрэг баримт бичгийг боловсруулахад туслалцаа үзүүлсэн явдал байв. Үүний дараа шилжилтийн үеийн нэвтрүүлгийн агуулгад хөндлөнгийн бие даасан байгууллагууд мониторинг хийх ажлыг санаачлан, арга зүйг боловсруулах, мониторинг хийх дэмжлэгийг Монголын Хэвлэлийн Хүрээлэнд үзүүллээ.

2004-2005 онд хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын талаар судалгаа хийх, ийм байгууллагын ач холбогдлыг сурталчлах, загвар жишиг болгох ажлыг Глоб Интернэшнл Төв ТББ-тай хамтран зохион байгуулж Хэвлэлийн цэц байгуулах, ёс зүйн дүрмийг нь боловсруулах ажлыг эхлүүлж байв.

ОНРТ-ийн тухай хууль батлагдсаны дараах хэвлэлийн бага хурлын үеийн сурвалжилга



Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийн талаарх мэдээллийг олон улсын сүлжээ болон олон нийтэд байнга шуурхай мэдээлэх, тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх ажилд байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөг хүртэл дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

2019 оны сүүлээс эхлэн Ковид-19 халдварын тархалт дэлхий нийтийг түгшээн хүн амын эрүүл мэндээс гадна нийгэм, улс төр, эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлсэн билээ. Энэ хугацаанд төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн янз бүрийн хэлбэрийн хөл хорио, хязгаарлалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтэд хүндээр тусаж сөргөөр нөлөөлсөн нь цар тахлын дараа ч бүрэн арилахгүй байгааг судлаачид шүүмжлэн хэлэлцсээр байна. ННФ-аас 2019-2024 онд Глоб Интернэшнл Төв ТББ-д иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, сэтгүүлчдийн ажил үүргээ хараат бусаар гүйцэтгэхэд нь эрх зүй, мэргэжлийн дэмжлэг үзүүлж, аюулгүй байдлыг хамгаалахад нь туслах зорилгоор олгосон тэтгэлгийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудлаар нийт 1889 хүн оролцсон 45 удаагийн шүүмжлэлт хэлэлцүүлэг, сэтгүүлчдэд эрхийнх нь талаар мэдээлэл өгөх, үр чадварыг нь дээшлүүлэх 26 удаагийн цахим

болон танхимын сургалт зохион байгуулсан ба 50 гаруй сэтгүүлчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 200 орчим сэтгүүлчид хуулийн зөвлөгөө өгчээ. Түүнчлэн сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийг бүртгэх олон улсын сүлжээнд 12 шуурхай мэдээллийг хүргэж ажилласан байна.

2024 онд Монгол Улсын Засгийн газраас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулсан төслийг боловсруулан УИХ-аар хэлэлцэхээр бэлтгэж байна. 1998 онд батлагдсан анхны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд туссан чухал зарчмуудыг шинэ хуульд алдагдуулалгүй тусгах, сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа халдлага сүрдүүлэгт өртөх, мэдээний эх сурвалжаа хамгаалахад хүндрэл учрах, санхүүжилтийн тогтолцоо болон эрх зүйн орчны дутмаг байдлаас үүдэлтэй сэтгүүлч, редакц нь төрийн болон эздийн нөлөөнөөс хараат бусаар ажиллах нөхцөл бүрдээгүй байж ирсэн гэх мэт хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй асуудлуудыг оновчтой шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмж, хуулийн шүүмжийг ННФ-аас нийтлэн бодлого боловсруулагчдад хүргүүлэн ажиллаж байна.

ОНРТ-ийн олон нийтийн арга хэмжээний үеэрх сурвалжлага



Хүний эрхийг хамгаалахад иргэний нийгмийн оролцоо

Ардчиллын суурь зарчим болох хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэдэг нийгмийг төлөвшүүлэх үйлсэд ННФ ямагт анхаарч, хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн бөгөөд хамгийн эхэн үеийн ажлуудын нэг нь төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа юм. Хэрэг төвөгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэд хүний эрхээ эдлэн эрх зүйн туслалцаа авдаг тогтолцоо бий болгохоор зорьж ажилласан нь үр дүнгээ өгч 2006 онд Засгийн газраас “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан билээ (дэлгэрэнгүй мэдээллийг Эрх зүйн туслалцаа хэсгээс үзнэ үү). Энэ үеэс хойш бид иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтран хүний эрхийн мэдлэг, мэдээлэл түгээх, эрх хамгаалах үндэсний механизм бүрдүүлэх чиглэлд НҮБ-ын хүний эрхийн хороод, Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) зэрэг байгууллагуудтай нягт холбоотой ажиллаж ирлээ.

УИХ-ын 2008 оны сонгуулийн дүнд эргэлзсэн байж болох олон хүн нэгдэн эсэргүүцлээ илэрхийлж, төв талбайд цугларснаар сүүлдээ эмх замбараагүй үймээн, улмаар мөргөлдөөнд хүргэж, Монгол Улсад анх удаа онц байдал зарлаж, эцсийн дүндээ таван хүн амь үрэгдэж, олон иргэн, хууль сахиулагчид гэмтэж бэртэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хохирол үүссэний зэрэгцээ олон зуун иргэн саатуулагдан шүүхээс ял сонссон билээ. 7 сарын 1-ний хэрэг явдал гэж нэрлэгдэх болсон энэ цаг үеэр иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа хүний эрхийн байгууллагууд эвлэлдэн нэгдэж иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, цагдаагийн байгууллагаас гаргаж буй хүний эрхийн зөрчлийг зогсоох, баримтжуулах, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх зэргээр ажиллав. Цагдаагийн байгууллагаас 700 гаруй

иргэнийг хоморголон баривчилж хорьсон явдлыг эрс буруушаан хохирогч иргэдийн мэдээлэл, аудио, видео, фото баримтыг цаг алдалгүй цуглуулан баримтжуулж УИХ, Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн юм. Улмаар 2009 онд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос зохион байгуулсан “Долдугаар сарын 1 – Хүний эрхийн зөрчил” хяналтын нээлттэй сонголд иргэний нийгмийн эвслийн гишүүд оролцон мэдээлэл хийв. ННФ нь ийнхүү хүний эрхийн зөрчлийн мониторинг, баримтжуулалтын ажилд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ баривчлагдсан төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчдийн багийг санхүүжүүлж 60 гаруй иргэнд өмгөөллийн үйлчилгээг бүрэн үзүүлсэн билээ. Энэхүү үйл явц нь хүний эрхийн зөрчлийг дахин давтагдахгүй байхад томоохон түлхэц болохын зэрэгцээ хүний эрхийн байгууллагуудад олон улсын механизмыг үр дүнтэйгээр ашиглах чухал туршлага, мэдлэг болж чадсан юм.

Онц байдлын үеэр байгуулагдсан эвсэл нь өнөөдөр Монголын Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум (Хүний эрхийн форум) болон үйл ажиллагаа нь өргөжин тэлж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн чухал институт болон төлөвшөөд байна. Хүний эрхийн форум нь НҮБ-ын хүний эрхийн механизмыг үр дүнтэй ашиглах замаар дотоодын хүний эрхийн хэрэгжилтэд ахиц гаргахыг зорин ажиллаж, энэ хүрээнд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэх механизмд 2010, 2015, 2020 онд тус тус оролцож, 30 орчим мэдээлэл хүргүүлж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.





Тэрчлэн НҮБ-ын Хүний эрхийн болон Эрүүдэн шүүхийн эсрэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн болон Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хороодод илтгэл, мэдээлэл илгээж, НҮБ-ын хүний эрхийн тодорхой асуудлаарх Тусгай илтгэгч, Ажлын хэсэг зэрэг механизмтай хамтран ажиллах чиглэлээр тодорхой туршлага хуримтлуулсан билээ. Энэ үйл явцад ННФ төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн бөгөөд Ядуурал ба хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Магдалена Сепулведа (2013), Хүрээлэн буй орчин, хүний эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Жон Нокс (2017), Хүний эрхийн хамгаалагчийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Мишель Форст (2019), Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт (2023) нарын айлчлалын үеэр мэдээлэл илгээж, уулзалт зохион байгуулав.

Хүний эрхийн форум нь хүний эрхийн тулгамдсан асуудалд анхаарал хандуулж, хамтарсан нөлөөлөл хийж хэвшлээ. Тухайлбал, хүний эрхийг хамгаалах, зөрчлөөс сэргийлэхэд чухал ач холбогдолтой Прокурорын мөрдөн байцаах алба, Тахарын алба зэргийг татан буулгахтай холбоотой асуудлаар эсэргүүцэл илэрхийлэх, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын хараат бус, бие даасан байдлын талаар санал зөвлөмж, нээлттэй захидал хүргүүлэх, ХЭҮК-ын хуулийг шинэчлэх болон хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах шинэ эрх зүйн орчин бий болгох, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ухралтаас сэргийлэх зэрэг олон асуудлаар нэгдсэн байр суурь илэрхийлж нөлөөллийн хүчтэй дуу хоолой болж ажиллав.

Хүний эрхийн форум хүний эрхийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн институт болсны нэг илэрхийлэл бол *UPR Info* Олон улсын ТББ-аас өөрийн хэвлэн нийтлэлд Монголын Хүний эрхийн форумын түршлагыг онцлон дурдсан явдал юм. ННФ нь хүний эрхийн салбарт Хүний эрхийн форумын гүйцэтгэх үүргийг онцлон авч үзэж чадавхыг нь бэхжүүлж, нөлөөлөл, хамгааллын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд 2022 оноос Хүний эрхийн форум бие даан ажиллах боллоо.

Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төр, төрийн бус байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, төрөл бүрийн үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлсний дотор 10 гаруй жил үргэлжилсэн хүний

эрхийн цуврал лекц, цаг үеийн халуун сэдвээр өрнүүлдэг “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний үулзалт, ярилцлага, залуучуудын сонирхлыг их татах болсон “Хүний эрхийн кино хэлэлцүүлэг” зэрэг нь олон нийтэд хүний эрхийн тухай мэдлэг, мэдээлэл түгээх чухал хэрэгслүүд байв. Түүнчлэн урлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол, мэдлэг түгээх шинэ хэлбэрийг дэлгэрүүлэхийг чухалчилж “Театр хүний эрхийн төлөө” санаачилга гарган Глоб интернэшнл Төв ТББ-ын анх санаачилсан “тавилттай уншлага” хэмээх үзвэрийн шинэлэг төрлөөр хэд хэдэн жүжиг улсын болон аймаг орон нутгийн театруудад тавигдсан нь үзэгчдийн анхаарлыг хүний эрхэд хандуулах, эрхийн тухай боловсрол, мэдлэгийг

бодитой, энгийн ойлгомжтой хүргэхэд зохих хувь нэмэр орууллаа. Энэхүү санаачилгын хүрээнд зохиолч, уран бүтээлч, иргэний нийгмийн төлөөллийг хүний эрхийн сэдвээр жүжгийн зохиол бичих сургалтад хамруулах, шилдэг бүтээл шалгаруулах, тайзнаа тавихад нь дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Жил бүрийн 12 дугаар сарын 10 буюу олон улсын Хүний эрхийн өдрөөр олон нийтийг хамруулсан үйл ажиллагааг тогтмол дэмжиж, Хүний эрхийн форумтай хамтран “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” өдөрлөг, хүний эрхийн “Мэдээллийн зах” арга хэмжээ, “Эрхээ шаардъя” сарын аян зэрэг арга хэмжээг давтамжтай зохион байгуулж ирлээ.

“Театр хүний эрхийн төлөө” санаачилгын нээлтийн арга хэмжээ (2015 он)





**ХАРИУЦЛАГАТАЙ,
ИЛ ТОД ТӨР**

Төрийн хариуцлагын механизмууд

УИХ-ын 2004 оны сонгуулиар улс төрийн томоохон хүчнүүд тэнцвэртэй төлөөлөлтэй болсноор Их эвслийн Засгийн газар байгуулагдаж, Монголын нийгэмд ужгирсан, улс орны хөгжилд чөдөр тушаа болсон олон асуудлыг төр засгийн түвшинд хөндөж, хүлээн зөвшөөрсний нэг нь авлига хээл хахуулын хэрэг газар авсан явдал байлаа. УИХ-аас 2005 онд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцыг соёрхон баталж, улмаар 2006 онд удтал хэлэлцсэний эцэст Авлигын эсрэг хуулийг батлан гаргав. Бие даасан иргэний нийгмийн байгууллага болж үйл ажиллагаагаа дөнгөж эхлүүлээд байсан ННФ-ын зүгээс авлигын эсрэг анхны хуульд авлигаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдол бүхий ашиг сонирхлын зөрчлийн болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх зохицуулалтуудыг тусгахад хүчин чармайлт гарган ажилласан билээ.

Манай улсад сонирхлын зөрчлийн асуудал нь 2000 оны эхээр харьцангуй шинэ ойлголт байлаа. Хуулийн төсөлд албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хувь хүний нууцад хамааруулан Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулах, зөвхөн нийт хөрөнгө болон орлогын ерөнхий мэдээллийг л нээлттэй байхаар тусгасныг өөрчлөх нь бидний нөлөөллийн ажлын чухал зорилго байв. Энэ асуудлыг тусгайлан зохицуулсан хуультай Эстони, Литва, Латви зэрэг улсын туршлагыг судлан цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүхэлд нь нийтлэх, цахим хуудсанд байрлуулах зэргээр мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг

хангах зохицуулалт оруулахыг санал болгосон нь хуульд тусгалаа олж өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Хууль батлагдсаны дараа хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавих арга зүйн судалгааг дотоодын судлаачдын оролцоотой хийж гүйцэтгэсэн нь хуулийн хэрэгжилт, үр дүнд тодорхой хувь нэмэр болсон буй заа. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай бие даасан шинэ хууль 2012 оноос хүчин төгөлдөржиж эхэлсэн бөгөөд төрийн бус байгууллагуудын зүгээс энэхүү хуулийн хэрэгжилтэд мониторинг хийхэд нь бид арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллав.

Сонирхлын зөрчил, мөнгө угаах зэрэг албан тушаал, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох олон улсын стандарт, шаардлагыг Монгол Улсад нутагшуулан хэрэгжүүлэх, ялангуяа авлигын өндөр эрсдэл бүхий уул уурхайн салбарт эцсийн өмчлөгчийн тайлагналыг нэвтрүүлэхэд ННФ өөрийн судалгаа, нөлөөллийн ажлаараа тодорхой хувь нэмэр оруулсан билээ. Тэрчлэн эцсийн өмчлөгчийн мэдээллийг төрийн худалдан авалт, шилэн данс, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбон шинжилж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлийг олны сонорт хүргэсэн нь авлигын эсрэг олон нийтийн хяналтад төрийн нээлттэй мэдээллийг хэрхэн бүтээлчээр ашиглаж болохыг харуулж байна.

1990-ээд оноос өнөөг хүртэл Монгол Улс нийтийн эрх ашгийн өмнөөс төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын янз бүрийн загварыг туршин хэрэгжүүлсэн бөгөөд 2003 оноос Ерөнхий аудиторын загварыг сонгон хуульчилсан. ННФ-ын зүгээс одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиудад Ерөнхий аудиторыг томилох асуудлыг УИХ дахь олонх дангаар шийдэж болохоор зохицуулсныг шүүмжлэн, томилгоог хэрхэн зохицуулах нь зүйтэй талаар бодлогын судалгаа хийж, олон нийтийн хүртээл болгов. Үүний зэрэгцээ Үндэсний Аудитын Газар (ҮАГ)-тай 2018 онд санамж бичиг байгуулан аудитын дүгнэлт, зөвлөмжийн үр нөлөөг нэмэгдүүлэхийг зорьж, энэхүү мэдээллийн олон нийтэд хүрэх урсгалыг сайжруулах чиглэлд хамтран ажиллав.

Захиргааны ерөнхий хууль нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг анх удаа стандартчилж, иргэдийн оролцоог бодитоор баталгаажуулснаараа төрийн хариуцлагатай байдлыг сайжруулахад нэн чухал урьдчилсан нөхцөл болсон билээ. Бид энэ хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсэгт ажиллан, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах зохицуулалтыг хуульд

тусгуулахад хувь нэмэр оруулж ажиллав. Тэрчлэн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжийн дагуу мониторинг хийж, тодорхой санал зөвлөмж боловсруулан бодлогын хүрээнийхэн болон олон нийтэд хүргэлээ.

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэний нийгмийн оролцоо, хяналт нэн чухал үүрэгтэй билээ. Газрын доорх эрдэс баялгаа эрчимтэй ашиглах бодлого, нөхцөл бүрэлдэж, улмаар улсын төсвийн орлого урьд өмнө байгаагүйгээр нэмэгдэх нь тодорхой болж эхэлсэн 2004 онд ННФ төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад төрийн бүс байгууллагуудын зүгээс тавих хяналт, оролцоог бий болгохыг чухалчлан авч үзэв. Ардчилсан шинэ Үндсэн хуульд эвлэлдэн нэгдэх эрхийг тунхагласнаар 1990-ээс 2000 оныг хүртэл төрийн бүс байгууллагын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байсан хэдий ч үйл ажиллагаа нь гол төлөв нийгмийн эмзэг бүлэгт үйлчлэх, соён гэгээрүүлэхэд чиглэж байснаас төрийн эрх мэдлийг хянах, нийтийн эрх ашгийг хамгаалан хариуцлага шаардах хэмжээнд

2018 онд ННФ-ын ҮАГ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитад анх удаа иргэний нийгмийн шинжээчид оролцов.

иргэний нийгмийн чухал үүрэг гүйцэтгэх чадавх хангалттай бүрдээгүй байв. Төрийн зүгээс ч иргэний нийгмийн хяналт тавих үүргийг хүлээн зөвшөөрч оролцоог нь дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлээгүй үе байв.

ННФ-аас 2004-2014 онд хэрэгжүүлсэн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагууд газар олголт, гаалийн үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, төсвийн зарцуулалт гэх мэт нийгэм, эдийн засгийн олон асуудлаар нийт 200 орчим мониторинг хийв. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих арга зүйн анхны гарын авлага гарган, улмаар мониторинг хийх, тайлан бичих, мониторингийнхоо үр дүнд үндэслэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах сургалтын цогц хөтөлбөр боловсруулсан юм. Тус хөтөлбөр, арга зүйн дагуу нийслэл болон 21 аймагт ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулан сургалт зохион байгуулсан нь төрийн бус байгууллагуудын төрд хяналт тавих чадавхыг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулав.

УИХ-ын 2008 оны сонгуулиар хяналт тавих төрийн бус байгууллагуудтай СЕХ санамж бичигт гарын үсэг зурж буй нь

Ийнхүү төрийн байгууллагын үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар төрийн бус байгууллагууд дагнан хяналт тавих болсноор Мэдээллийн ил тод байдлын тухай анхны хууль батлагдаж, бодлого боловсруулах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан саналыг нь авах зэрэг иргэний нийгмийн оролцоог дэмжсэн эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн билээ. Иймээс ННФ 2011 онд төрийн бус байгууллагуудад зориулсан тусгай тэтгэлэгт хөтөлбөрөө өөрчлөн шинэчилж, манай хөтөлбөрүүдийн хүрээнд төрөлжсөн эвсэл болж хүчээ нэгтгэн хамтарч ажиллахад нь түлхэц үзүүлэн дэмжиж ирсэн бөгөөд төрийн бус байгууллагуудын мониторинг нь өнөөг хүртэл ННФ-ын үйл ажиллагааны нэг чухал арга хэрэгсэл хэвээр байна. Ардчиллын гуч гаруй жилийн хөгжлийг судалсан олон улс төрч, эрдэмтэд ч Монголын иргэний нийгэм нь идэвхтэй бөгөөд нөлөөллийн чухал үүрэг гүйцэтгэж ирснийг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэхүү дүгнэлт нь нийтийн эрх ашгийн өмнөөс төрд хяналт тавих төрийн бус байгууллагуудын оролцоо нь ихээхэн нөлөөтэйг илтгэж буй юм.

Ерөнхий аудиторын томилгоог ил тод, хараат бусаар зохион байгуулах асуудлаар зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр (2024 он)



Зураг дээр СЕХ-ны дарга Б.Баттулга, дэд дарга Б.Баярсайхан, Глоб Интернэшнл Төвийн тэргүүн Х.Наранжаргал, Хүний эрх хөгжил төвийн гүйцэтгэх захирал Г.Уранцэцэг, Филантропи хөгжлийн төлөө төв ТББ-ын судлаач Г.Мөнхцэцэг, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг



Төсвийн ил тод, хариуцлагатай байдал

Улсын төсөв нь Засгийн газраас дэвшүүлсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн чухал баримт бичиг бөгөөд төсвийн дийлэнх хэсэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлсөн татвараар бүрдэхийн учир иргэд төсвийн төлөвлөлтөд оролцож, гүйцэтгэлд хяналт тавих эрхтэй. ННФ байгуулагдсан үеэсээ эхлэн төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх чиглэлд иргэний нийгмийн байгууллагууд болон

Төсвийн ил тод байдал

Төсвийн ил тод байдал болон төсөвт иргэдийн оролцоо сул байсан 2000-аад оны дунд үеэс бид төсвийн мэдээллийг нээлттэй болгох, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд бодлого боловсруулагчдын анхаарлыг хандуулж эхлэв. Тухайлбал, “Төсвийн үйл явц ба 2004 оны төсвийн хэлэлцүүлэг” сэдэвт форумыг 2004 онд зохион

эдийн засагч судлаачидтай хамтран тасралтгүй 20 жил ажилласны дүнд төсвийн ил тод байдал, зарцуулалтад мониторинг хийхээс эхлээд төсвийн орлогын тооцоолол, зардалд дүн шинжилгээ хийн тодорхой санал зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагчдад хүргэх, улмаар бодлогын баримт бичгүүдэд тусгахад нөлөө үзүүлэх хэмжээний чадавх, туршлага хуримтлуулжээ.

байгуулж байсан бол 2006 онд “Төрийн ил тод байдал” сэдэвт үндэсний форум зохион байгуулан төсвийн асуудлыг онцгойлон авч хэлэлцүүлсэн билээ. УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчид, иргэний нийгмийн болон донор байгууллагын төлөөлөл оролцсон эдгээр хэлэлцүүлгийн үеэр иргэдийг төсвийн мэдээллээр хангахад төрийн хүлээх үүрэг

Дорнод аймагт зохион байгуулагдсан төсвийн хяналтын сонголын явцаас (2018 он)

Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан ТББ-ын Багануур дүүрэгт өрнүүлсэн "Шилэн түрийвч" аяны үйл ажиллагааны үеэр иргэд төсвийн мэдээлэлтэй танилцаж буй нь (2005 он)



www.forum.mn цахим хуудсанд "Төсвийн ажиглагч" булан нээж, 2005 онд анх удаа улсын төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлийг бүрэн эхээр нь нийтлэв.

хариуцлага тодорхойгүй, төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал хангалтгүй, төсвийн төлөвлөлтөд оролцох, гүйцэтгэлд хяналт тавих иргэдийн эрх хэрэгждэггүй, төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх тогтолцоо байхгүй зэрэг нь төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явц шударга бус явагдах, төсвийн зарцуулалт үр ашиггүй болох, авлига газар авах нөхцөл бүрдүүлж байгааг онцлон шүүмжилсэн юм.

Харин 2006 оноос эхлэн төсвийн мэдээллийг төрөөс ил тод болгоход томоохон ахиц гарч, улсын төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэх үеэр нийтийн хүртээл болгосон бол 2007 онд ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр Сангийн яам "Ил тод төсөв" (iltod.gov.mn) цахим хуудас нээж, 2007 оны төсвийн дэлгэрэнгүйг нийтэлсэн нь төрийн зүгээс төсвийн мэдээллийг нээлттэй болгосон анхны тохиолдол болов.

Бид нийтийн төсвийг нээлттэй, ил тод болгох чиглэлээр мөн олон улсын байгууллагуудтай хамтарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ирсний дотор "Монгол Улсын төсвийн нээлттэй байдлын үнэлгээ"-г онцлон дурдаж болно. "Олон улсын

төсвийн түншлэл" байгууллагын судалгаанд 2004 оноос эхлэн оролцож, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, мэдээлэл олж авах боломж, мөн төсвийн хяналтын институциудын гүйцэтгэж буй үүргийг хоёр жил тутамд тодорхой шалгуураар үнэлж ирэв. Энэхүү судалгаа нь төсвийн ил тод байдалд гарч буй өөрчлөлтийг илтгэхээс гадна манай улсыг бусад оронтой харьцуулах боломж олгодог билээ. Төсвийн нээлттэй байдлаар манай улс 2012 онд 51 оноо авч байсан бол 2023 онд 9 оноогоор дээшилж 62 оноонд хүрэв.

ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2005 онд иргэний нийгмийн байгууллагууд төсөвт мониторинг хийж эхэлсэн бөгөөд Орон нутгийн удирдлагын хөгжлийн сан ТББ-ын Багануур дүүрэгт өрнүүлсэн "Шилэн түрийвч" аян нь сайн жишиг тогтоож, өөр хэд хэдэн аймагт үр дүнтэй хэрэгжсэн нь төрийн бус байгууллагууд төсөвт ажиглалт хийх суурийг тавьсан төдийгүй хожмоо төсвийн ил тод байдлыг бэхжүүлэх "шилэн данс" үүсэх үндэс суурь болсон билээ.

2014 он төсвийг нээлттэй, хариуцлагатай болгоход эргэлтийн жил болсон юм. Шилэн дансны тухай хууль 2014 онд батлагдаж, 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн

билээ. Шинэ тутам батлагдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад бид 30 гаруй төрийн бус байгууллагатай хамтран хоёр жилийн туршид 21 аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрууд болон зарим төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийг оролцуулан цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гүйлгээ, холбогдох шийдвэрийг хамруулан мониторинг хийж үр дүнг нийтэд тогтмол мэдээлж байв.


ННФ-аас Ерөнхийлөгчийн тамгын газар, ҮАГ, Сангийн яамтай хамтран 2015 оны 5 дугаар сард зохион байгуулсан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” хэлэлцүүлгийн үр дүнд Засгийн газрын 89 дүгээр тогтоол (2017)

гарч захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд “шилэн дансны хөтлөлт”-ийг багтаав.

ННФ-ын зүгээс төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах чиглэлээр төрийн байгууллагуудтай үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлж ирсний нэг жишээ нь 2018 онд ҮАГ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн төрийн аудитад анх удаа иргэний нийгмийн шинжээчид оролцсон явдал билээ. Энэ нь төрийн аудитын байгууллага болон иргэд, олон нийт, төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагааны сайн жишиг тогтоосон үйл явдал болсон юм.

Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төсвийн төлөвлөлт, зарлага, худалдан авалтын ил тод байдлыг зохицуулж буй хууль, журмуудын хэрэгжилтийг үнэлсэн “Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгаа”-г 2010-2016 онд хийж, үр дүнг нийтэд хүргэсэн бөгөөд 2022 оноос Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвөөс жил бүр хийдэг аймгуудын өрсөлдөх чадварын судалгаанд орон нутгийн төсвийн ил тод байдал нэг үзүүлэлт болж ордог болоод байна. Цаашилбал, Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдлыг судлан (2022), дүгнэлт, зөвлөмжийг бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэсэн юм.

2024 оны улсын төсөвт УИХ-аас шинээр нэмсэн төслийн тоо, 2024 онд санхүүжих дүн





Төсвийн хариуцлагатай байдал

Төсвийн бодлогыг улс орны хөгжлийн эрх ашигт нийцүүлэх, төсвийн үрэлгэн, үр ашиггүй зарцуулалтыг бууруулах хүрээнд ННФ олон тооны судалгаа, шинжилгээ хийж, хэлэлцүүлэг өрнүүлснээс гадна иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хийх хяналт мониторингийн ажлуудыг дэмжиж ирлээ.

Төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөлийн нэг нь төлөвлөлт оновчтой байх явдал юм. Иймээс ННФ жил бүрийн улсын төсвийн төслийн орлого, зарлагын төлөвлөлт, УИХ-аар хэлэлцэх явцад оруулж буй өөрчлөлтөд шуурхай шинжилгээ хийж, үр дүнгээ бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийнхэнд танилцуулахаас гадна төрийн байгууллагуудын зүгээс иргэд, иргэний нийгэмд төсвийн төслийн талаар мэдээлэл өгөх уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж хэвшив. Түүнчлэн Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалт, зарлагын судалгаа (2009), Нийгмийн даатгалын сангийн төсөв, удирдлагыг боловсронгуй болгох (2019), Шинэ сэргэлтийн бодлогын төлөвлөлт (2022) зэрэг судалгаанууд маань төсвийн төлөвлөлтийг сайжруулахад чиглэж ирэв.

Төсвийн хариуцлагатай байдлыг хангахад гүйцэтгэлийн дүн шинжилгээ, аудит, иргэд, иргэний нийгмийн хяналт мониторинг нэн чухал үүрэгтэйг онцлон ННФ Ковид-19 цар тахлын үеийн төсвийн гадуурх зарцуулалт (2021), Монгол Улсын төрийн гадаад өр, түүний цаашдын төлөв байдал, өрийн тогтвортой байдал (2014, 2023), Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээ (2022), Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ (2023) зэрэг судалгааг хийж холбогдох байгууллагууд болон олон нийтийн сонорт хүргэв. Мөн 2022 онд БНХАУ-ын “Бүс ба Зам” төсөл, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хэрэгжих манай улсад хамаарал бүхий төслүүд, тэдгээрийн нөлөөлөл, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон хэрэгжиж буй төслүүд, эдгээр санаачилгын засаглалын зарчмуудыг судалж, анхаарах асуудлуудаар зөвлөмж гаргасан билээ.

Түүнчлэн улсын төсвөөс татаас авсаар ирсэн эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын засаглалыг судалж,

2014 онд гаргасан зөвлөмж маань өнөөдөр ид өрнөж буй эрчим хүчний салбарын шинэтгэлийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд ашиглаж болох чухал ач холбогдолтой эх сурвалж болно гэж үзэж байна.

Төрийн зүгээс төсөв, санхүүд тавих хяналтаа сайжруулах, нийтэд хүрэх мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төсвийн чиглэлээр ажилладаг шинжээч, судлаачдын бүрэлдэхүүнтэй тусгай зөвлөлийг бид 2021 онд байгуулсан юм. Энэхүү зөвлөл улсын төсөв, санхүүгийн асуудлуудаар байнга санал солилцон, шаардлагатай бодлогын шинжилгээ хийж санал, зөвлөмж боловсруулан УИХ-ын Төсвийн байнгын хороо, бусад холбогдох байгууллагад хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтийн анхааралд оруулж байна. Зарим судалгааг нэрлэвэл, Ковид-19 цар тахлын үеийн төсвийн бодлого, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилт, ковидын үеийн төсвийн гадуурх зарцуулалт зэргийг дурдаж болно. Улмаар Төсвийн зөвлөлөөс Ковид-19 цар тахлаас урьдчилан

сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2021 оны төсвийн тодотгол, 2023 оны улсын төсвийн төлөвлөлт зэрэг асуудлыг хэлэлцэн УИХ-д санал, зөвлөмж хүргүүлснийг мөн дурдах нь зүйтэй. Төсвийн зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд иргэний нийгмийн зүгээс төсвийн холбогдолтой цаг үеийн асуудлуудаар шуурхай дүн шинжилгээ хийж, цаг тухайд нь хариу үзүүлдэг болсны зэрэгцээ төсвийн төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй үялдуулах, үр ашигтай зарцуулахад нөлөөлөх боломж бүрдэж байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын төсөвт хяналт тавих чадавх, боломжийг сайжруулахад ННФ анхаарч улсын болон орон нутгийн төсвийн гарын авлага боловсруулж, сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, шинээр бий болсон ил тод байдал, хариуцлагын механизмуудыг цаг тухайд нь танилцуулж, хамтын ажиллагааг дэмжиж ирэв. ННФ-ын дэмжлэгээр төсвийн чиглэлээр ажилладаг 13 төрийн бус байгууллага 2008 онд нэгдэж “Иргэд төсвөө хянана” сүлжээ байгуулав. Тус сүлжээний гишүүн байгууллагууд орон нутгийн

төсвийн төсөл боловсруулах, Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д өргөн барих, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж батлах үйл явц болон батлагдсан төсвийн ил тод, нээлттэй байдалд мониторинг хийх, төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж ирлээ. Ийнхүү төсвийн чиглэлээр мэргэшиж буй төрийн бус байгууллагууд олон жилийн үйл явцын үр дүнд бий болсон төсвийн нээлттэй мэдээллийг хэрэглээнд оруулж, төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч төсвийн сонсгол шаардах, хариуцлага нэхэх акц хийх зэрэг үр нөлөөтэй үйл ажиллагаанд суралцаж байна.

Төрийн зарим байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлснээр төсөв, санхүүгийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд ННФ чухал нөлөө үзүүлснийг энд дурдахгүй байхын аргагүй. Тухайлбал, ҮАГ-тай 2018 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжүүдийг бодлого боловсруулагчдын анхааралд оруулах чиглэлээр хамтран ажиллав. Үүнээс гадна төрийн аудитын үйл ажиллагаанд иргэд хэрхэн оролцох талаарх мэдээллийг нийтэд хүргэлээ.

Төсвийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Төсвийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход бодлогын үнэлгээ, шинжилгээ нэн чухал болохыг харгалзан ННФ олон тооны судалгаа захиалж хийлгэхээс гадна өөрсдөө ч эрхлэн гүйцэтгэж ирлээ. Тухайлбал, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт (2020), улсын төсвийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсронгуй болгох (2021), улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа (2023), Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсэн хуулиудын төслийг боловсруулах, өргөн барих зохицуулалт (2023) зэрэг чиглэлээр судалгаа хийж, зөвлөмж боловсруулсан юм. Мөн Шилэн дансны тухай хууль, журмын аудитын дүгнэлтүүдэд хийх эрх зүйн судалгааг манай байгууллагаас дэмжин ажиллаж (2021), судалгаанаас гарсан санал, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагуудад хүргэв. Үүний дүнд гарсан зарим ахиц дэвшлээс дурдвал, Төсвийн тухай хуульд 2022 оны 11 дүгээр сард орсон өөрчлөлтөөр улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын төслүүдэд дахин давтагдашгүй код үүсгэж, төсөл хуулиар батлагдсанаас хойш уг код нь тухайн төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байхаар туссан юм. Энэхүү өөрчлөлт нь төсөвт туссан хөрөнгө оруулалтыг он дамнан хянах боломжийг хязгаарлаж байсныг шийдвэрлэсэн алхам болов.

Түүнчлэн он дамжин хэрэгжих төслийн анхны төсөвт өртгийн мэдээллийг тухайн төсөл үргэлжлэн хэрэгжих жилийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгах заалт Төсвийн тухай хуульд тусгалаа оллоо. ННФ-аас хийсэн төсвийн төлөвлөлтийн судалгаагаар өмнөх оноос шилжих зарим төслийн анх батлагдсан төсөвт өртөг ихээхэн нэмэгдсэн байгаа нь харагдсан бөгөөд энэхүү мэдээллийг хэлэлцэгдэх төсвийн

хөрөнгө оруулалтын жагсаалтад багтаахыг хуульчилсан нь ихээхэн ач холбогдолтой юм. УИХ-д өргөн барьж буй хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн мэдээлэлд тухайн оны байдлаарх төсөвт өртгийг тусгахаас гадна анх батлагдсан төсөвт өртгийг харуулснаар хууль тогтоогчид болон иргэний нийгмийнхэн тухайн төслийн төсөвт өртгийн өөрчлөлтийг нэг дороос үзэх, өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, улмаар хууль тогтоогчид бүрэн мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах, иргэдийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх давуу талтай.

ННФ-ын дэргэдэх Төсвийн зөвлөлөөс улсын төсөв, санхүүгийн чухал асуудлуудыг тогтмол хэлэлцэж, санал зөвлөмжөө УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлж ажилласнаар Төсвийн тухай хуульд 2023 оны 7 дугаар сард орсон өөрчлөлтөөр төсвийн удирдлагыг боловсронгуй болгох, төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр нааштай заалтууд ороод байна. Тухайлбал, төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах хүрээнд Засгийн газар олон нийтийн хэлэлцүүлгийг салбар бүрээр явуулах, гарсан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, тодотголын төсөлд хэрхэн тусгасан талаарх мэдээллийг нийтлэх, байнгын ажиллагаатай санал авах цахим хуудас, шуурхай утас ажиллуулах зэрэг шаардлагууд Төсвийн тухай хуульд мөн шинээр тусгалаа олов. Цаашилбал УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 69 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тооцоог хийж, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж байхаар хуульчлагдсанаас гадна улсын төсвийн цаглабарт нааштай өөрчлөлт оров.

Эрдэс баялгийн салбарын засаглалыг бэхжүүлэх нь

Бодлогын өөрчлөлт, шинэчлэл

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбарын нөлөө эрчимтэй нэмэгдэж, салбарын бодлого зохицуулалтыг нийгмийн шаардлага, дэлхийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх сорилттой ид нүүр тулж байсан 2000-аад оны дунд үеэс ННФ тус салбарын засаглалын асуудалд анхаарлаа хандуулж эхэлсэн билээ.

Засгийн газар уул уурхайн салбарын зохицуулалтыг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцүүлэх, хөрөнгө оруулалт татах бодлого явуулсны үр дүнд 2005 он гэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн

тоо эрс нэмэгдэж, салбарын олон төсөл биеллээ олж хэрэгжиж эхэлсний зэрэгцээ Оюу толгой, Тавантолгой зэрэг томоохон ордыг ашиглах асуудлаар гадаадын хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх хэмжээнд хүрчээ. Нөгөөс талаас, уул уурхай нь манай улс орны өсөлт, хөгжлийн нэгэн тулгуур багана болохыг хэн хүнгүй хүлээн зөвшөөрөх болсон ч хариуцлагагүй уул уурхайн байгаль экологид үлдээсэн үл мөр нь олон нийт, орон нутгийн иргэдийн зүгээс хүний эрх, байгаль орчин, улс, орон нутгийн хөгжилд оруулах бодит хувь нэмрийн талаар бас ярьж эхлэхэд хүргэв.

Хариуцлагагүй уул уурхайн дүр зураг, 2000-аад оны дунд үе



Уул уурхайгаас орох орлого ямар хэмжээтэй байх, яаж зөв зарцуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд ямар бодлого баримтлах, байгаль, нийгмийн сөрөг нөлөөллийг хэрхэн зохицуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд салбарын бодлого, зохицуулалтыг шинэчлэн сайжруулах сорилт тулгарч, нийгэмд янз бүрийн байр суурь, мэтгэлцээн, тэмцэл өрнөх болсноос хойш хориод жил өнгөрчээ.

Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн улс орны хөгжлийн алс ирээдүйд оруулах хувь нэмрийг ид хэлэлцэж байсан чухам тэр цаг үед ННФ тус салбарын тухай мэдээлэл, судалгаа, шинжилгээний тайлан, хууль тогтоомж, түүний хэрэгжилт, томоохон төслүүдийн талаарх мэдээллийг нэг дороос авч, оролцогч талуудад санал бодлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор 2005 онд “Уул уурхай ба хөгжил” сэдэвт ажиглалтыг анх эхлүүлсэн нь яваандаа олборлох салбар дахь татвар, санхүүгийн дэглэм, орлогын удирдлага, хөрөнгө оруулалтын гэрээ, лиценз олголт, авлигын эрсдэл, ил тод, хариуцлагатай байдал зэрэг салбарын засаглалын үндсэн асуудлуудыг нарийвчлан судлах, мөн өргөн олныг хамарсан бодлогын яриа хэлэлцүүлэг

өрнөх талбар болж өргөжив. 2006 онд зохион байгуулсан “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялаг хуваарилалт” олон талт хэлэлцүүлэгт төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн 180 гаруй хүн оролцож, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал” сэдэвт салбар хуралдаанаар байгалийн баялгийн үр шимийг иргэд жигд хүртэх, авлига, байгаль орчны доройтол зэрэг сөрөг үзэгдлийг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэхэд лиценз, гэрээ хэлэлцээр, татвар төлбөрийн мэдээллийг ил тод болгох шаардлагатайг олон нийт, шийдвэр гаргагч нарт сонордуулсан юм. Тэрчлэн 2007-2009 онд “Лиценз ажиглагч” ажиллагаа хэрэгжүүлсэн нь олон нийтийн дунд маргаан дагуулсан ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олголт, түүнд орсон өөрчлөлт, онцгойлон анхаарах асуудлыг иргэний нийгэм, орон нутгийн иргэд цаг алдалгүй мэдэж, хяналт тавих боломж олгосон мэдээллийн гол эх сурвалж болов. Улмаар энэ салбарт лицензийн мэдээллийг нээлттэй болгох, өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ, хяналт хийх эхлэлийг тавьж байв.

Цаг үеийн тулгамдсан асуудлаар санал бодлоо чөлөөтэй уралдуулж, шийдэлд

чиглэсэн бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлдгээрээ олонд танигдсан “Форум ТВ” телевизийн нэвтрүүлгээр 2005-2007 онд байгалийн нөөцийн менежмент, тогтворжилт, хөгжлийн сангийн хэрэгцээ, Оюу толгой ордын ашиглалт, алтны салбарын үр ашиг, татварын хөнгөлөлт чөлөөлөлт, нөхөн сэргээлт, иргэний хөдөлгөөн зэрэг олон чухал асуудлыг хөндөн ярилцсан нь алдаа, оноо хослон яригддаг энэхүү ээдрээтэй боловч ирээдүйтэй салбарын талаар тухайн үеийн нийгэмд үүсээд байсан талцал, түйлшралыг сааруулж, олон нийт салбарын талаар мэдлэг мэдээлэлтэй болоход зохих хэмжээнд нөлөөлсөн болов уу. Мөн салбарын бодлого, зохицуулалтыг нээлттэй, ил тод, олон талын байр суурийг жигнэн дүгнэж боловсруулахад зохих нэмэр оруулсан гэдэгт бид итгэлтэй байна.

Хөрсөн доорх баялгаа хүн бүрд хүртээмжтэй хөгжил болгож чадах эсэх нь бүхэлдээ татварын тун хэмжээг зохистой тодорхойлж, олсон орлогоо үр ашигтай зарцуулах эсэхээс шалтгаалах билээ. Энэ хүрээнд 2006 онд Нью-Йорк хотод төвтэй “Орлогын ажиглагч хүрээлэн” зэрэг олон улсын байгууллага, Дюкийн Их Сургуулийн профессор Р.Конрад,

олон улсын хуульч Ж.Бэлл зэрэг дэлхийн тэргүүлэх эрдэмтэдтэй хамтран татвар санхүүгийн дэглэм, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, суурь үнэ тооцох арга зам, гэнэтийн ашгийн татвар болон бусад асуудлаар иж бүрэн шинжилгээнүүд хийв. Судалгааныхаа үр дүнг “Форум ТВ” телевизийн нэвтрүүлэг болон цахим хуудсаараа нийтэд түгээж, салбарын мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэн УИХ, Засгийн газрын гишүүдэд цаг алдалгүй хүргэж байсан нь төрийн бодлогод тусгалаа олж, ажил хэрэг болоход нөлөөлөв.

Эргэж нөхөгдөхгүй байгалийн баялгаас олсон орлогоо эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогоор үр ашигтай зарцуулахын тулд хуримтлал үүсгэж, өсгөж арвижуулан ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах талаар олон улсын түршлага, сургамжийг анхлан танилцуулж, 2006-2009 онд Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Штиглиц, Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан захирал Давид Доллар, Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном нарын лекц ярианд тулгуурлан хэлэлцүүлэг өрнүүлж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-аас гаргасан “Сайхан ярианы цаана” судалгаа, Орлогын ажиглагч хүрээлэнгийн “Гүн

өрөмдөж үзэхүй”, “Газрын тосны тухай бичихүй”, Пол Коллиерын “Адагт үлдсэн тэрбум”, Жаред Даймондын “Сүйрэл” номыг орчуулан хүргэж байв.

Байгалийн баялгаас олсон орлогоо зохистой ашигладаг болгоход чиглэсэн дээрх үйл ажиллагаа 2010 онд Төсвийн тогтворжуулалтын сан, 2016 онд Ирээдүйн өв сан, 2024 онд Үндэсний баялгийн сан байгуулагдах хүртэл 20 гаруй жилийн турш тасралтгүй үргэлжилсэн билээ. Энэ хугацаанд бид бие даасан судлаачид, "Орлогын ажиглагч хүрээлэн"-гийн зөвлөхүүдтэй хамтран эрдэс баялгийн салбар дахь холдинг компанийн эрсдэл, үр өгөөж, хуримтлалын болон тогтворжуулалтын сан, Хөгжлийн банкны асуудлаар дүн шинжилгээ хийж үр дүнг холбогдох талуудад танилцуулсан юм. Эдгээр судалгаагаар эрдэс баялгийн салбарын орлогын менежментийг үнэлэх шалгуур боловсруулж, тогтворжуулалт болон хөгжлийн сан, Хөгжлийн банкны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, 2012 оноос эхлэн Байгалийн баялгийн засаглалын индексийн үнэлгээнд оролцох болсон нь өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна. Уул уурхайн салбарын орлогын хуваарилалтад иргэдийн анхаарлыг хандуулж, бодлого

2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, тооцох арга замыг шинэчлэн тогтоосон нь ННФ-ын судалгаанаас гаргасан саналтай нийцсэн билээ.

2021 оны Монголын зураглал

ДӨРВӨН ЗАЯА



ЗОРГООР НЬ ОРХИСОН БОЛ ИЛҮҮ БАЙХ ХУВЬ ЗАЯА

...Баян болно гэж Заяа хэлэх ч боловч байсангүй. Харин хэлэх нэгэн цагт дүрвэнх нэгдэн амжилтаар сайхан амьдралын тэнгэр болж байсан үе Заяад байв.



ӨГӨӨМӨРТ НАЙДСАН МОНГОЛ ЗАЯА

...Заяа нэгдэн болж нүүдэдийн сар бүр явдаг тэглэм, нэрвэл цэцэн зэрэгээр нийлүүлдэг шиг түүний амьдралаа мөхүүрэн, түүн дотор нэгдэн амжилтаар сайхан амьдралын тэнгэр гэж найзлаад ирж байгаа...



ӨМНӨГОВИЙН "НОГООН КАРТ"-НЫ ЭЗЭН ЗАЯА

Өвөр Монгол-Өмнөговийн аргын нэгдэл үйлдвэрлэлийн Баян Цэцэг нүүдэдийн үүсвэр Заяа "Оюу толгой" компанид нүүдэдийн үйлдвэрлэлийн үзэх ажилд оролцож байна.



ИХ ХУВЬ ЗАЯАТАЙ ОРНЫ ИРГЭН ЗАЯА

...Заяа баян сайн, амьдралын аргаар үр амжилтаар, Өмнөговийн газрын тусгай зонианд байгаа нь сайхан хэргийг гэгддэг байна гэж хэлж байна. Гэвч Заяа нь сайн амьдралын тэнгэр болж байна гэж хэлж байна. Сайн амьдралын тэнгэр болж байна гэж хэлж байна.

Сценари 1: Зоргоор нь орхисон бол илүү байх хувь Заяа

Сценари 2: Өгөөмөрт найдсан монгол Заяа

Сценари 3: Өмнөговийн "Ногоон карт"-ын эзэн Заяа

Сценари 4: Их хувь заяатай орны иргэн Заяа

боловсруулагчдад нөлөөлөх зорилгоор “2021 оны Монголын хөгжлийн зураглал: Дөрвөн Заяа” хэмээх орлогын менежментээс хамаарсан ирээдүйн хөгжлийн дүр зургийг тэртээ 2012 онд гаргасан нь өнөө ч зарим талаар ач холбогдолтой хэвээр байна. Тэрчлэн Төсвийн тухай, Төсвийн тогтворжуулалтын тухай, Үндэсний баялгийн тухай хуулиудад олон удаа санал шүүмж өгч, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг батлан гаргахад бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангаж, хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт тэргүүлэх үүрэгтэй ажиллав.

Гэсэн хэдий ч уул уурхайн салбарын бодлого нь улс төржилт, бизнесийн явцуу ашиг сонирхол, сонгуулийн элдэв амлалтыг тойрон гарч чадаагүй нь өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банк, тогтворжилт, хуримтлалын сан, төрийн өмчит компаниудын үйл ажиллагаанд үүссэн доголдол, зүй бус зарцуулалтаас харагдана. Ийм ч учраас байгалийн баялгийн өгөөжийг тогтвортой хөгжлийн зорилгод зүй зохистой ашиглаж, тэгш шударга хуваарилах асуудал Үндсэн хуулийн зарчмын хэмжээнд хүртэл чухлаар тавигдах болжээ. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Үндэсний баялгийн сан”

байгуулах тухай хэлэлцүүлэг нийгэмд дахин идэвхжиж эхлэв. ННФ ч энэ хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, сангийн удирдлага, засаглал, ил тод байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн санал, байр сууриа илэрхийлсээр ирэв. Гэсэн хэдий ч 2024 оны 4 дүгээр сард яаралтай горимоор, олон нийтийн хэлэлцүүлэггүй батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль нь Сантиагогийн зарчимд бүрэн нийцээгүй гэсэн шүүмжлэл дагуулсаар байна.

Манай улс Оюу толгойн ордыг ашиглах асуудлаар Айвенхоу Майнз компанитай хэлэлцээрт хүрч, 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээнд хоёр тал гарын үсэг зурах хүртэлх хугацаа нь Оюу толгой, Тавантолгой зэрэг асар их нөөцтэй томоохон ордуудаа хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулах талаар монголчууд бүгдээрээ санаа чилээж, санал бодлоо уралдуулж асан цаг. ННФ дэлхийн шилдэг мэргэжилтнүүдтэй хамтран тухайн үед танилцуулагдсан Оюу толгойн ордын ашиглалтын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд дүн шинжилгээ хийж, өнөө ба ирээдүйд хүртэх үр ашгийг тооцоолох санхүүгийн загварыг танилцуулж, бусад улс орны алдаа онооноос санаа, сургамж авах боломжийг төр, иргэний нийгэмд тэгш тэнцүү олгохыг

эрмэлзэж ирсэн нь олон жилийн баялаг түршлагатай хүчирхэг корпорацитай хэлэлцээрт хүрч, Оюу толгой төслийг амилуулахад зохих хувь нэмрээ оруулсан гэдэгт итгэлтэй байна.


Тэрчлэн ННФ-ын зүгээс орд ашиглахад төр хувь эзэмших эсхүл бүтээгдэхүүн хуваах зарчмаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж оролцох зэрэг хөрөнгө оруулалтын үндсэн хувилбарууд, тэдгээрийн давуу болон сул талыг танилцуулж, төр, иргэний нийгмийн чадавх бэхжүүлэхэд идэвхийлэн ажилласаар байв. Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад холдинг компани байгуулж, олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгох, гадаадын хөрөнгө оруулалт татаж гэрээ байгуулах, оператор компани ажиллуулах зэрэг олон янзын хувилбар он дамнан яригдсан билээ. ННФ 2010 онд “Орлогын ажиглагч хүрээлэн”-тэй хамтран холдинг компанийн эрсдэл, үр өгөөж, засаглалын асуудлууд, оператор компанитай байгуулах үйлчилгээний гэрээний давуу, сул талыг судлан Засгийн газрын саналд зөвлөмж хүргүүлсэн бол 2015 онд Засгийн газраас танилцуулсан хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын баталгаа,

тогтворжилт, өмчлөл шилжүүлэх нөхцөл, гэрээний хууль зүйн үр дагавартай холбоотой дүгнэлт саналаа хүргүүлэв.

Уул уурхайн салбар, тэр дундаа стратегийн ач холбогдолтой томоохон орд дахь төрийн оролцоо улам тэлж буй энэ үед төрийн өмчит компанийн (ТӨК) засаглал улам чухал боллоо. Иймд бид ТӨК-ийн эрх зүйн шинэчлэл, засаглалын хэлэлцүүлэгт судалгаа шинжилгээгээрээ дамжуулан идэвхтэй оролцсоор байна. Энэ хүрээнд бүр анх 2007 онд төрийн оролцоо, компанийн засаглалын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж эхэлсэн нь тасралтгүй үргэлжилсээр 2014-2024 онд уул уурхайн салбарын бүх ТӨК-ийг хамарсан засаглалын үнэлгээ хийж, Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-ийн хараат бус байдал, томилгоо, хариуцлага, нэгдлийн зохион байгуулалт болон сүүлийн үед тогтоох болсон онцгой дэглэм, бүрэн эрхт төлөөлөгч томилох зэрэг асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, ТӨК-тай холбоотой хууль тогтоомжийн төсөлд шүүмж хүргүүллээ. Мөн авлигын өндөр эрсдэл бүхий ТӨК-ийн худалдан авах ажиллагаанд мониторинг, дата анализ хийж, хуулийн шүүмж болон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлүүдээрээ дамжуулан

ННФ-ын саналаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, гэрээний ил тод байдлын заалтууд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдан, анхны нээлттэй гэрээ болсноор түүний хэрэгжилт, эрсдэл, үр өгөөжийн талаар олон нийт шүүн хэлэлцэх боломж нээгдэв.

2005-2024 онд эрдэс баялгийн салбарын асуудлаар гаргасан ном судалгаа, зохион байгуулсан арга хэмжээ



- Ном
- Хууль тогтоомжид өгсөн санал
- Мониторинг
- Судалгаа, үнэлгээ
- Сургалт, хэлэлцүүлэг
- Мэдээ, мэдээлэл

авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг талуудын сонорт хүргэсээр байна.

Төрийн бодлого, зохицуулалт зөв оновчтой байж, амжилттай хэрэгжих эсэх нь судлаач, мэргэжилтнүүд, иргэний нийгэм, иргэдийн идэвх оролцооноос ихээхэн хамааралтай байх тул үндэсний хэмжээнд судлаач, мэргэжилтнүүдийг бэлтгэх, төр-иргэний нийгмийн үр дүнтэй хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавх бүрдүүлэх, иргэдийн хяналт, оролцоог төлөвшүүлэхэд бид мөн санал, санаачилга гарган ажиллаж ирлээ. Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр, 2005-2009 онд хэрэгжсэн Дорно-дорно хөтөлбөрөөрөө дамжуулан үндэсний судлаачдыг бэлтгэн, туршлага судлах аялал, төрөл

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал

Байгалийн нөөц баялаг ихтэй, хөгжиж буй улс орон орлогоо зохистой удирдахгүй байх аваас авлига хээл хахууль газар авч, засаглалын чанар доройтож, эдийн засгийн хөгжил саарах нь түгээмэл. Үүнээс сэргийлэхэд байгалийн баялгаас олж буй орлогын хэмжээ, түүнийг юунд зарцуулж буйг ард түмэн мэдэж, бодитой хяналт тавьж чаддаг байх нь нэн чухал.

Уул уурхай өргөжин тэлсэн 2000-аад оны дунд үед лицензийн наймаа, авлига, хяналт, хариуцлагагүй байдал манай улсад газар авч, хаа саагүй тэмцэл хөдөлгөөн өрнөх болов. Энэ нөхцөл байдалд ННФ тус салбарын ил тод байдалд анхаарал хандуулан нэгэн чухал хэрэгслийг танилцуулахад хүчин чармайлт гаргаж ажилласнаар Монгол Улс 2006 оны нэгдүгээр сард Их Британийн Засгийн газрын санаачилсан ОУИТБС-д нэгдэн орохоо албан ёсоор зарласан юм. ОУИТБС эхлэхдээ зөвхөн уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөр, орлогыг ил тод болгож, компани, төр хоёрын тус тусдаа тайлагнасан дүнгийн зөрүүг шалган баталгаажуулж

бүрийн сургалт семинар, арга хэмжээг үндэсний болон олон улсын түвшинд тасралтгүй зохион байгуулж, тэтгэлэг дэмжлэг олгож ажиллав.

Эцэст нь тэмдэглэхэд, дээр дурдсан ахиц дэвшлийг олоход салбарын төрийн байгууллага, бодлого боловсруулагчдын хамтын ажиллагаа, дэмжлэг туйлын чухал байсныг дурдах нь зүйтэй. Түүнчлэн уул уурхайн чиглэлээр ажилладаг судлаач, мэргэжилтнүүд, ТАН эвсэл, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Транспэрэнси Интернэшнл зэрэг олон улсын болон үндэсний төрийн бус байгууллагуудын дэмжлэг, хамтын ажиллагаа нь бидэнд урам зориг нэмж энэ олон жилийн тасралтгүй үйл ажиллагааг бүрэлдүүлж ирсэн билээ.

нийтэд мэдээлдэг байсан бол эдүгээ төлбөр орлого, гэрээ, тусгай зөвшөөрөл, эцсийн өмчлөгч, олборлолт, борлуулалт, худалдан авалт, экспорт, тээвэр, ажиллах хүчин, нөхөн сэргээлт, нийгмийн зардлыг хүртэл ил болгодог, дэлхийн 55 улсыг эгнээндээ багтаасан ил тод байдлын тэргүүн стандарт болон хэрэгжиж байна. Улмаар тус Санаачилга зөвхөн ил тод байдлыг хангах төдийгүй авлига, ашиг сонирхлын зөрчилтэй бодитойгоор тэмцэхийг уриалах болсны дотор ТӨК-ийн сайн засаглал, ил тод байдлыг хамгаас чухалчлан тусгайлсан шаардлага хэрэгжүүлэхийг улс орнуудад үүрэг болгоод байна.

ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд ННФ ихээхэн хүчин чармайлт гарган талуудын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн эн тэнцүү оролцоог баталгаажуулах, мэдлэг ойлголт түгээх, тайлан мэдээллийг чанаржуулан үр дүнг бодлого шийдвэр гаргахад үр нөлөөтэй ашигладаг болгох чиглэлээр тасралтгүй ажиллаж ирлээ. Энэ бүхний үр дүнд Санаачилгын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах өнөөгийн бүтэц тогтолцоо бүрдсэн юм.

Эдүгээ тайлагналын цахим системээр дамжуулан жил бүр 1000 гаруй компанийн мэдээллийг цуглуулж, манай улсын олборлох салбарын орлогыг бараг бүрэн хамарсан үндэсний нэгтгэл тайланг он дараалан гаргаж хэвшлээ. Энэ нь улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах засаглалын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж буй гэдэгт итгэлтэй байна.

Тэрчлэн уул уурхайн үйл ажиллагаанаас манай улс хэдий хэрийн орлого олж, юунд зарцуулж байгааг иргэд нь мэддэг, хяналт тавьж, хариуцлага нэхдэг, тулгамдсан асуудлаа бодит мэдлэг, мэдээлэлд суурилж хамтран шийдвэрлэдэг байх нь дахин сэргэшгүй байгалийн баялгаа хариуцлагатай ашиглахын нэн чухал нөхцөл юм. Энэ зорилгоор ОУИТБС-ын Ажлын алба болон ТАН эвсэлтэй хамтран орон нутагт мэдээлэл түгээх хэлэлцүүлэг, сургалтыг тасралтгүй зохион байгуулав. Үүний үр дүнд аймаг, сумдад ОУИТБС-ын дэд зөвлөл байгуулагдан, үйл ажиллагаа явуулах төсөв санхүү, хууль эрх зүй орчин бүрэлдэн тогтож, нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, хандив дэмжлэгийн зарцуулалт гэх мэт тулгамдсан асуудлаа орон нутагтаа дүгнэн хэлэлцдэг нийтлэг жишиг тогтоод байна.

Авлигаас сэргийлэхэд өндөр ач холбогдолтой мэдээлэл болох гэрээний ил тод байдал, эцсийн өмчлөгчийн бүртгэл, нээлттэй тайлагнал нь тус Санаачилгын хүрээнд улс орнуудын заавал биелүүлэх үүрэг, салбарын соёл болжээ. ННФ гэрээний ил тод байдлыг хангахад манлайлан оролцож, төр, хувийн хэвшлийн хүчин чармайлтыг нэгтгэж чадсанаар 2019 онд Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн нэгдсэн сан (www.iltodgeree.mn)-г ашиглалтад оруулсан бөгөөд тус сан анх 400 орчим гэрээтэйгээр нээгдэж байсан бол эдүгээ улсын болон орон нутгийн түвшний 1000 гаруй гэрээг бүрэн эхээр нь агуулсан мэдээллийн чухал эх сурвалж боллоо. Гэрээг тод болгох үйл ажиллагаанд төр засаг, иргэний нийгэм,

тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын дэмжлэг, хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэснийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Ил тод байдал эцсийн дүндээ хариуцлагад хөтлөх учиртай. Нийтэд ил тод болсон гэрээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бодлого зохицуулалтаа сайжруулах, хэрэгжилтээ үнэлэх, басхүү хариуцлага тооцож чадаж гэмээж сая авлига, ашиг сонирхлын зөрчлийг сэргийлж чадах билээ. Иймээс ННФ төр, орон нутаг, иргэний нийгмийн гэрээ хэлэлцээр байгуулах, хяналт шинжилгээ хийх, хариуцлага шаардах чадавх бэхжүүлэхэд хөрөнгө нөөцөө дайчлан ажилласны дотор зөвхөн Оюу толгой, Тавантолгойн төсөлтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд гэхэд 7 удаа шинжилгээ хийж, дэлхийд танигдсан эрдэмтэдтэй хамтран эдийн засгийн үр ашгийг тооцоолох санхүүгийн загвар боловсруулан төр засгийн түвшинд танилцуулж

Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан
www.iltodgeree.mn



байв. Мөн уул уурхайн төслийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг баталгаажуулах зорилготой орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний талуудыг чадавхжуулах чиглэлээр өнгөрсөн хугацаанд 30 гаруй удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, удирдамж, гарын авлага, санал зөвлөмж гаргаж, мониторинг, нийтийн ашиг сонирхлын өмгөөллийн 24 тэтгэлэг олгожээ.

ОУИТБС-ын стандартын 2016 оны шинэчлэлтээр олборлох салбарын компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил болгох замаар авлигатай тэмцэх үйл ажиллагаандаа ахиц гаргах үүргийг улс орнууд хүлээх болов. Энэ ажлыг хэрэгжүүлэхэд ННФ түүчээлэн оролцож 2017 онд үндэсний эрх зүйн тогтолцоог үнэлэн эцсийн өмчлөгчийг ил тод болгох бодлого, тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулан, оролцогч талуудыг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүллээ. Түүнчлэн ОУИТБС-ын Ажлын алба, Авлигатай тэмцэх газар, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, ТАН эвсэл, судлаач мэргэжилтнүүдтэй хамтран 40 гаруй удаагийн сургалт, хэлэлцүүлэг, яриа таниулга хийсний дүнд 2018 онд уул уурхайн салбар эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгосон хамгийн эхний салбараар тодорч, удалгүй ашигт малтмал, улсын бүртгэл болон татварын хууль тогтоомжид өөрчлөлт орсноор эцсийн өмчлөгчөө тайлагнах нь Монгол Улсад бүртгэлтэй бүх хуулийн этгээдэд хамаарах нийтлэг үүрэг болсон юм. Улмаар төрөөс хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг нээлттэй болгосон билээ. Энэ бүх ахиц дэвшил гарахад 2019 онд ФАТФ буюу мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий засгийн газар хоорондын байгууллагаас Монгол Улсыг “саарал жагсаалт”-д оруулж, хууль тогтоомжоо олон улсын шаардлагад нийцүүлэн сайжруулах санамж өгсөн нь ч томоохон түлхэц болсныг дурдах нь зүйтэй.

Ийнхүү эцсийн өмчлөгчийн ил тод байдал хэрэгжиж эхэлсэн ч нээлттэй мэдээллийг бүтээлчээр ашиглах, авлигын бодит эрсдэлд олны анхаарлыг хандуулахгүйгээр нийтийн өмч хөрөнгийн зүй бүс зарцуулалтыг хязгаарлах боломжгүй. Иймээс бид Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Хөгжлийн төлөө өгөгдөл ТББ-тай хамтран өгөгдлийн шинжилгээ, эрэн сурвалжлах чадавх бэхжүүлэх цуврал сургалт зохион байгуулж, иргэний нийгэм, сэтгүүлчдийн санаачилгыг дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2020 онд Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Олон Улсын Санхүүгийн Корпорац, ОУИТБС-тай хамтран “Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” цахим хакатон зохион байгуулсан нь цар тахлын хатуу хөл хорионы үед залуучуудыг идэвхжүүлэн эрдэс баялгийн салбарын засаглалын хэлэлцүүлэгт татан оролцуулах эхлэл болов. Хакатонд 200 гаруй хүн оролцож дата шинжилгээ, мэдээллийн технологид суурилсан олон сонирхолтой шийдлийг танилцуулсны дотор хиймэл дагуулын зураг ашиглан нөхөн сэргээлтийн явцыг тогтмол хянах, орон нутаг дахь уул уурхайгаас орлого төвлөрүүлдэг сангуудын засаглал болон ТӨК-ийн худалдан авалтын ил тод байдлыг тус тус хөндсөн сэтгүүл зүйн бүтээлүүд нийтийн хүртээл боллоо. Тэдгээрээс “Хөгжлийн сан нэртэй ёроолгүй савнуудад хуулийн дэнс хэрэгтэй” нийтлэл Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн эдийн засгийн сэтгүүл зүйн оны шилдэг бүтээлийн нэгээр шалгарсан билээ.

Бид энэ түршлагадаа тулгуурлан өгөгдлийн шинжилгээг хөгжүүлэх иргэний нийгмийн санаачилгыг дэмжин ТӨК-ийн худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж, худалдан авалт дахь үр ашиггүй байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх ажлыг эхлүүллээ. Залуучууд энэ ажлаар өгөгдлийн шинжилгээ хийх, дүрсжүүлэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үр чадвараа нэгтгэн “дата клуб” байгуулж, төрийн нээлттэй мэдээллийг

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН НҮҮРС ТЭЭВРИЙН С ЗӨВШӨӨРӨЛТЭЙ КОМПАНИУДЫН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ

Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор нүүрс тээврийн С зөвшөөрлийг уурхайнууд өөрсдөө олгохоор зохицуулсан. Энэ дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүсээс Гашуун сухайт-Ганц мод боомт хүртэл 25 км газарт нүүрс тээвэр хийх 7200 С зөвшөөрлийг “Эрдэнэс тавантолгой”, “Тавантолгой”, “Энержи Ресурс” компанид хуваан олгожээ.



60%



25%



15%

4320 1800

1030

2023 оны 1, 2-р улиралд 4011 С зөвшөөрлийг 188 ХХК-д олгов

“Friendship & Fortune S Corporation”



“Качфлов энерги”



“И-Коммодитс Монголиа Интелигент Ложистикс Пте”




Гүйцэтгэх удирдлага, оффисын хаяг нэгтэй компаниуд



Гүйцэтгэх удирдлага, эцсийн өмчлөгч нэгтэй компаниуд



Бусад



Засгийн газраас нүүрс тээврийн компаниудад С зөвшөөрлийг хувь тэнцүүлсэн журмаар олгож эхэлсэн. Энэ дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК 2023 оны эхний хоёр улирлын байдлаар нийт 188 компанид 4000 гаруй тусгай зөвшөөрлийг олгоод буй.

Дунджаар нэг компанийн нийт хүсэлтийн 35-50 орчим хувьд С зөвшөөрөл олгож байгаа.

Гэхдээ эдгээр тусгай зөвшөөрлийн гуравны нэг нь харилцан хамаарал бүхий хэдхэн групп компанид төвлөрсөн байна.

2006 онд эрдэс баялгийн салбарын засаглалын асуудлаар ажилладаг 10 гаруй төрийн бус байгууллага нэгдэн ТАН эвсэл байгуулагдсанаас хойш орон нутгийн төрийн бус байгууллагуудаар хүрээгээ тэлсээр эдүгээ 30 гаруй гишүүнтэй үндэсний болон олон улсын хэмжээнд танигдсан иргэний нийгмийн сүлжээ боллоо.

ашиглан нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахаар ажиллаж байна. Клубийн гишүүдийн бүтээлүүдээс нүүрс тээврийн “С” зөвшөөрөлд холбогдох авлигын эрсдэлийг сурвалжилсан нийтлэл 2023 онд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн “Цахиур” уралдааны дэд байрт шалгарсан бол, “Дөрвөн толгой залгисан Тавантолгой ба дүр эсгэсэн ТУЗ-ийн засаглал” нийтлэл нь “Анрийд медиа”-гаас зарладаг оны онцлох нийтлэлийн нэг болжээ.

ОУИТБС-аас 2023 онд нутгийн уугуул иргэдийн эрхийг хүндлэн бодит оролцоог хангах, жендер,

уур амьсгалын өөрчлөлт, авлигатай тэмцэх чиглэлээр улам хариуцлагатай байхыг оролцогч улс орнууддаа уриалж буйгаа зарлав. Уриалгын гол санаа нь хүн төрөлхтөн түүлсан замаа эргэн харж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, эх дэлхийдээ ээлтэй тогтвортой хөгжлийн замыг сонгох хариуцлагатай үүргийг хойч үеийнхээ өмнө хүлээж байгааг сануулах явдал бөгөөд ОУИТБС-ын энэхүү шинэчлэгдэж буй шаардлага, стандартыг ажил хэрэг болгоход ННФ цаашид ч хувь нэмрээ оруулсаар байх болно.

Төлсөн Авсанаа Нийтэл (ТАН) эвсэл

ОУИТБС-ын бас нэгэн онцлог нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн эн тэнцүү оролцоо, эрх тэгш хамтын ажиллагаанд тулгуурладаг бөгөөд ТАН эвсэл тус Санаачилгыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшилтэй эн тэнцүү хэмжээнд үр дүнтэй хамтран ажиллаж байгаад ННФ-ын дэмжлэг, оролцоо чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Талууд анх 2007 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх Санамж бичигт гарын үсэг зурж, төр, төрийн бус байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн тэнцүү тооны

төлөөлөл бүхий Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг байгуулагдсанаар зөвшилцөлд суурилсан эрх тэгш, хамтын ажиллагааны эхлэл тавигдсан билээ. Энэ цаг үеэс эхлэн ТАН эвсэл ил тод байдлын хэрэгжилтэд бүхий л талаар идэвхийлэн оролцож, тайлан, маягт гаргах, орон нутгийн иргэдийг чадавхжуулах, мэдээ мэдээлэл түгээн санаачилгын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирлээ. Ялангуяа ил тод байдлыг орон нутагт хэрэгжүүлэх, компаниудын үйл ажиллагааг төсөл тус

PRMONGOLIA

COMPANIES

GOVERNMENT

OUR VISION

*BUILD UP A SOCIETY WHERE EXTRACTIVE INDUSTRY'S REVENUE MANAGEMENT IS OPEN AND TRANSPARENT, AND ITS BENEFITS ARE FAIRLY AND EQUALLY DISTRIBUTED, AND HUMAN DEVELOPMENT AND WELL-BEING IS PROVIDED.

STRATEGIC GOALS FOR 2014-2016

- *MAKING A PROFOUND CONTRIBUTION TO THE ESTABLISHMENT OF ENABLING LEGAL ENVIRONMENT FOR HOLDING EXTRACTIVE SECTOR OPEN AND TRANSPARENT
- *ADVOCATING FOR BROADER PUBLIC PARTICIPATION IN DECISION MAKING OF NATURAL RESOURCES, WITH ADEQUATE UNDERSTANDING OF EITI AND ITS NEW STANDARDS
- *BEING AN EFFECTIVE, STRONG AND SOCIALLY RECOGNIZED ORGANISATION THROUGH ITS ACTIVITIES AND OUTCOMES.

MAJOR CHALLENGES

- ! LACK OF FUNDS TO TAKE EFFECTIVE PUBLIC CAMPAIGNS FOR POLICY REFORMS USING EITI DATA
- ! LACK OF LEGAL REQUIREMENT FOR CONTRACT TRANSPARENCY AND DISCLOSURE OF BENEFICIAL OWNERS
- ! NON-RECOGNITION OF 'PRIOR AND INFORMED CONSENT PRINCIPLES' AND LACK OF LOCAL COMMUNITIES' PARTICIPATION IN THE MINING RELATED DECISIONS
- ! LACK OF LIABILITY FOR THE FAILURE OF REPORTING DUTIES OF COMPANIES AND IMPROPER INVESTIGATION ON DISCREPANCIES FOUND BY EITI REPORTS.



★ STANDING RIGHTS FOR NGOs TO CLAIM FOR THE PUBLIC INTEREST 2016

★ REVISION OF TOR FOR MSWG MEMBERS TO IMPROVE THE IMPLEMENTATIONS OF EITI REPORTS 2015

★ ADOPTION OF MODEL RULES FOR EITI SUB-NATIONAL COMMITTEES 2013

★ REPRESENTATION OF MONGOLIAN CSOs IN THE EITI INTERNATIONAL COMMITTEE 2011

★ LEGAL REQUIREMENT OF REPORTING DUTIES OF THE COMPANIES 2006

★ PUBLICATION OF 2 SERIES OF DATA ANALYSIS ON EITI NATIONAL REPORTS 2012 AND 2015

★ CONSENSUS AMONG STAKEHOLDERS ON CONTRACT TRANSPARENCY 2015

★ RESEARCHED THE STATUS OF OWNERSHIP OF GOVERNMENT OFFICIAL IN EXTRACTIVE COMPANIES 2014

★ CONTRIBUTION IN DRAFTING THE LAW ON EXTRACTIVE SECTOR TRANSPARENCY 2014

★ CSO'S PRELIMINARY ASSESSMENT ON EITI IMPLEMENTATION USING THE VALIDATION CRITERIA 2010

START 2006

★ KEY ACHIEVEMENTS
 ! MAJOR CHALLENGES

бүрээр нарийвчлан тайлагнадаг болох, байгаль орчны мэдээллийг ил тод болгох, гэрээ, эцсийн өмчлөгчийн нээлттэй байдлыг хангах зэрэг шинэ стандарт, шаардлагыг нутагшуулан хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцжээ. Тэрчлэн иргэний нийгмийн хяналтын чиг үүргээ амжилттай гүйцэтгэн хяналт мониторингоор дамжуулан зөрчил дутагдлыг арилгах, Үндэсний тайланг чанаржуулан бодлогын өөрчлөлт шинэчлэл хийхэд төр, хувийн хувийн хэвшлийг уриалан ажиллаж байна.

ННФ тус эвслийг үүсгэн байгуулахад анхнаас нь идэвхтэй оролцож, байгууллагын хувьд өсөн дэвжихэд нь шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ 2011-2012, 2015-2018 онд хоёр удаа эвслийн зохицуулагчаар сонгогдон ажиллав. Энэ хугацаанд эвслийн гадаад, дотоод хамтын ажиллагааг бэхжүүлж, байгууллагын хөгжлийг дэмжих стратеги төлөвлөгөөг боловсруулахад манлайлан ажиллав. Өнгөрсөн хугацаанд ТАН эвсэл, түүний гишүүн байгууллагууд ННФ-ын дэмжлэгтэйгээр Киргизстан, Казакстан, Азербайжан, Гүрж, Украин, Өвөр Монгол, Канад, Франц, Гана, Индонези, Тажикстан, Сенегал зэрэг улсад айлчлан ОУИТБС-ын арга хэмжээнд оролцон, Төлснөө Нийтэл олон улсын сүлжээний Евроазийн бүсийн уулзалтыг Монгол Улсад зохион байгуулж, Украин, Казакстан, Киргизстан, Афганистан улсын ижил төстэй байгууллагуудыг эх орондоо урьж туршлага, сургамжаа хуваалцлаа.

ТАН эвсэл нь тусгай зөвшөөрөл олголт, ОУИТБС болон хууль тогтоомжийн хэрэгжилт, ялангуяа байгаль орчныг хамгаалах, ил тод байдлыг хангах, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр нутгийн захиргааны болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үүргийн хэрэгжилтэд 48 удаа мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах өмгөөлөл, нөлөөллийн ажлууд хийснээс гадна сургалт, хэлэлцүүлэг, бусад үйл ажиллагааг 21 аймагт хүрч зохион байгууллаа.

Эрдэс баялгийн салбарын засаглалыг сайжруулах бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Байгаль орчны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Уул уурхайн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай зэрэг хуулийн төслүүд болон салбарын бусад дүрэм журмын төсөлд санал шүүмж өгч, орон нутагт гарч буй хуулийн зөрчлийг арилгуулах санал шаардлагыг тухай бүр төр засгийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Эдүгээ ТАН эвслийн олон гишүүн нийтийн эрх ашгийн өмгөөлөлд суралцан эрдэс баялгийн салбарт төр, хувийн хэвшлийн сахилга, хариуцлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн олон чухал шийдвэрийг шүүхээс гаргуулж, орон нутгийн иргэдэд зөвлөн тусалж байгааг тэмдэглүүштэй.



ШУДАРГА ЁСНЫ ТОГТОЛЦООНЫ ШИНЭТГЭЛ

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь

(2008-2024)

Нээлттэй Нийгэм Форумын 2008 оны шинэчлэгдсэн стратегид нэгэн том сэдэв нэмэгдсэн нь шүүхийн хараат бус байдал байлаа. Монгол Улсын шинэ Үндсэн хуульд шүүх эрх мэдэл нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлтэй эн тэнцүү засаглалын багана хэмээн тодотгосон хэдий ч тус институцын бие даасан байдал хангагдаагүй, хараат бус байдалд нь итгэх олон нийтийн итгэл маш доогуур байлаа. Энэ нь Сант Марал сангийн 2007 оны олон нийтийн төсөөллийн судалгаанаас тод харагдаж байсан бөгөөд хамгийн их авлигад идэгдсэн байгууллагуудын тоонд удаа дараа эхний байруудад жагсаж байв.

Энэхүү нөхцөлд бид юуны өмнө тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг чухалчлан шинжилгээ, мониторинг хийх үндсэн дээр бодит байдлыг аль болох бүрэн дүүрэн үнэлэхийг зорьсон билээ. 2008 онд АНУ-ын Барын холбооны арга зүйд үндэслэн шүүх эрх мэдлийн шинэтгэлийг явцыг үнэлэх судалгааг АНУ-ын Аризонагийн их сургуулийн профессор Брент Уайттай хамтран гүйцэтгэж “Голдоо ортол ялзарсан уу” сэдэвт тайланг хэвлэн нийтэлсэн нь шүүхийн сэдвээр гарсан анхны бие даасан хөндлөнгийн судалгааны ажил болсон юм. Эдүгээ ч энэхүү тайлан ач холбогдолтой хэвээр, олон улсын болон дотоодын судалгаанд эшлэгдсээр байна.

2010-аад онд нэг талаас шүүхийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт төсөөлөл хомсхон, нөгөө талаас шүүх ч

иргэдэд үйлчилгээ үзүүлэх байгууллага болохын хувьд үйлчилгээний стандарт, орчны нөхцөл байдал нь хангалтгүй байгааг баримтжуулах, засаж сайжруулах боломж бололцоог эрэлхийлэх шаардлага үүсэв. Тиймээс бид Польшийн хүний эрхийн Хельсинкийн хорооны арга зүйн дэмжлэгтэйгээр 2010 онд “Шүүхийн ажиглалт” хийсэн нь шүүхэд өргөн хүрээний хөндлөнгийн ажиглалт хийсэн анхны тохиолдол байлаа. Отгонтэнгэр, Шихихутаг, МУИС-ийн хууль зүйн сургуулийн оюутнууд, орон нутгийн төрийн бус байгууллагын ажилтнууд нийслэлийн зургаа, орон нутгийн гурван шүүх дээр 12 долоо хоногийн туршид шүүхийн үйл ажиллагааг ажиглаж, дэлгэрэнгүй асуумжийн дагуу баримтжуулалт хийв. Нийт 287 анхан шатны эрүүгийн шүүх хуралдаан ажиглаж шүүх хуралдаан хаалттай явагдсан эсэх, шүүхийн байр танхимын эмх цэгц, хүндэтгэл төрүүлэхүйц байдал, мөн харилцаа хандлага нь ямар байсныг баримтжуулсан нь шүүхийн захиргаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгоход багагүй хувь нэмэр оруулсан билээ.

Энэхүү ажиглалтыг 2014, 2017 онд давтан гүйцэтгэсэн нь шүүхийн захиргаа хэрхэн шинэчлэгдэж буйг баримтжуулснаар шинэчлэлтийн явцыг үнэлэх ач холбогдолтой байв. 2018 онд Шүүхийн ажиглалтын гарын авлагыг бэлтгэн нийтэлсэн нь өнөөдөр ч шүүх хуралдаан ажиглахад удирдамж болохуйц монгол хэлээр гарсан арга зүйн гол эх сурвалж хэвээр байна.

ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2009 онд Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх сэдвээр судалгааны төсөл шалгаруулан доктор профессор Ж.Амарсанаа, доктор профессор Н.Лүндэндорж нарын ахалсан багууд шүүхийн шинэтгэлийн 20 жилийн тойм судалгаа болон шүүхийн хараат бус байдлын үнэлгээ хийсэн нь дотоодын судлаачдын бие даасан бодлогын томоохон судалгаанууд болсон юм. Улмаар бид 2015-2021 онд шүүх эрх мэдлийн хүрээний бодлогын дүн шинжилгээг дэмжиж хэд хэдэн судалгаа захиалан гүйцэтгүүлсэн нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, 2021 оны шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг боловсруулахад чухал эх сурвалж болж ашиглагдлаа.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгох нь шүүхийн шинэтгэлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг байв. ННФ нь шүүхийн үйл ажиллагаанд иргэдийн шууд оролцооны энэхүү сувгийг үр нөлөөтэй болгоход багагүй хүчин чармайлт гарган тал бүрийн дэмжлэг үзүүлээ. 2010 онд ННФ-ын дэмжлэгээр холбогдох талууд БНСУ-ын туршлагыг газар дээр нь судалсан, тэрчлэн олон улсын туршлагыг харьцуулсан дүн

шинжилгээнүүд хийгдсэн зэрэг нь 2013 онд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай шинэ хууль боловсруулахад чухал эх сурвалж болсон юм. Энэ хүрээнд шүүхийн иргэдийн төлөөлөгчид тохиолдлын журмаар сонгогдон анхан шатны шүүх хуралдаанд оролцох тогтолцоо бүрдсэн билээ. Тэрчлэн, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гарын авлага боловсруулах, сургалт, сурталчилгааны контент бэлтгэхэд Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-д дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллав.

Шүүх эрх мэдлийн хүрээг хамарсан бодлогын судалгаа шинжилгээнүүдээс үзэхэд шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт шаардлагатай талаар цөөнгүй дүгнэлт хийгдсэн байдаг. Ийнхүү 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд шүүхийн хараат бус байдлыг сайжруулахад чиглэсэн чухал шинэчлэл тусгалаа олсон бөгөөд олон нийт, тэр дундаа залуучуудын дуу хоолойг сонсгох өргөн хүрээний нөлөөллийн цогц үйл ажиллагаа үүнд чухал нөлөө үзүүлсэн юм. Бодлогод залуусын хяналт ТББ-ын манлайлал дор явагдсан энэхүү олон нийтийн оролцоо нь шүүх эрх мэдлийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой байв.

Шүүх эрх мэдлийн сэдвээр гаргасан судалгаанууд:

- *Шүүхийн захиргааны бие даасан байдал*
- *Шүүхийн томилгооны хараат бус байдал*
- *Шүүгчийн хараат бус байдлын баталгаа*
- *Шүүхийн тойргийн тогтолцооны үр нөлөөний үнэлгээ зэрэг орно.*

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2019 оны 11 дүгээр сард батлагдсанаар Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Шүүхийн Сахилгын хороо (ШСХ)-ны статус, бие даасан байдал бэхжих суурь тавигдаж, шүүхийг тойргийн болон дагнасан журмаар байгуулах боломж нээгдлээ. Улмаар зөвхөн Ерөнхийлөгчид төвлөрсөн байсан шүүхийн томилгооны эрх мэдлийг задалж, Улсын Их Хурал ШЕЗ болон ШСХ-ны томилгоонд оролцохоор хуульчлагдав. Мөн шинээр байгуулагдсан ШЕЗ, ШСХ-ны шүүгч бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг олон нийтийн анхаарлын төвд оруулах, процессыг нь нээлттэй, хяналт тавих боломжтой болгох, иргэний нийгмийн оролцоог хангахад чиглэсэн нөлөөллийн аян өрнүүлсэн нь томилгооны сонголыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлсэн болов уу.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн араас 2020 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг эхэлсэн бөгөөд ННФ энэхүү бодлогын хэлэлцүүлэгт идэвхийлэн оролцож, хуулийн төсөл дээр олон талын байр суурийг сонсох хэлэлцүүлэг зохион байгуулж, судалгааны хүрээнд боловсруулсан бодлогын зөвлөмжүүдээ хуульд тусгуулж чадлаа. Ийнхүү 2012 онд хийгдсэн эрх зүйн орчны зарим ахиц дэвшлийг хадгалах, алдаа дутагдлыг засахад чиглэсэн эрх зүйн шинэтгэл өрнөн 2021 оны 3 дугаар сард Шүүхийн тухай хууль батлагдан гарав. 2015-2017 онд хийгдсэн бодлогын судалгаа, шинжилгээний үр дүн 2019-2021 оны эрх зүйн шинэтгэлийн чухал эх сурвалж болсон нь бидний хувьд бахархалт үйл явдал бөгөөд бид дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, цаашид боловсронгуй болгох, аливаа хэлбэрийн үхралтаас сэргийлэх чиглэлд үргэлжлүүлэн ажиллаж байна.

Шүүхэд итгэх олон нийтийн итгэл нь шүүхийн талаар тэдний авч буй мэдээлэл, түүний үнэн зөв, тэнцвэртэй байдлаас шууд хамааралтай байдаг. Олны анхаарлыг татсан ямарваа хэрэг маргаан шүүхээр шийдвэрлэх

үед л хэвлэл мэдээллийн хэрэгслүүд идэвхтэй ажиллахаас бусад үед шүүхийн талаар сурвалжлах нь хомс хэвээр байна. 2011 онд Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран “Шүүхийн шинэтгэл – Хэвлэл мэдээлэл” төсөл хэрэгжүүлэн сэтгүүлчдэд орон нутгийн шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломж олгож, шүүхийг сурвалжлах сургалтыг олон улсын зөвлөх багш нарын оролцоотойгоор зохион байгууллаа. Энэхүү хамтын ажиллагааг 2019 оноос сэргээн сэтгүүлчдийн дунд өглөөний уулзалт зохион байгуулж шүүх эрх мэдлийн хүрээнд гарсан шинэ судалгааг танилцуулж, мөн нөлөөллийн үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг зохион байгуулж ирсэн нь бодлогын нөлөөллийн үр дүнтэй сувгийн нэг боллоо.

Шүүх эрх мэдлийн хүрээн дэх бодлогын нөлөөллийн зэрэгцээ шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын чадавхыг дээшлүүлэхэд техникийн туслалцаа үзүүлж ирсний зарим жишээг дурдвал, шүүхийн захиргааны ажилтнууд, тэр дундаа шүүхийн зохион байгуулагчдыг чадавхжуулах сургалтыг 3 жил дараалан зохион байгуулж, хүний нөөцийн удирдлага, шүүхийн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч ажиллав. 2016 онд Шүүхийн захиргааны ажилтнуудыг БНСУ-д суралцах аялалд хамруулсан нь тэдний хувьд шүүхийн үйлчилгээний хүртээмж, нөхцөлийг сайжруулах бодит ажил санаачилж хэрэгжүүлэхэд нь үр нөлөөтэй арга хэмжээ болов.

Шүүхийн захиргаа, үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэхээс гадна шүүхийн үндсэн үүрэг болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, гарч буй шүүхийн шийдвэр бүр нь үндэслэлтэй, ойлгомжтой, хуулийн дагуу байх нь нэн чухал билээ. Түүнчлэн гарсан шийдвэрүүдийг эргэж шинжлэн дүгнэх, эргэлзээтэй зүйл, шийдвэрийг нягтлан шинжилж, цаашид шийдвэр гаргахад анхаарч ашиглах нь шүүхийн шийдвэр шударга, үнэн зөв байх, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг

нэмэгдүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй болой. Тиймээс ННФ “Шүүхийн шийдвэрийн судалгаа төсөл”-ийг сүүлийн 7 жилийн туршид хэрэгжүүллээ. 2020 онд энэхүү судалгааны ажлыг эрхлэх редакцын зөвлөлийг эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлээр судалгааны болон практик туршлагатай тэргүүлэх мэргэжилтэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд судалгааны сэдвийг тодорхойлох, судалгааны багийг сонгон шалгаруулах, судлаачдаас хэвлэн нийтлүүлэхээр ирүүлж буй шүүхийн шийдвэрийн судалгааны тайлангийн шүүмж бэлдэх, редакторлах зэрэг ажлыг энэхүү зөвлөл мэргэжлийн, хараат бус түвшинд гүйцэтгэж ирэв.

Шүүхийн шийдвэрийн судалгааны цувралууд нь эрх зүйн мэргэжлээр суралцаж буй оюутнууд, мөн энэ салбарт ажиллагсад эрэлттэй бүтээл болсны зэрэгцээ шүүхийн шийдвэрийн судалгааны арга зүй туршигдан нэвтэрч, энэ төрлийн судалгаа түгээн дэлгэрэхэд түүштай дэмжлэг, түлхэц болсныг тэмдэглэх нь зүйд нийцнэ.

2013 онд шүүхийн шинэтгэлийн хүрээнд гарсан чухал дэвшлүүдийн нэг нь шүүхийн шийдвэрийн цахим сан бий болсон явдал байв. Тус санг бүтээсэн нь Монгол Улсын шүүхийн ил тод

байдлыг нэмэгдүүлэх хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг болж буйг Шүүхийн индексийн дүнгээс харж болно. Дээр дурдсан шүүхийн шийдвэрийн судалгааг хийхэд шаардлагатай мэдээллийг тус сангаас авч байгаа нь үндсэндээ шүүхийн шийдвэрийн ил тод байдалд үнэлгээ өгөх давхар үүрэг гүйцэтгэсэн буюу мэдээллийн бүрэн бүтэн байдлыг нягтлахад чухал ач холбогдолтой болсон юм. Олон тохиолдолд судлаачид шүүхийн шийдвэрүүд бүрэн бус, бичилт нь жигд бус байгааг шүүхийн шийдвэрүүдийг шүүн түүвэрлэх явцдаа олж тогтоож байсан нь бидний зүгээс шүүхийн шийдвэрийн цахим санд тусгайлан мониторинг хийх үндэслэл болж, 2022, 2024 онд хэрэгжүүлсэн мониторингийн үр дүнд цахим сангийн журам шинэчлэгдлээ.

Ийнхүү шүүхийн институт өнгөрсөн 20 жилийн хугацаанд томоохон шинэтгэлийн давлагаанд өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа ч шүүхэд итгэх олон нийтийн итгэл төдийлөн нэмэгдэхгүй, аливаа шүүмжлэл ч тасрахгүй үргэлжилсээр байна. Шүүхийн өөрчлөлт шинэчлэлийн үйл явцыг олон талаас нь аль болох бодит байдлаар үнэлж, холбогдох талууд болон олон нийтэд хүргэх, бодлогын шийдвэрийн

“Шүүхийн шийдвэрийн судалгаа төсөл”-ийн хүрээнд 60 гаруй судалгаа хийгдэж, үр дүнг нь нэгтгэсэн 18 цуврал тайлан хэвлэгдэж шүүгчдийн гарт хүрлээ.

ШҮҮХИЙН



үндэслэлийг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулахыг эрмэлзэн ННФ 2018 онд Шүүхийн индексийн судалгааны арга зүйг боловсруулж эхэлсэн бөгөөд 2021 оны мэдээлэлд суурилсан анхны индексийн дүн 2022 онд танилцуулагдсанаар шүүхийн салбарт хараат бус хөндлөнгийн цогц үнэлгээний шинэ арга хэрэгсэл бий боллоо. Энэхүү судалгааны арга зүйг олон улсын туршлага, үндэсний зөвлөхүүдийн санал зөвлөмжид үндэслэн зургаан үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүн 108 шалгуур үзүүлэлтэй байхаар боловсрууллаа. Судалгааны

ИНДЕКС



мэдээллийг олон нийтийн санал асуулга, хуульч мэргэжилтнүүдийн санаа бодлын судалгаа, захиргааны статистик мэдээлэл гэсэн үндсэн гурван эх сурвалжаас цуглуулан 100 хүртэлх оноогоор үнэлэн үр дүнг гаргаж байна. Шүүхийн салбарын бодлогын баримт бичигт эшлэгдэн, салбарынхны дунд нэгэнтээ хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж болж байна. Шүүхийн индексийн энэхүү судалгааг бид цаашид дотоодын судлаач шинжээчдийн оролцоотойгоор хоёр жил тутамд гаргаж танилцуулах юм.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэл

(2012-2024)

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үр нөлөө нь зөвхөн шүүхийн тухай хуулийн өөрчлөлт төдийгүй мөн шүүхэд хэрэглэх бусад хуулийн шинэчлэлтийн үр дүнд бий болно. Иймээс Монгол Улсын Засгийн газар 2012 онд шүүхийн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлсэн билээ. Үүнд, шүүхийн өмнөх болон дараах шатны процессын хуулиуд, эдгээр процесст оролцогч талуудын эрх зүйн байдлыг зохицуулсан тусгайлсан хуулиуд, Эрүүгийн хуулийг үзэл баримтлалын түвшинд эргэн харж шинэчлэн найруулах ажлыг хамруулав.

ННФ энэхүү шинэтгэлийн үйл явцад манлайлан оролцож, тухайн үеийн эрүүгийн эрх зүйн судлаач, тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх баг бүрдүүлэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн байгууллагын тухай, Цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Мөрдөх албаны тухай хуулиудын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-д хүлээлгэн өгсөн нь цаашид энэ салбарын хууль тогтоомжийн талаар шүүмж санал өгөх нөр их ажлын эхлэл байлаа.

Бид шинэ тутам батлагдсан хууль сахиулах салбарын хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийг зорьж ХЗДХЯ-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, 2013-2017 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлж Цагдаагийн албаны, Гэрч хохирогчийг хамгаалах, Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, Тахарын албаны тухай хуулиудын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлсэн юм. Энэ хүрээнд олон улсын 80 гаруй жишиг стандарт, дүрэм журмыг орчуулан Цагдаагийн ерөнхий газар, Тахарын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны

төвийн үйл ажиллагаанд мөрдөх дотоод дүрэм журмууд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих болон туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Иргэний зөвлөл, Олон нийтийн цагдаагийн дүрэм, алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын сургалтын хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлж, холбогдох сургалт зохион байгуулав.

ННФ болон ХЗДХЯ-ны түншлэлийн хүрээнд цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний шинэлэг арга зүйг боловсруулан, иргэд хэрхэн үнэлж буйг судлах, хууль сахиулах ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, хууль сахиулагчдыг чадавхжуулахад техникийн туслалцаа үзүүлэх зэрэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ээлтэй болгоход чиглэсэн санал санаачилга хэрэгжүүлэв. Хэдийгээр манай улсад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа төдийлөн нээлттэй бус байдаг ч хөндлөнгийн мониторинг нь цагдаагийн албыг олон нийтэд ойлгуулах, үйл ажиллагааг нь сайжруулахад чухал үүрэгтэйг харгалзан иргэний нийгмийн байгууллагуудад тэтгэлэг олгож, мониторингийн арга зүйн цогц сургалт зохион байгуулсны үр дүнд цагдаагийн төв байгууллага болон орон нутгийн цагдаагийн үйл ажиллагаанд нийт 63 удаагийн мониторинг хийсэн байна.

Эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулахад анхаарч хэвлэл мэдээллийн кампанит ажил өрнүүлэх, бүсчилсэн сургалт явуулах, видео шторк, хэвлэмэл танилцуулга бэлтгэн түгээх, бэсрэг жүжиг тайзнаа тавих зэрэг бүтээлч ажлыг мөн хэрэгжүүлж байв. Глоб интернэшнл Төв, Улсын драмын эрдмийн театр (УДЭТ)-тай хамтран бүтээсэн

“Хуулийн өмнө”, “Наран цамхгийн хэрэг”, “Манаач” зэрэг жүжиг нь мөн дэлгэцийн бүтээлд хувирч үндэсний олон нийтийн телевизээр нийтийн хүртээл болсон билээ.

2014 оноос эрчимжиж эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдсан багц хуулийн төсөлд эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг тусгахад дэмжлэг үзүүлэхийг зорьж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Гэмт хэргийн болон Таслан сэргийлэх арга хэмжээний тухай зэрэг зургаан хуулийн төслийн хэлэлцүүлгийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэлэлцүүлгийн үеэр хөндөгдсөн асуудлууд, гаргасан зөвлөмжүүдийг “Хуулийн шүүмж”, “Чухал сэдэв” зэрэг хэвлэн нийтлэлийн бүтээгдэхүүнээрээ дамжуулан олон нийтэд хүргэж байв. Тэрчлэн эрх зүйн шинэчлэлийн маргаантай хурц асуудлаар өөр өөр үзэл бодолтой экспертүүд мэтгэлцэхийн зэрэгцээ оролцогчдын асуултад хариулах хэлэлцүүлгийн хэлбэрийг өргөн ашиглаж Монголын хуульчдын холбоотой хамтран “Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү”,

“Шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь буруу” зэрэг сэдвээр анх мэтгэлцээн зохион байгуулж, мэтгэлцээний товчилсон тэмдэглэлээр “Чухал сэдэв” хэвлэлийн бүтээгдэхүүн гаргасан нь цаг үеийн чухал асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах бүрд шинэ дугаараар олон нийтэд хүрч байна.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн нэг томоохон асуудал бол гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг оновчтой болгох, гэмт хэргийн үндэсний статистикийг олон улсын статистикийн ангилалтай нийцүүлэх явдал билээ. ННФ-ын санаачлан дэмжсэн Монголын Криминологичдын Холбооноос 2016, 2017, 2018 онд гаргасан “Гэмт хэргийн цагаан ном” судалгаа жилээс жилд чанаржиж, агуулга, хүрээ нь тэлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой бодлого тодорхойлоход ашиглах чухал эх сурвалж боллоо. Гурван жил тутамд хийж гүйцэтгэх тус судалгааны арга зүй боловсруулагдаж, эдүгээ ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үргэлжлүүлэх болсон нь цаашид энэ чухал судалгаа тогтвортой гарах боломжийг бүрдүүлээ. Мөн ННФ-ын

Глоб интернэшнл төв ТББ болон УДЭТ-ын хамтран бүтээсэн “Хуулийн өмнө” жүжгийн тоглолт (2015 он)



*2020 онд эхэлсэн
“Хохирлын тогтолцоо”
кампанит ажил
эрчимжиж, бэлгийн
халдашгүй байдал, эрүүл
мэнд, хүрээлэн буй орчны
эсрэг болон хүн алах,
авлигын гэмт хэргийн
асуудлаарх видео,
постер, нийтлэлүүд
олны хүртээл болов.*

захиалгаар хийж гүйцэтгэсэн “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний статистиктай нийцүүлэх боломж” сэдвийн хүрээнд Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллын ойлголт, түүний 11 бүлэг үзүүлэлтийн тухай ерөнхий тоймыг танилцуулсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн нь гэмт хэргийн үндэсний статистикийг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, зарчимтай нийцүүлэх, уялдаа холбоог сайжруулах, олон улсын болон үндэсний хэмжээнд дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах ач холбогдолтой судалгаа болсон юм.

Бид өнгөрсөн хугацаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, өршөөлийн хуулиудын дүн шинжилгээ, нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, хорихоос суллагдсан этгээдэд тавих захиргааны хяналт, бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал, гэрч хохирогчийн хамгаалалт, эрүүгийн хуульд шинээр оруулсан гэмт хэргийн шийдвэрлэлт, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, зөвшөөрлийн зохицуулалт зэрэг эрх зүйн шинэчлэлийн зарим бодлогыг үнэлж, маргаантай зарим асуултад хариулт өгсөн 30 гаруй судалгаа захиалж

хийлгэсэн нь салбарын бодлогыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хохирогчийн эрх зүйн хамгаалалт, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн барагдуулалт сайжирна хэмээх олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын хүлээлт биеллээ төдийлөн олсонгүй. Тиймээс хохирол барагдуулах үйл ажиллагаатай холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт зэрэг цуврал судалгааг олон нийт, шийдвэр гаргагчдад хүргэж, цуврал бодлогын хэлэлцүүлэг өрнүүлснээр хохирол барагдуулах асуудалд холбогдох талуудын анхаарлыг хандуулж чадсан юм.

Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд батлагдан мөрдөгдөөд багагүй хугацаа өнгөрч байгаа ч энэ асуудлаар нийгэмд багагүй маргаан мэтгэлцээн өрнөсөөр байгаа билээ. Эдгээр хуульд суурь судалгаа хийлгэн, судалгааны үр

дүнг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэх, хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт боловсруулах ажлын хэсгийн гишүүд АНУ-д туршлага судлахад санхүүжилт олгох зэргээр дэмжлэг үзүүлээ.

Шинээр үйлчилж эхэлсэн эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийн талаарх хуульч, хууль сахиулагчдын ойлголт мэдлэг хангалтгүй байгааг харгалзан Монголын хуульчдын холбоо, ХЗДХЯ-тай хамтран эрүүгийн хууль тогтоомжийн талаарх сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг эхлүүлэв. Энэ хүрээнд МХХ “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн зохицуулалт, онцлог”, “Эрүү шүүлт”, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагааны онцлог” зэрэг сэдвээр хуульчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулсны дагуу сургалт хийгдэж байна. ННФ-ын МХХ-той хамтран зохион байгуулсан цуврал хэлэлцүүлэг нь хууль тогтоомжийн хийдлийг арилгах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. МХХ-ноос зохион байгуулдаг Хуульчдын форум арга хэмжээг анх

зохион байгуулагдахаас эхлэн агуулга, зохион байгуулалтын хувьд дэмжихийн зэрэгцээ Монгол Улсад хуульч бэлтгэх тогтолцоо, хуульчдын өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх чиглэлийн харьцуулсан судалгаа хийх зэргээр тус байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэхэд зохих хувь нэмэр оруулж ирсэн нь хуульч мэргэжилтнүүдийн дуу хоолойг бодлогын түвшинд хүргэх, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд тус нэмэр болсон гэж найдаж байна.

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, бие даасан судалгаа, мониторингийн үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд иргэний нийгмийн бодит оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “5 хуулийн эвсэл”-ийг байгуулж нөлөөллийн ажил зохион байгуулж байв. Энэ чиглэлд хот болон орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын чадавх, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс шаталсан сургалт зохион байгуулж 3 жилийн хугацаанд 21 аймгийн 300 гаруй төрийн бус байгууллагыг хамруулсан нь нөлөөллийн ажлын цар хүрээг нэмэгдүүлсэн чухал үйл ажиллагаа байлаа.

МХХ-той хамтран зохион байгуулсан эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын талаарх цуврал хэлэлцүүлэгт 300 орчим хуульч, хууль сахиулагч, төрийн бус байгууллагын ажилтнууд оролцож, 90 нийтлэг санал, 266 тусгай санал гарган, тулгамдаж буй олон асуудлыг тодорхойлов.

Эрх зүйн туслалцаа

(2004-2011)

Монгол Улсад ядуурлын түвшин өндөр байснаас үүдэн 2004-2011 оны үед нэг талаас, гэмт хэрэгт холбогдох иргэд олон; нөгөө талаас хэрэгт холбогдсон иргэдийн дийлэнх нь төлбөрийн чадваргүйн улмаас эрх зүйн туслалцаа авах боломж хомс байв. Гэмт хэрэгт шалгагдаж буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цаг алдалгүй, эрх зүйн чанартай туслалцаа авах боломж бололцоо хомс байх нь олон улсын түвшинд хүний суурь эрхийн зөрчилд тооцогддог. Дээрх нөхцөл байдлыг харгалзан ННФ нь Нью-Йорк хотноо төвтэй Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Шударга ёсны хүртээмж хөтөлбөртэй хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх” төслийг 2004 онд санаачлан 2011 он хүртэл амжилттай хэрэгжүүлсэн билээ. Үүний үр дүнд томоохон доноруудын анхаарал, дэмжлэгтэйгээр төлбөрийн чадваргүй иргэд эрх зүйн туслалцаа авах Үндэсний тогтолцоо бүрдэн өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа нь тасралтгүй явагдаж ирлээ.

ННФ 2004 оноос буюу төслийн эхний шатнаас ХЗДХЯ-тай нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулах ажлыг эхлүүлэн холбогдох судалгаа, олон улсын сайн туршлага судлах, туршилтын төсөл хэрэгжүүлэх зэргээр шинэ тутам тогтолцооны үр нөлөөг баримтжуулах, баталгаажуулахад хүч чармайлт гарган ажилласны үр дүнд 2006 оны 12 сард Монгол Улсын Засгийн газар тус Үндэсний хөтөлбөрийг баталсан юм. 2006-2012 онд хэрэгжсэн энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хууль зүйн туслалцааны үндэсний тогтолцооны бодлогын суурь баримт бичиг буюу хууль зүйн

туслалцааны тухай хууль батлах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Эрх зүйн туслалцааны хүрээнд төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн түвшинд иргэд эрх зүйн мэдээлэл, лавлагаа авах тогтолцоо бий болгох, хууль зүйн клиник сургалтыг бэхжүүлэх, өмгөөллийн про боно үйлчилгээг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааг хамааруулан авч үздэг бөгөөд ННФ энэ бүх чиглэлд бодлого, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлж байв.

ННФ 2004 оны 5 сард Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх туршилтын төвүүдийг Хэнтий аймаг болон Сонгинохайрхан дүүрэгт байгуулан ажиллуулснаас хойш дөрвөн жилийн хугацаанд эдгээр төвийн туршлагад үндэслэн ийм төрлийн 30 төвийг үндэсний хэмжээнд байгуулан өмгөөлөгчдийн чадавх дээшлүүлэх сургалт зохион байгуулах, өмгөөлөгчийн гарын авлага, төвийн үйл ажиллагаанд баримтлах удирдамж, стандарт боловсруулах зэргээр дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ дээрх төвүүдийн цалин хангамж, захиргааны зардлыг бүрэн санхүүжүүлж өнөөдрийн хууль зүйн туслалцааны төвийн тогтолцооны суурийг тавьсан билээ.

2009 онд НҮБХХ-өөс эхлүүлсэн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх” төслийг хэрэгжүүлэхэд НҮБХХ болон ХЗДХЯ-тай гурван талт хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурснаар энэхүү үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бэхжүүлэх боломж бүрдсэн. Улмаар 2013 онд “Төлбөрийн чадваргүй

яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль батлагдсанаар Хууль зүйн туслалцааны төвийн тоо 35-д хүрч, дан ганц төрийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь төслийн хувьд томоохон амжилт, үр дүн байлаа. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд дунджаар шүүхээр шийдвэрлэгдсэн нийт эрүүгийн хэргийн 40 орчим хувьд хууль зүйн туслалцаа үзүүлж, хамгийн ачаалал өндөртэй төрийн үйлчилгээний нэг болжээ.

2022 оны 7 сард “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль нь “Хууль зүйн туслалцааны тухай” хууль хэмээн шинэчлэгдэн найруулагдсан бөгөөд шинэ хуулиар тус төв төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагчаас гадна бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид, гэмт хэргийн улмаас хохирсон насанд хүрээгүй хүн; мөн үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн төлбөрийн чадваргүй иргэд захиргааны хэргийн оролцогч бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авахаар болж тогтолцоо хүрээгээ тэлээд байна.

Орон нутагт эрх зүйн мэдээлэл лавлагаа өгөх чиг үүргийг Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын хуулийн хэлтэст хариуцуулан ажлын байрны тодорхойлолтыг батлуулж, холбогдох гарын авлага гарган сургалт зохион байгуулснаар уг тогтолцоо институтчилэгдсэн юм. Энэ хүрээнд эрх зүйн хөтөч

буюу иргэдэд нэн шаардлагатай эрх зүйн зөвлөгөө мэдээллийг багтаасан лавлагаа гарын авлага, цахим хуудас зэргийг бэлтгэн, орон нутгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн ажилтнуудыг сургаж иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг эрчимжүүлсэн билээ. Энэхүү суурь тогтолцоонд үндэслэн 2016-2020 онд Олон улсын байгууллагын санхүүжилттэй Эрх зүйн хөтчийн тогтолцоог бэхжүүлэх төсөл амжилттай хэрэгжүүлснийг “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь” төслийн танилцуулгаас дэлгэрүүлэн үзэж болно.

Хууль зүйн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд хууль зүйн дээд боловсролын байгууллагуудын үүрэг их билээ. Монголын Нээлттэй Нийгэм хүрээлэн (Соросын сан)-гийн үед Монгол Улсын Их Сургуулийг түшиглэн байгуулсан Хууль зүйн клиник сургалтын жишиг төвийн загвараар бусад хууль зүйн дээд боловсрол олгох улсын болон хувийн сургуулиудад клиник сургалтын төв байгуулах, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх эрхийг шинээр байгуулагдсан Монголын хуульчдын холбоонд шилжүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү сургалтын хөтөлбөрийн хүрээнд хуулийн сургуулийн оюутнууд багшийн удирдлага, хяналтын дор иргэдэд анхан шатны эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх ажил өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь

(2016 – 2020)

Ардчилсан нийгэмд иргэдийн эрх зүйн чадамж өндөр байх нь ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх, засаглалыг сайжруулахад чухал нөлөөтэй ажээ. ННФ иргэдийн хэрэгцээнд суурилсан, баталгаатай, тогтвортой хууль зүйн анхан шатны туслалцаа, эрх зүйн албан бус боловсрол, мэдээлэл олгох тогтолцоог албан ёсоор бий болгоход нөлөөлөл, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь” төслийг 2016 оноос эхлэн дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлсэн юм. Тус төсөл нь Нээлттэй Нийгэм Сангуудаас 2020 он хүртэл хэрэгжсэн олон улсын санаачилгын хүрээнд эрх зүйн тогтолцоо, эдийн засгийн чадавх, газар зүйн байрлал зэргийг харгалзан сонгосон 10 улсад олон талын төлөөллийг оролцуулан нэгэн зэрэг хэрэгжсэн бөгөөд эдгээр улс түршлага арга зүйгээ солилцох, харилцан дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллах боломжтой байлаа.

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үйл явц нь нэг талаас иргэдийн мэдээлэл хайх, эрэлхийлэх, олж авах эрхийг нь баталгаажуулах замаар эрх зүйн хүрээнд бий болсон боломжийг мэдэхэд нь туслах; олж авсан мэдээллээ ашиглан хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадвар, нөхцөл боломжоор хангах; хуулийн хүрээнд эрх ашгаа хангуулах, хамгаалуулах; аливаа бэрхшээл тохиолдсон үед зөрчигдсэн эрхээ нэхэмжлэх чадвар, боломжоор хангагдах; нөгөө талаас хууль, бодлогын хүрээнд гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдсөн үед иргэд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцож үзэл бодол, байр сууриа илэрхийлж сонгох зэргээр эрхээ хэрэгжүүлэх харилцан хамааралтай процесс юм.

Төслийн хүрээнд юуны өмнө иргэдийн эрх зүйн мэдлэгийн хэрэгцээ шаардлага, эрх зүйн чадавхын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлохыг зорьж үндэсний хэмжээний судалгаа явуулж, иргэдэд хамгийн хэрэгцээтэй эрх зүйн мэдээлэл, мөн тус мэдээллийг олж авах тохиромжтой суваг байгаа эсэх зэргийг тодорхойлов. Судалгааны дүнгээр оролцогчдын 54.8 хувьд нь ямар нэг хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл учирсан байх хэдий ч тэдний тал нь ямар алхам хийхээ мэдэхгүйгээс тулгарсан асуудлаа шийдвэрлэхгүй орхиж байгаа дүр зураг харагдсан билээ.

Иргэдэд тохиолддог нийтлэг бэрхшээл (судалгааны дүн)



Улмаар дээрх судалгааны дүн, түүний дагуу хийсэн нөлөөллийн үр дүнд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Бүх нийтийн эрх зүйн боловсрол чадавхыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдав. Үүний дагуу ННФ-ын санхүүжилтээр үндэсний хөтөлбөрийн төслийг бүх нийтээр хэлэлцүүлэхээр нийт аймаг, хот, сум, дүүргийн төлөөллийг оролцуулан 1000 гаруй иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөрт тусгах тодорхой санал, зөвлөмжийг хүлээн авч нэгтгэх ажлыг зохион байгууллаа. 2016 онд ХЗДХЯ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, бусад улсын сайн түршлагатай танилцах, орон даяар ашиглах эрх зүйн цахим хөтөч (www.e-khutuch.mn) бүтээхийн сацуу орон нутагт хөтөч хувь хүмүүсийг сургаж бэлтгэх, анхан шатны мэдээлэл хүргэх түршилтын төсөл хэрэгжүүлэх зэрэг ажлыг тус санамж бичигт тусгасан юм.

ХЗДХЯ-тай түншлэн хэрэгжүүлсэн түршилтын төсөл болон нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд Монгол Улсын Засгийн газар 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг эцэслэн баталлаа. Тус хөтөлбөр нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдлэг, мэдээллийг энгийн ойлгомжтой хэлбэрээр бэлтгэн боловсруулж, цахим болон хэвлэмэл хувилбараар нээлттэй, хүртээмжтэй болгох замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилго дэвшүүлэн таван жилийн хугацаанд хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөгдөв. Бид хөтөлбөр боловсруулалтын эхний шатнаас хүчин чармайлт гарган ажиллаж тус хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд эрх зүйн цахим хөтөч бий болгох, мөн орон нутагт эрх зүйн хөтөч сургаж бэлтгэх гэсэн үндсэн хоёр үйл ажиллагааг дэмжин санхүүжүүлж, алсдаа төсвийн санхүүжилтээр төрийн үйлчилгээний төрөл

болгон институтчилэх хэтийн зорилготой ажиллалаа.

Эрх зүйн цахим хөтөч нь эрх зүйн албан ёсны мэдээллийг нэг дороос, цагийн хязгаарлалтгүй, хурдан шуурхай олж үзэх цахим платформ юм. Бид Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ)-тэй дөрвөн жилийн хугацаанд хамтран ажилласны дүнд цаг хугацаа, зардал мөнгө хэмнэх эрх зүйн цахим хөтөч (www.e-khutuch.mn)-ийг бүтээсэн билээ. Энэхүү цахим хуудсаар хамгийн эрэлттэй байгаа эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөг бэлтгэн нийтэд хүргэхээс гадна эрх зүйн сургалтад ашиглагдах гарын авлага, танилцуулга, видео контент байрлуулан эрх зүйн сургалт сурталчилгаа явуулах хүсэлтэй хэн бүхнийг найдвартай мэдээлэл, контентоор хангахыг зорьж байв. Ийнхүү төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн иргэдийн эрх зүйн хэрэгцээ шаардлагын судалгаанд (2016) үндэслэн хамгийн эрэлттэй 20 гаруй сэдвээр хууль ёсны агуулгыг ойлгоход энгийн, ашиглахад хялбар байдлаар боловсруулан орон даяар, цагийн хязгаарлалтгүй хандаж болох цахим сан бий болгосон нь энэхүү хөтөлбөрийн томоохон үр дүн байв. Бидний зүгээс 2020 оныг дуустал цахим хөтчийн техникийн хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг ХЗҮХ-д үзүүлж, 2021 оноос төрийн санхүүжилтээр үргэлжлүүлэхээр ХЗДХЯ-нд хүлээлгэн өгсөн билээ.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хоёр дахь чухал хэсэг болох орон нутагт эрх зүйн хөтөч нарыг сонгон, сургаж бэлтгэх ажлын хүрээнд бид түршилтын журмаар Хэнтий, Сэлэнгэ аймгийг сонгон, 46 суманд нийт 118 эрх зүйн хөтөч сургаж бэлтгэсэн бол төслийн төгсгөлд нийт 7 аймагт 600 гаруй эрх зүйн хөтөчтэй болсон байв. Түршилтын төслөөр сонгогдсон хоёр аймгийн нийт сумын ЗДТГ-т эрх зүйн хөтчийн булан байгуулан, интернэтэд холбогдсон төхөөрөмжөөр тоноглон цахим хөтчид хандан мэдээлэл авах

боломж, хүртээмжийг нэмэгдүүлэв. Цахим хөтөч ашиглалт цар тахлын улмаас тооцож байснаас бага хандалттай байсан хэдий ч төслийн үр дүн эмзэг бүлгийн иргэдээс гадна жижиг бизнес эрхлэгчдэд төрийн цахим үйлчилгээ авахад нь ихээхэн тус нэмэртэй байсныг төслийн үнэлгээнд дурджээ. Бид орон нутагт эрх зүйн хөтөч бэлтгэж ажиллуулах энэ үйл хэргийг төслийн хугацаанд хамтран ажилласан ХЗҮХ-д шилжүүлэн 2021 онд амжилттай дуусгавар болгосноос хойш эрх зүйн хөтөч нарыг бүртгэх, гэрчилгээ олгох, давтан сургах зэрэг үйл ажиллагааг ХЗҮХ орон нутгийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж байгаа бол үйл ажиллагааны зардлыг нь орон нутаг хариуцан ажиллаж байна.

Тэрчлэн ХЗДХЯ-тай хамтран “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь” хөтөлбөрийн цаашдын тогтвортой байдлыг хангах үүднээс хандивлагчдын үүлзалт зохион байгуулж хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, гарсан үр дүн, цаашдын зорилт, төлөвлөгөөг танилцуулсны үр дүнд хэд хэдэн олон улсын байгууллагаас эрх зүйн хөтөч бэлтгэх, албан бус сургалт болон гарын авлага, хэвлэн нийтлэлийг дэмжих зэрэг хамтын ажиллагааны тодорхой санал ирүүлэн санхүүжилт олгосон билээ.

Олон улсын туршлагаас харахад тодорхой эмзэг бүлгийн иргэдэд эрх зүйн дэмжлэг үзүүлэхдээ тэдэнтэй ажиллаж итгэлийг нь даасан, тэдний төлөөлөл болох иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан нэн хэрэгцээт эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг хүргэх арга илүү үр дүнтэй байдаг аж. Бид олон улсын хэмжээнд иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх талаар багагүй туршлага

хуримтлуулсан Намати байгууллагатай хамтран Монголын иргэний нийгмийн байгууллагуудад зориулан гурван удаагийн сургалт-семинар зохион байгуулж, нийт 12 байгууллагад нэгээс хоёр жилийн хугацаатай төслийн тэтгэлэг олгож ажиллав. Эдгээр төсөл амжилттай хэрэгжсэн бөгөөд зарим байгууллага бусад хандивлагчийн дэмжлэгтэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. ННФ-ын иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан тэтгэлгийн хүрээнд 160 гаруй иргэний нийгмийн хөтөч бэлтгэгдсэн бөгөөд ХЗҮХ-ийн сургаж бэлтгэсэн орон нутгийн эрх зүйн хөтөч нараас ялгарах онцлог нь гэр бүлийн хүчирхийллийн даван туулагчид, уул уурхайн нөлөөлөлд орсон орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнууд, захын хорооллын хүүхэд залуус, орон байртай байх эрх нь хөндөгдсөн иргэд гэх зэрэг тодорхой бүлгийн тулгамдсан асуудлаар бэлтгэгдсэн тэдгээр хөтөч нар дээрх бүлгүүдийн төлөөлөл болсон иргэд байгаа явдал юм.

2016 оноос эхэлсэн “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь” олон улсын санхүүжилттэй энэхүү төсөл нь эрх зүйн анхан шатны мэдээлэл, үйлчилгээ хүргэх албан болон албан бус суваг, механизмыг ийнхүү бүрдүүллээ. Түүнчлэн тус төсөл нь тодорхой эмзэг бүлгүүдийн эрхийг хамгаалах, эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлэхэд чиглэсэн иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, цаашид өргөжин тэлж чадавхжих боломжийг бүрдүүлснээр манай улсын хууль зүйн анхан шатны туслалцаа, мэдээлэл хүргэх тогтолцоог хэрэгцээнд суурилсан, илүүтэй мэдрэг болж төлөвшин хөгжихөд чухал хувь нэмэр оруулсан билээ.



**ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГМИЙН БОДЛОГО**

Эдийн засгийн бодлогын асуудал

Эдийн засгийн бодлогын асуудал нь ННФ үйл ажиллагааныхаа эхний стратегиас л ач холбогдол өгч авч үзэн бодлогын шинжтэй, өргөн хүрээний олон сэдвийг хамарсан ажил юм. Энэ хүрээнд Монголын ирээдүйн хөгжлийн зураглалыг боловсруулах, ирээдүйд ул мөр үлдээх нийгэмд тулгамдаж буй асуудлуудаар хэлэлцүүлэг өрнүүлж, судалгааг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласаар байна. Тухайлбал, Монголын хөгжлийн зураглалыг 2004, 2011 онд хоёр удаа тусгай аргачлалын дагуу гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг оролцуулан боловсруулж “Гочоогийн дөрвөн тавилан”, “Дөрвөн заяа” нэрээр олон нийтэд хүргэж байсан бол 2007 онд төрийн болон эдийн засгийн бодлогын шилжилтийн амаргүй цаг үед Ерөнхий сайдаар ажиллаж байсан Д.Содном, Д.Бямбасүрэн, Ш.Гунгаадорж, П.Жасрай, Р.Амаржаргал нарыг урьж “Монгол Улсын Ерөнхий сайд нар ярьж байна” сэдэвт цуврал ярилцлага зохион байгуулж байв.

Бие даасан, чанартай судалгааны мэдээлэл хомс байсан 2004-2009 оны үед ННФ-аас улс орны эдийн засгийн хөгжлийн асуудалд хамаарах олон чухал судалгаа гарч байсны сацуу, орон нутгийн эдийн засгийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах, хөрөнгө оруулалтын сангийн суурийг тавьсан жижиг төслүүдийг олон улсын байгууллагуудтай түншлэн санхүүжүүлсэн нь тухайн үедээ иргэдийн амьдрал болон шинээр үүссэн бизнесийн хөгжилд

“Монгол Улсын Ерөнхий сайд нар ярьж байна” сэдэвт цуврал хэлэлцүүлгийн үеэр, зүүн гар талаас: Ерөнхий сайдаар ажиллаж байсан Д.Содном, Д.Бямбасүрэн, Ш.Гунгаадорж, П.Жасрай нар (2007 он)



нэмэртэй байсныг оролцогчид нь тэмдэглэж байсан билээ. Жишээ нь, 2006 онд оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурласан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх Делта төсөлд 4 аймгаас түс бүр нэг сум хамрагдаж төслийн үр ашгаасаа “Хөрөнгө оруулалтын сан” байгуулан дараа дараагийн төслөө санхүүжүүлэх хэмжээнд хүрч байсныг дурдъя. Түүнчлэн 2010 онд Шинэ Зеландын Засгийн газрын санхүүжилтээр алслагдсан орон нутгийн иргэд бүлгээр ажиллах, бүлгийн маркетингийн үйл ажиллагааг дэмжих төсөл хэрэгжин орон нутгийн бизнесийн орчны судалгаа анх удаа хийгдэж байв.

Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуйн ирээдүйн чиг хандлага, энэ салбарт төр засгийн гүйцэтгэх үүрэг, хөгжлийн албан ёсны түслэмжийн хөдөөгийн хөгжилд үзүүлсэн үр нөлөө, мал аж ахуйн бодлогын ялгавартай байдал зэргийг гүнзгий авч үзсэн бодлогын болон олон нийтийн санал асуулгын судалгаанууд 2004-2006 оны хооронд хийгдэж энэ сэдвээр яриа хэлэлцүүлгүүд өрнүүлж байсан билээ. Түүнчлэн 2006-2012 онд эдийн засгийн бодлогын

чухал асуудлууд болох албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эмзэг байдал ядуурал, халамжийн үйлчилгээний иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө, хэрэглэгчийн индексийн судалгаанууд хийгдэн олон нийтэд хүрчээ. МУИС-тай хамтран Монголын эдийн засгийн эрх чөлөөний тоймыг 2006 оноос гаргасан ба 2008 онд “Эдийн засаг дахь төрийн оролцоо”-г онцлон авч үзэж байв. Мөн Эдийн засаг, бизнесийн үндсэн ойлголт, зарчим, эдийн засгийн эрх чөлөөний талаарх мэдлэгийг энгийн ойлгомжтойгоор илэрхийлсэн “Эдийн засаг энгийнээр” номыг 2007 онд англи хэлнээс орчуулан хэвлэж, Монгол Улсын макро эдийн засгийн богино, дунд хугацааны компьютерын загварыг 2009 онд боловсрууллаа.

Түүнчлэн дэлхийн санхүүгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө, инфляцын эсрэг авч хэрэгжүүлэх макро эдийн засгийн бодлогын судалгаануудыг 2008-2009 онд давтамжтай хийж, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороотой хамтран үр дүнг нь нийтэд хүргэхийн сацуу Санхүүгийн зах

2004 онд Монголын хөгжлийн зураглалыг хэлэлцэж боловсруулсан баг



зээлийн холбоотой хамтран “Хэрэглэгчийн итгэлийн индекс” судалгааг 2009-2013 онд давтамжтай хийж гүйцэтгэсэн билээ.

Сүүлийн жилүүдэд бид иргэдийн орлогын тэгш бус байдлыг бууруулахад зарлага талаас нөлөөлөх хүчин зүйлсийг судлахаас гадна орлого талаас нөлөөлөх хүчин зүйлс буюу иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд халамжийн үзүүлэх нөлөө, татварын асуудлаарх судалгааг дэмжиж ажиллалаа. Тухайлбал, 2021 онд Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-д хөндлөнгийн тойм дүгнэлт хийсэн бол 2023 онд Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, цалин, халамжийн бодлого иргэдийн ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөөлөл; хувь хүний орлогын албан татварт хамрагдаж буй орлогын эх үүсвэрүүд; жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнест импортын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалтыг боловсронгуй болгох зэрэг чиглэлээр судалгаа хийж, зөвлөмж гаргасан юм.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг олон улсын зэрэглэлтэй харьцуулан судалж, ахиц дэвшил олоход ННФ мөн дэмжлэг үзүүлж ажилласаар ирлээ. Энэ хүрээнд бид олон улсын Фрейзер

институттай түншлэн 2006 онд тус институтээс гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексэд мэдээлэл илгээснээр анх удаа Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт тус байгууллагын судалгааны жагсаалтад гарах болсон билээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль анх 1992 онд батлагдаж хэрэгжсэнээс хойш даруй 10 гаруй жилийн дараа нийгмийн болон эдийн засгийн олон нөхцөл байдал өөрчлөгдөж хууль шинэчлэхтэй холбоотой чанартай судалгаа мэдээлэл нэн шаардлагатай үед 2004-2009 онд энэ сэдвээр хэд хэдэн судалгаа хийж, төрийн болон иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан уулзалтууд зохион байгуулж, мөн “Форум ТВ” нэвтрүүлгээрээ ч энэ асуудлыг орон даяар хэлэлцүүлж байсан билээ.

Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Үндсэн хуулийн хүрээнд төвлөрсөн бус тогтолцоог оновчтой болгох чиглэлээр бодлогын хувилбар агуулсан зөвлөмж боловсруулж, холбогдох талуудад хүргэхийн зэрэгцээ “Форум ТВ” нэвтрүүлгээрээ орон нутгийн засаг захиргааны хуваарийн оновчтой байдал, эрх мэдлийн харьцааны талаар сонирхлын бүлгүүдийг оролцуулсан

хэлэлцүүлэг өрнүүлэн орон даяар цацаж, нэвтрүүлгийн үеэр шууд утас ажиллуулан иргэдийн саналыг оролцогчдод хүргэж байв. Улмаар нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт (2005), орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж, арга замын талаарх (2006) судалгаануудыг тус тус хийж гүйцэтгэн хуулийн шинэчлэлийн багт хүргүүлэв.

2008 онд зохион байгуулсан “Хариуцлагатай төр” Үндэсний форумаараа Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёсны асуудлыг хэлэлцэн, Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтын судалгааны ажлынхаа үр дүнг танилцуулав. Үүнээс гадна санхүүгийн төвлөрлийг бууруулах ажлын нэг хэсэг болох боловсролын салбарын үүрэг функцийн хуваарилалтын судалгааг мөн 2008 онд хийж гүйцэтгэн “Төсвийн төвлөрлийг сааруулах үр ашигтай стратеги боловсруулж хэрэгжүүлэх” сургалт зохион байгуулан энэхүү эх сурвалжийг нийтэд хүргэж байлаа.

Газрын шинэтгэлийн асуудлаар судалгаа, мониторинг хийх, бусад ижил төстэй улстай түршлага солилцох хэмжээнд олон улсын хурал зохион байгуулах, бэлэн болсон эх сурвалжаа түшиглэн шинэтгэлийн асуудлаарх маргаан,

ННФ-ын санхүүжилтээр Байгаль 21 ТББ-ын хийсэн газрын шинэтгэлийн мониторингоор газрын хуваарилалтад гарч буй алдаа дутагдал, газар ашиглалтын байдлыг нарийвчлан судалж, иргэдэд газар олгохдоо эдийн засгийн үр өгөөж, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах үүднээс хандаж, шударга явуулах талаар бодлогын тодорхой зөвлөмж гаргаж байв.

цаашид анхаарвал зохих зүйл дээр олон нийт, бодлого боловсруулагчдын ойлголт, хандлагыг тодорхой болгоход чиглэсэн хэлэлцүүлэг өрнүүлсэн нь газрын шинэтгэлийн бодлого, хэрэгжилтийн талаар баялаг эх сурвалж бүрдүүлсэн билээ. 2004 онд хоёр судалгаа хийгдсэний нэг нь “Хөдөө аж ахуйн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах”, нөгөө нь “Газрын шинэтгэл хэрэгжүүлэх эрх зүйн болон институцын тогтолцооны үнэлгээ” юм.

Улмаар 2005 онд Газрын харилцаа, геодези, зурагзүйн газартай хамтран 2006 онд “Шилжилтийн улс орны газрын шинэтгэлийн бодлого”, 2007 онд “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” сэдэвт

Өрсөлдөх чадвар

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2004 онд 10-аас илүү хувь давсан шалтгааныг тухайн үед олборлох болон үйлчилгээний салбарын түлхүү хөгжлөөс гадна өрсөлдөх чадварын шинэ нөхцөл байдалтай холбон дүгнэж байлаа. Үүнтэй зэрэгцэн Монгол Улс 2005 оноос анх Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-аас гаргадаг Өрсөлдөх чадварын судалгаанд хамрагдаж эхэлсэн бөгөөд уг судалгаа нь дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгэмд ихээхэн сөрөг үр дагавар бүхий

олон улсын бага хурлууд зохион байгуулж, хурлын илтгэлүүд, хэлэлцүүлгүүдийн тэмдэглэлээр товхимол гаргахад нь дэмжлэг үзүүлэв. ННФ-аас жил бүр уламжлан хийж байсан Үндэсний форум 2006 онд “Төрийн ил тод байдал” сэдвийн дор явагдан газар олголтын ил тод байдлыг мөн хэлэлцэж байлаа.

Ийнхүү бид үйл ажиллагааныхаа бүр эхний үеэс ажиллаж ирсэн эдийн засгийн бодлогын хүрээний дээр дурдсан судалгаанууд, мониторингийн дүнгүүд, Үндэсний форум болон чухал уулзалт, хэлэлцүүлгийн тэмдэглэл зэрэг эх сурвалжуудаа www.forum.mn сайтад байрлуулж ирсэн ба тэдгээр нь өнөөг хүртэл нийтэд нээлттэйгээр ашиглагдаж буй.

Ковид-19 цар тахал гарсан жил буюу 2019 он хүртэл жил бүр улс орнуудын өрсөлдөх чадварын зэрэглэлийг тодорхойлон гаргасан юм. Судалгааг анх АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Эдийн засгийн бодлогын шинэчлэл, өрсөлдөх чадвар” төслийн хүрээнд ННФ хийж эхэлснээс хойш өрсөлдөх чадварын индексийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг Бизнесийн удирдах ажилтнуудын санаа бодлыг бусад судлаачтай хамтран жил


тутам тандан судалж байна. Өрсөлдөх чадварын судалгаагаар ДЭЗФ 12 бүлэг үзүүлэлтээр судалгаанд оролцсон бүх улсыг эрэмбэлэн жагсаадаг юм.

Шинэ судалгааны дүн гарах бүрд бид олон нийтэд танилцуулж ирсний дүнд УИХ-аас 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтэд өрсөлдөх чадварыг оруулахаар 19 дүгээр тогтоол гарган баталгаажуулж өрсөлдөх чадвараараа дэлхийн эхний 70 орны нэг болох зорилт дэвшүүлсэн билээ. УИХ-ын тогтоол гаргаж, бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжихэд өрсөлдөх чадварын үзүүлэлтийг тооцохоор оруулсан хэдий ч дэлхийн өрсөлдөх чадварын 2019 оны тайлангаар Монгол Улс авбал зохих 100 онооноос 53-ыг авснаар судалгаанд хамрагдсан 141 орноос 102 дугаарт эрэмбэлэгдэв. Энэ нь манай улс өрсөлдөх

чадвараа дээшлүүлэх чиглэлээр дорвитой ажил хийх шаардлагатай байсныг илтгэнэ. Ялангуяа институциудын чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил гэсэн үзүүлэлтүүдийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарлаа хандуулах шаардлагатай байв.

Ковид-19 цар тахлаас хойш буюу 2020 оноос улс орнуудын өрсөлдөх чадварын зэрэглэлийг ДЭЗФ гаргаагүй байна. Гэсэн хэдий ч 2019 оноос бизнесийн удирдах ажилтнуудын санаа бодлын судалгаа жил бүр хийгдэж ДЭЗФ-аас гаргадаг бусад тайланд ашиглагдаж байна. Тус байгууллагаас 2020 онд Өрсөлдөх чадварын тайлангийн тусгай дугаар эрхлэн гаргасан ба тус тайланд цар тахлын үеийн хямралаас гарах замыг улс орнууд хэрхэн туулж байгаад анхаарлаа хандуулжээ.

Монгол Улсын өрсөлдөх чадвар, 2018 он



Боловсрол, нийгмийн бодлого

ННФ нь нийгмийн салбарт өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийг судлах, тулгамдсан асуудлыг тодорхойлж, оновчтой шийдэл эрэлхийлэх, нийгмийн хөгжилд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй үзэгдэл, хандлагыг бодлогын хэлэлцүүлэгт оруулахад анхаарч ирлээ. Ерээд оны сүүлээр хэрэгжсэн боловсрол, эрүүл мэнд, урлагийн байгууллагуудын хувьчлалыг судалж, хувьчлалын процессыг баримтжуулан, ололт амжилт төдийгүй сорилт, сургамжийг нь олон нийт, бодлого шийдвэр гаргагчдад хүргэж нийгмийн бодлогын хөтөлбөрийнхөө суурийг тавьж байсан билээ.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн загварууд, тэтгэврийн нэрийн дансны бодлого, эрүүл мэндийн үйлчилгээ дэх үйлчлүүлэгчийн эрх, боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан төсвийн зарцуулалтын судалгаа, 1990-ээд оны эдийн засгийн хямралыг Монголын боловсролын салбар даван туулсан туршлага зэрэг асуудлыг хөндсөн судалгааны үр дүнг бодлогын яриа хэлэлцүүлэгт нэмэрлэсэн юм.

Боловсролын үйлчилгээний хүртээмжид онцгой анхаарч, шилжин суурьшигч, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн хүүхдүүд болон сүм хийдэд шавилан суугч, хорих ангид ял эдэлж байгаа хүүхдүүдийн сургууль завсардалтад иргэний нийгэм, бодлого боловсруулагч, хандивлагчдын анхаарлыг хандуулсан нь эдгээр бүлгийн хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангахад хувь нэмэр болсон гэж найдаж байна. ННФ-ын дэмжлэгтэйгээр хот, хөдөөгийн төрийн бус байгууллагууд сургууль завсардалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн орлого багатай болон эмзэг бүлгийн хүүхдүүдийг сурах бичиг, сургалтын хэрэгслээр үнэ төлбөргүй хангах хөтөлбөрт тогтмол мониторинг хийж байлаа.

2010-2024 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудалд төвлөрч, тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчныг сайжруулах үйл явцыг судалгаа шинжилгээгээр хангах, тэгш хамруулан сургах тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн салбарын оролцогч талуудыг чадавхжуулах зорилтуудыг дэвшүүлж ажиллалаа. Монгол Улс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод 2008 оны 12 дугаар сард нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн тэгш оролцоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох тэгш эрхийг хангах шинэ зорилт тавигдав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай сургуулиар боловсрол олгодог оор өөр бодит туршлага байхгүй манай улсын хувьд ердийн сургуулиудад үе тэнгийнхэнтэй нь хамт суралцуулах арга зүйг судлах, бусад орны сайн туршлагыг танилцуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ үүсэв.

2013 оноос эрчимтэй өрнөсөн тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчныг сайжруулах үйл явцад идэвхтэй оролцож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн цогц үйлчилгээний зураглал, үг үйлчилгээг салбар дамнасан болон салбар хоорондын стратегиар хэрэгжүүлэх бодлогын судалгаа, холбогдох нөлөөлөл хийсний үр дүнд 2014 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комиссын тогтолцоо бий болов. Салбарын гурван яамтай байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ННФ нь уг Комиссын дүрмийн төслийг боловсруулж, гишүүдийг чадавхжуулах, арга зүй, удирдамж заавар боловсруулах, Комиссын дүнд хугацааны стратеги боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэв. Тэрчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль



(2016), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр (2017), БШУЯ-аас гаргасан журмуудыг боловсруулахад оролцов.

ННФ-ын үзүүлсэн дэмжлэгээр Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, МУБИС-ийн Боловсрол судлалын сургууль нь тэгш хамруулах боловсролын хөтөлбөрөө шинэчилж, МУБИС-ийн Боловсролын суурь судалгааны төв нь суралцагчдын сурах ялгаатай арга барил, хэрэгцээнд нийцүүлэн хичээл төлөвлөлт хийх аргачлалыг нэвтрүүлээ.

Иргэний нийгмийнхний чадавхыг дэмжих зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээл, боловсролын асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагуудыг нэгтгэсэн Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээг 2014 онд байгуулан, тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, бодлогын судалгаа шинжилгээ болон мониторингийн арга зүй эзэмшүүлэх, ном гарын авлага боловсруулах, бодлогын нөлөөлөл, олон нийтийн кампанит ажил өрнүүлэх үр чадвар суулгах зэрэг сургалт зохион байгуулж, үйл ажиллагааны дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллав. Сүлжээний гишүүн 30 гаруй

байгууллага хамтран стратеги төлөвлөгөө боловсруулж, бодлогын нөлөөлөл, сургалт, сурталчилгаа явуулахын зэрэгцээ судалгаа шинжилгээ хийж 10 гаруй жил хүчээ нэгтгэн ажилласны үр дүнд боловсролд тэгш хамруулах чиглэлээр дагнан ажилладаг иргэний нийгмийн хэсэг төлөвшиж, салбартаа эксперт болж танигдаад байна. Тус сүлжээнээс жил бүр зохион байгуулдаг “Тэгш хамруулах боловсролын форум” нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын тулгамдсан асуудлуудыг хэлэлцдэг олон талын оролцоог хангасан, хүлээн зөвшөөрөгдсөн талбар болсныг мөн тэмдэглэхэд таатай байна.

ННФ нь тэгш хамруулан сургах боловсролын ойлголтыг тэлж, хөгжлийн бэрхшээлээс гадна хэлний цөөнх, ядуу өрхийн болон алслагдсан орон нутгийн хүүхэд, жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн охид, хорих ангид ял эдэлж хүүхэд зэрэг тасралтгүй сурч боловсрох эрх нь зөрчигдөх эрсдэлтэй хүүхдүүдийг багтаан, боловсролын үйлчилгээг бүх нийтийн хүртээмжтэй болгох асуудлыг дэвшүүлэн ажиллалаа.

Боловсрол, нийгмийн бодлогын хүрээнд Унгар улс дах Нээлттэй нийгэм хүрээлэнгээс хэрэгжүүлсэн их дээд сургуулийн

багш нарт зориулсан Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулагчаар ННФ 2007-2013 ажиллав. Энэхүү хөтөлбөрөөр гадаадын нэр хүндтэй их дээд сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан эрдэмтэн багш нар эх орондоо эргэж ирж, дотоодын их дээд сургуульд тогтвортой ажиллахад дэмжлэг үзүүлж, тэднээр дамжуулан дотоодын их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэ мэдлэг, шинэлэг аргазүйгээр баяжуулан, сургалт, судалгааны үйл ажиллагааг чанаржуулахыг зорьсон юм. Хөтөлбөрийн оролцогчид гадаадын зөвлөх багшийн удирдлага дор сургалтын хөтөлбөр шинэчлэл хэрэгжүүлэхийн зэрэгцээ жилд

Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх нь

ННФ нь дунд, ахлах ангийн хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх үйлчилгээг нийтийн номын сан, гэр номын сан, төрийн бус байгууллага, оюутны зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлж байсан туршлагатай.

2014 оноос залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлогын орчин бий болгох ажлыг эхлүүлж, уг асуудлаар мэргэжлийн чадавх хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, олон нийт, залуучуудын ойлголт,


нэг судалгааны бүтээл гаргах төлөвлөгөөтэй ажиллаж, хөтөлбөрөөс сар бүрийн стипенд, мөн гадаадад эрдэм шинжилгээний хуралд оролцох зардал, судалгаагаа хөгжүүлэх зорилгоор гадаадын их дээд сургуулийн номын санд ажиллах тэтгэлэг, тэнхим хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх санхүүжилт зэрэг дэмжлэгээр хангаж байлаа. Уг хөтөлбөрт МУИС-ийн Нийгмийн Ухааны сургуулийн Нийгэм, соёлын антропологийн тэнхим, Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим, МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхим, АШУУИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи, биостатистикийн тэнхим, Нийгмийн ажлын тэнхимийн багш нар хамрагдав.

хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлээ. Улаанбаатар хотын алслагдсан дүүргийн сургууль, гэр хороолол, оюутны дотуур байранд үе тэнгийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн нөхцөл байдлын судалгааг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн нь бодит орчны анхны судалгаа болж, уг асуудлаар ажиллах төрийн бус байгууллагуудыг чадавхжуулсан юм. Бодлого, хөтөлбөрийн сайн туршлагыг

ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙН КЕЙС СУДАЛГАА (ЦУВРАЛ)



ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ВИДЕО НЭВТРҮҮЛЭГ



хүргэх зорилгоор ДЭМБ-аас эмхлэн гаргасан “Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Баримт нотолгооны тойм” гарын авлагын орчуулга, сургуулийн орчин дах үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх олон улсын Олвеус, Кива хөтөлбөрүүдийн мэдээллийг өргөнөөр тараан түгээлээ.

Урьдчилан сэргийлэх мэргэжлийн мэдлэг, чадварыг системтэйгээр хөгжүүлэх зорилгоор нийгмийн ажилтан бэлтгэдэг АШУҮИС-ийн НЭМС, ШУТИС, МУБИС, хууль сахиулагч бэлтгэдэг ДХИС-тай хамтран ажиллаж, бакалаврын хөтөлбөрт “Залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь” гурван кредитийн хичээл бий болгов.

Тэрчлэн бага ангийн багш, нийгмийн ажилтан бэлтгэдэг Ховд, Баян-Өлгий, Архангай, Дорнодын их дээд сургууль, коллежийн хөтөлбөрт хүүхэд, залуучуудын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хичээл бий болгоод байна. МУБИС, ДХИС нь уг асуудлыг магистрын хөтөлбөрийн хичээл, МУБИС мөн докторын зэрэг горилох судалгааны сэдэв болгосноор тухай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны сантай болох эхлэл тавигдлаа.

ННФ-ын түнш төрийн бус байгууллага, их дээд сургуулийн судлаач нар үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан

зогсоох чиглэлээр хүүхэд, залуус, ЕБС, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ, БШУЯ, түүний харьяа Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, ХНХЯ, түүний харьяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудад сургалт, мэдээлэл хүргэж, бодлого, хөтөлбөр, арга хэмжээ боловсруулахад зөвлөн оролцож байна.

2014 оны нөхцөл байдалтай харьцуулахад өнөөдөр үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр бий болж, үг үзэгдлийг үл тэвчих хандлага нийгэмд төлөвшиж байгаад ННФ хувь нэмрээ оруулсанд баяртай байна.



ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

Иргэдийн оролцооны механизмуудыг бүрдүүлэх нь

Ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн шинэчлэл эрчимтэй өрнөж байсан 2004-2005 оны үед ННФ шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо чухал болохыг онцлон, эрх зүйн шинэчлэлд түлхэц болох хөрс суурийг бэлдэхэд юуны өмнө анхаарлаа хандуулж, “Шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Эрх зүйн орчин ба институтчилэл” (2004), “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад төрийн бус байгууллагын оролцоо: Эрх зүйн орчин ба институтчиллыг сайжруулах нь” (2005) зэрэг эрх зүйн орчны үнэлгээ, судалгааг МУИС, МУБИС-ийн эрдэмтэн судлаачидтай хамтран хийж гүйцэтгэв. Эдгээр судалгааг эргэн сөхвөөс, тухайн үед бодлогын үйл явцад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо арга зам нь захидал бичих, албан бус үүлзалт зөвлөгөөн зохион байгуулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт уригдвал оролцож ажиллахаар хязгаарлагдаж, шийдвэр гаргагчдын үзэмжээс хамаарч байгааг шүүмжлэн, хууль тогтоох үйл явцын ил тод байдлыг хангах, иргэд мэдээлэл авч оролцоо байнгын тогтмол ажиллагаатай механизмыг бий болгохын чухлыг онцолж байжээ.

Бодлогын судалгаа, шинжилгээнээс гадна хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог

хангах олон улсын сайн туршлагатай холбогдох талуудыг танилцуулах зэрэг нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд хуулийн төсөлд иргэдийн саналыг авч тусгах процессыг хуульчлах бодлогын шинэчлэлийн эхлэл тавигдаж, улмаар иргэдтэй шууд харилцах УИХ-ын Өргөдөл, гомдлын байнгын хороо байгуулагдан ажиллаж (2012-2016) байлаа.

Иргэдийн оролцооны механизмын нэг сонгодог хэлбэр болох нээлттэй сонсголыг танилцуулсан гарын авлагыг ННФ 2009 онд боловсруулан, бодлого боловсруулагчдад хүргүүлж байв. Улмаар 2011 онд УИХ-ын Хууль зүйн байнгын хороотой хамтран Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төслөөр нээлттэй сонсгол зохион байгуулсан нь ардчилсан парламентын түүхэнд болсон хууль тогтоомжийн сонсголын анхных байлаа. Нийтийн сонсгол нь эдүгээ УИХ-ын үйл ажиллагааны тогтмол арга хэрэгслийн нэг болжээ.

Парламентын түвшинд ийнхүү ажиллахын зэрэгцээ орон нутагт шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, 2011 онд нийт 9 аймагт төрийн бус байгууллагуудтай хамтран ИТХ-ыг нээлттэй болгох, Иргэний танхимын үйл ажиллагааг хэвшүүлэх, иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулж явуулах журмыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан юм.

2012-2016 онд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог баталгаажуулахад чухал нөлөөтэй хуулиуд батлагдан гарав. Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулийн төсөлд ННФ санал шүүмж өгч, зарим хуулийн ажлын хэсэгт оролцон ажиллаж, иргэдийн оролцоог хангах зохицуулалтыг тусгуулахад хувь нэмэр орууллаа. Эдгээр хуулийн талаарх мэдээлэл орон нутагт төдийлөн хүрээгүй байсан нь хуулийн хэрэгжилтийг удаашруулан, үр нөлөөг нь бууруулах эрсдэлтэй тул ННФ 21 аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудад зориулсан сургалт хийж, сургагч багш бэлтгэлээ. Захиргааны ерөнхий хууль нь орон нутагт шийдвэр гаргах үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, иргэдийн оролцоог бодитой нэмэгдүүлэх түүхэн ач холбогдол бүхий шинэчлэл тул хуулийн хэрэгжилт эхэлсэн цагаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжийн дагуу мониторинг хийж, хэрэгжилтэд түлхэц өгөх нөлөөлөл явууллаа. Нийтийн

сонсголын хууль 2016 оноос хэрэгжиж эхлэхэд мөн холбогдох талуудад дэмжлэг үзүүлж ажиллав. УИХ-аас ерөнхий хяналтын анхны сонсголыг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр агаарын бохирдлын буюу “утааны” асуудлаар зохион байгуулав.

ННФ-ын сүүлийн жилүүдийн үйл ажиллагаа нь эдгээр хуулийн хэрэгжилтийг иргэний нийгмийн оролцоотой тасралтгүй хянах, дэмжлэг үзүүлэх, нэмэлт өөрчлөлтүүд нь хуулийн үзэл санаа, иргэдийн оролцоог хангах зорилгод нийцэж буй эсэхийг няхуур нягтлан ажиглах, мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах, подкаст хийх гэх мэт ажлаар үргэлжилж байна.

Төрийн бус байгууллагуудын хяналт тавих оролцоо нь нийтийн эрх ашгийг хамгаалах, сайн засаглалыг бэхжүүлэхэд нэн чухал байж ирсэн нь ННФ-ын 20 гаруй жилийн үйл ажиллагааны замналаас тод харагдана. ННФ нь 2004-2014 онд хэрэгжүүлсэн мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрөөр төрийн бус байгууллагуудад ардчиллын институцийн хувьд төрд хяналт тавих үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ төрийн ил тод байдал, иргэний

Утааны асуудлаар сонсгол зохион байгуулахыг шаардсан нөлөөллийн ажлыг Утааны эсрэг аав, ээжүүд ТББ 2017 оноос эхлэн ННФ-ын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн юм.





оролцоог дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд судалгаа шинжилгээгээрээ томоохон хувь нэмэр оруулсан билээ. ННФ-ын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагууд газар олголт, төрийн үйлчилгээний хүртээмж, гаалийн үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, төсвийн зарцуулалт зэрэг нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудлаар 200 орчим мониторинг хийжээ. Эдүгээ мониторинг нь төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны нэг чухал хэрэгсэл болж хэвшээд байна.

Төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хариуцлага нэхэх иргэний нийгмийн бас нэгэн чухал арга хэрэгсэл болох стратегийн өмгөөллийг Монголд танилцуулах, чадавх бэхжүүлэх, хуульчдыг татан оролцуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг 2005 оноос шат дараатайгаар хэрэгжүүлж ирлээ. Стратегийн буюу нийтийн эрх ашгийн өмгөөллийн гарын авлага боловсруулж, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, бие даасан тэтгэлэгт хөтөлбөрөөр хүний эрх, нийтийн эрх ашгийн тулгамдсан асуудлаар гомдол, нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажилласны үр дүнд хүн худалдаалах, гэр бүлийн хүчирхийлэл, байгаль орчин, нийтийн эзэмшлийн зам талбайн асуудлаарх анхны нэхэмжлэлүүд гарч шийдэгдэн, тогтоосон жишиг нь олон байгууллагад энэ чиглэлээр ажиллах урам зориг өгсөн юм.

Тухайн үед нийтийн ашиг сонирхлыг хэрхэн томъёолж, хэн хэрхэн төлөөлөн хамгаалахыг эрх зүйн орчинд тодорхойлоогүй байсны улмаас төрийн бус байгууллагууд нэхэмжлэл гаргах боломжгүйд хүрч, нийтийн ашиг сонирхлын олон зөрчил шүүхийн хяналтын гадна үлдэж байлаа. Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалахын ач холбогдлыг нийгэмд таниулахад чиглэсэн төрийн бус байгууллагуудын уйгагүй хүчин чармайлтын дүнд 2010 онд байгаль

орчны асуудлаар нэхэмжлэл гаргах эрх нээгдэж, 2016 онд шинэчлэн батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар энэхүү эрх баталгаажсан юм.

Төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хамгаалах хуулийн хүрээнд нээгдсэн шинэ боломжийг үр дүнтэй ашиглах чадавх бэхжүүлэхийг чухалчлан Улаанбаатар хот, 21 аймгийн төрийн бус байгууллагуудыг сургалтад хамруулж, тэтгэлэгт хөтөлбөрөө өргөжүүлсэн юм. Өнгөрсөн хугацаанд ННФ-аас олгосон тэтгэлгийн хүрээнд төрийн бус байгууллага, хуульчид 90 гаруй гомдол нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, нийтийн өмч хөрөнгө, зам талбайн ашиглалт, хүрээлэн буй орчин, уул уурхайн асуудлаар төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалахад чиглэсэн олон чухал шийдвэр гаргуулж чаджээ. Хуульчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хуульчийн

үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, шинэ залуу хуульч, оюутнуудыг нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах арга зүйд сургах “Оюутны стратегийн өмгөөлөл, нөлөөлөл” хөтөлбөр хэрэгжүүллээ.

Ийнхүү эрх зүйн шинэчлэл явагдаж, түүнийг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм идэвхийлэн оролцож буй ч 2016-2024 онд захиргааны хэргийн шүүхэд гаргасан нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн бараг 80 хувь нь буцаагдаж эсхүл хэрэгсэхгүй болсон нь хууль эрх зүйн хүрээнд тулгардаг саад бэрхшээл бүрэн арилаагүйг илтгэж байна. ННФ эрх зүйн орчин, шүүхийн практикт нарийвчилсан шинжилгээ хийж, хуулиар тодорхойлсон нийтийн ашиг сонирхлын цар хүрээ, нэхэмжлэх эрхийг өргөжүүлж, иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг нээх зэрэг энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчныг шинэ шатад гарган хөгжүүлэхээр ажиллаж байна.

Төрийн бус байгууллагуудад зориулсан нийтийн эрх ашгийн өмгөөллийн сургалт (2018 он)



Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих нь

Ардчиллын тулгуур баганын нэг болох иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд ННФ хүчин чадлаа дайчлан ажиллаж ирлээ. Анхны ардчилсан Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулахад идэвхтэй бөгөөд хүчтэй иргэний нийгэм бүрэлдэн хөгжих нь нэн чухал байв. Ийм ч учраас Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т иргэний нийгмийн байгууллагын төлөвшил нь дотоодын аюулгүй байдлын нэг чухал хүчин зүйл болохыг хүлээн зөвшөөрч, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх тухай дурджээ.

ННФ нь хүний эрх, ардчилал, сайн засаглалын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын тогтвортой, мэргэшсэн, үр нөлөөтэй үйл ажиллагааг дэмжихэд анхаарч, хамтран ажиллаж ирлээ. Энэ хүрээнд хэрэгжүүлсэн мониторинг, нийтийн эрх ашгийн өмгөөллийн болон бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрүүд нь төрийн бус байгууллагуудад төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын шинжилгээ, нөлөөлөл хийх арга зүй эзэмших, үр чадвараа дээшлүүлэхэд нь чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй олон арван мониторинг, нийтийн эрх ашгийн өмгөөллийн төсөл хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж, чиглэл гаргах боломж бүрдүүлжээ.

Бид төрийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах эрхэм зорилготой иргэний нийгмийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа үялдуулан нэгтгэж, “Шударга сонгуулийн төлөөх иргэний нийгмийн эвсэл”, “Иргэд төсвөө хянана”, “Төлсөн авснаа нийтэл”,

“Хүний эрхийн форум” зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын эвсэл байгуулагдахад болон цаашид тогтвортой, үр нөлөөтэй ажиллахад нь байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж ирлээ. Ийнхүү эвсэлд нэгдэж ажиллах нь хүний болон санхүүгийн хязгаарлагдмал нөөцөө зохистой ашиглах, нэгдмэл үнэт зүйлд суурилсан үзэл бодол, байр сууриа нэгтгэн илэрхийлэх замаар үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэх, ярвигтай нөхцөл байдалд бие биедээ эв санааны дэмжлэг үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой билээ.

Төрийн бус байгууллагууд урт хугацаанд тогтвортой, мэргэшсэн үйл ажиллагаа явуулахад стратеги төлөвлөлт, санхүүгийн зохист удирдлага нэн чухал юм. Бид зарим төрийн бус байгууллагын хүсэлтийн дагуу стратеги төлөвлөгөө боловсруулах сургалт хийж, төлөвлөлтийн үйл явцад нь санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ олон нийтийн дэмжлэгээр санхүүждэг бусад орны төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцуулав. Тэрчлэн төрийн бус байгууллагад зориулсан санхүүгийн түсгай программ захиалан боловсруулж, сургалт явуулсны үр дүнд 50 гаруй байгууллага энэхүү программыг ашиглан, санхүүгийн менежмент, тайлангаа сайжруулж ирлээ.

Сүүлийн үед иргэний нийгмийн мэдээллийн аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдах болсныг онцлон цахим аюулгүй байдал, худал мэдээллээс сэргийлэх, баримт нягтлах зэрэг сургалтыг танхимаар болон онлайнгаар хийж байгаагийн зэрэгцээ өгөгдөл боловсруулах, дүрсжүүлэх, төсөл бичих зэрэг чадавхыг сайжруулахад анхаарч байна. Мөн ардчилал, хүний эрх, сайн засаглалын чиглэлээр

ажилладаг төрийн бус байгууллагуудыг үнэ төлбөргүй оффисын байраар хангаж, тогтвортой байдалд нь бодит хувь нэмрээ оруулах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд 2017-2023 онд зургаан байгууллага оффисын байрны тэтгэлэг хүртсэн бол 2023 оноос дараагийн ээлжийн зургаан байгууллага гурван жилийн хугацаагаар уг дэмжлэгт хамрагдаж байна.

Иргэний нийгмийг сурталчлан таниулах хүрээнд тусгай төлөвлөгөө гарган ажиллаж, төв болон орон нутгийн олон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны талаар баримтат нэвтрүүлэг бэлтгэн, телевизийн сувгуудаар нэвтрүүлсний зэрэгцээ mpres.mn мэдээллийн сайттай хамтран иргэний нийгмийн идэвхтний хөрөг цуврал болон төрийн бус байгууллагуудын онцлох үйл ажиллагааг тогтмол мэдээлэх булан ажиллууллаа. Эдгээр хүчин чармайлт нь хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлд иргэний нийгмийн явуулж буй үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголтыг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулж, улмаар иргэдийн дэмжлэгийг цаашид нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон хэмээн найдаж байна. Тэрчлэн бидний үүсгэсэн www.cso.mn сайт нь төрийн бус байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх нэг суваг болохын зэрэгцээ байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулах, иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр, судалгаа шинжилгээний ажлын зар зэрэг мэдээлэл авах боломжийг бүрдүүлж эхлээд байна.

1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль нь Монгол Улсад иргэний нийгмийн олон төрөл, хэлбэрийн байгууллага үүсгэн байгуулагдаж, хүний эрх, нийтийн ашиг сонирхол, нийгмийн шударга ёсыг сахин хамгаалах, төрийн бодлого, шийдвэрт хяналт

тавьж оролцох үүргээ нэр төртэйгөөр биелүүлэн, өөрийн гэсэн орон зайгаа нийгэмд эзлэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн билээ.

2000-аад оны дунд үеэс төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинээр баталсан Иргэний хуульд нийцүүлэх үйл явц эхэлсэн билээ. Энэхүү үйл явцад ННФ тогтмол оролцож, төрийн бус байгууллагын зохицуулалттай холбоотой гарын авлага, удирдамжуудыг орчуулж нийтлэх, хуулийн төсөл боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх, ажлын хэсэгт орж ажиллах, олон улсын байгууллагын санал шүүмжийг авах, судалгаа шинжилгээ хийх, хуулийн төслийн олон хувилбарт санал зөвлөмж өгөх зэргээр ажиллаж ирлээ.

2004 оноос хойш ХЗДХЯ-аас Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийн олон хувилбар боловсруулсан ч төр болон иргэний нийгэм санал бүрмөсөн нэгдээгүй байна. Төрийн бус байгууллагын тухай шинэ хууль нь төрийн шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавьж оролцох иргэний нийгмийн эрхийг баталгаажуулан, татвар, санхүүгийн орчныг сайжруулж, тогтвортой, хараат бус үйл ажиллагаа болон цаашдын хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой гэсэн иргэний нийгмийн байгууллагуудын хүлээлт энэхүү олон удаагийн төсөлд тусгалаа ололгүй 20 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна.

Ашгийн бус хуулийн олон улсын төв, Ашгийн бус хуулийн Европын төв, Ардчиллын Төлөө Дэлхийн Хөдөлгөөн зэрэг олон улсын байгууллагууд хуулийн төсөл шинэчлэгдэх бүрт санал зөвлөмж ирүүлж, эвлэлдэн нэгдэх эрхийг хангахуйц эрх зүйн орчин бүрдүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буйг талархан тэмдэглэж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Хөгжлийн мэдээллийн төв

ННФ-ын үйл ажиллагааны арга хэрэгслийн нэг болох Мэдээллийн төв 2003 оны 5 дугаар сард байгуулагдан улс орны хөгжлийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд холбогдох шинэ соргог судалгаа, ном товхимол, статистик мэдээлэл түгээж эхэлсэн билээ. Бодлогын мэдээллийн төв нэрээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн энэхүү төв 2004 онд Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, НҮБ-тай хамтарсан Хөгжлийн мэдээллийн төв болж үйл ажиллагаагаа өргөжүүлэв. Тус төв нь электрон каталог (Lib4U), хараагүй хүмүүсийн уншлагад зориулсан туслах төхөөрөмжүүд, RFID технологитой бөгөөд номын сангийн DDC ангилал бүхий 6000 орчим хэвлэмэл сан хөмрөгөөрөө 2004-2009 онд гол төлөв танхимаар үйлчилж байгаад 2010 оноос зарим үйлчилгээ нь, 2013 оноос бүрэн онлайн болсон.

Тус төв мэдээллийн үйлчилгээ үзүүлэхээс гадна ном, судалгааны материал тараах, номын сангуудын сан хөмрөгийн баяжилт болон номын санчдыг шинэ үйлчилгээнд суралцахад нь дэмжлэг үзүүлэх, судлаачид болон хамтрагч байгууллагын албан тушаалтнуудыг урьж үйлчлүүлэгчидтэйгээ уулзуулах, электрон мэдээллийн зохиогчийн эрхийн асуудлыг сурталчлах зэрэг ажлыг хамарч байлаа. Танхимын үйлчилгээтэй байх үед нийтдээ 40 орчим мянган хүн давхардсан тоогоор 44,000 гаруй эх

сурвалжийг ашиглаж байсан бол онлайнд шилжсэн 2009-2011 онд мэдээллийн хайлт 144,860-д хүрчээ.

Мэдээллийн төв нь 2004-2010 онд ННФ-аас гаргасан нийтдээ 44,500 ном, судалгааг их дээд сургуулийн болон орон нутгийн бүх номын санд түгээв. Түүнчлэн “Сайн дурын хөтөлбөр” эхлүүлж 21 аймгийн 42 номын санчийг ээлж дарааллаар тус Мэдээллийн төвд урьж сургалт хийн, харилцан арга туршлагаа хуваалцахын зэрэгцээ Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Соросын сан Монголд үйл ажиллагаа явуулж ирсний 10 жилийн ойгоор орон нутгийн 250 номын санд 20,000 ам.долларын үнэ бүхий 21 төрлийн ном хандивлаж байлаа.

Олон улсын eIFL байгууллагатай хамтран Үндэсний номын сангийн 2010-2015 оны хөгжлийн стратеги боловсруулах, Номын сангийн үйлчилгээний зохиогчийн эрхийн асуудлаар хамтран ажиллаж, АНУ-ын Конгрессын номын сангийн ном солилцооны хөтөлбөрт хамрагдан ННФ-аас гаргасан ном судалгааг илгээн харилцан ном солилцох хөтөлбөр хэрэгжүүлэв, МУИС-ийн болон Парламентын номын сан, Дархан, Өмнөговь аймгуудын нийтийн номын сан дээр Хөгжлийн мэдээллийн төв байгуулахад Дэлхийн Банктай хамтран оролцлоо. Эдүгээ ННФ өөрийн гаргасан ном, судалгаагаа www.forum.mn сайтаараа дамжуулан нийтийн хүртээл болгож байна.


Портал сайт (www.forum.mn)

“Форум” портал сайт улс орны хөгжлийн бодлого боловсруулах үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд илүү хүртээмжтэй, нээлттэй хүргэх замаар тэдний оролцоог бүрдүүлэх, түүнчлэн бодлогын хэрэгжилтийн талаарх олон талт байр суурийг түгээх, сонирхогч талууд хоорондоо санал солилцох талбарыг бий болгох зорилготойгоор 2003 оны 10 дугаар сард анх бүтээгдэн эдүгээ 21 дэх жилдээ үйл ажиллагаа нь үргэлжилж байна. Анхны хувилбарт бүх агуулга англи, монгол хэлээр гарч байсан нь тухайн үедээ үндэсний

уншигчдын төдийгүй Монголын нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудлаарх мэдээлэл хомс байх үед англи хэлтэй Монголыг сонирхогч гаднын уншигчдад ч хүртээмжтэй мэдээлэл байлаа. Ийнхүү хос хэлээр гарч байсан анхны сайтуудын нэг болохын хувьд агуулга, хэлбэрийг бүрдүүлэхдээ юуны өмнө түргэн шуурхай, шинэлэг, бодитой байх, үл туйлшрах зэрэг хэвлэл мэдээллийн нэр хүндтэй хэрэгслийн баримталдаг тулгуур зарчмуудыг дагаж мөрдөн ажилласан билээ. Энэхүү сайт нь тухайн үед хэлэлцүүлэг өрнүүлэх буюу бүртгэл үүсгэсэн

хэн бүхэн санал, сэтгэгдлээ бичих, тодорхой сэдвээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг уншигчдад олгосноороо онцлог байсан юм.

Портал сайтын агуулга нь анх эхлэхдээ улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг хөндсөн анализ-өгүүлэл, тойм, ярилцлага зэргийг багтаасан Нийтлэл, Ажиглалт, Бодлогын асуудал, судалгааны сангийн электрон хувилбар болох Эх сурвалж гэсэн дөрвөн хэсэгтэй байв. Нийтлэл хэсэгт улс төр, дотоод гадаад бодлого, засаглал, төсөв, уул уурхай, байгаль орчин, татвар, мэдээллийн эрх



чөлөө, даяаршил, хүн амын амьжиргаа, хүнс, газар, хөдөө аж ахуйн сэдвээр жилдээ 30-50 шинэ нийтлэл гардаг байсан бол Ажиглалт хэсэгт бүх шатны сонгууль, уул уурхай, төсөв, жижиг дунд бизнес, донорын тусламжийн асуудлаарх бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрүүдийг нийтлэхийн зэрэгцээ хэрэгжилтийн шатны мэдээ мэдээллүүдийг тоймлон багцалж олон нийтэд хүргэж байв. Харин Бодлогын асуудал буланд олон нийтийн эрх ашигт хамаарал бүхий нийгэмд үр дагавар дагуулахуйц, олон жил дамнан хэлэлцэгдэж байсан Мэдээллийн эрх чөлөөний тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай, Ашгийн төлөө бус байгууллагын тухай гэх зэрэг олон хуулийн төслийг байрлуулан олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, түүнээс гарсан

холбогдох санал, зөвлөмжийг хууль боловсруулах Ажлын хэсгүүд болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнууд, УИХ-ын гишүүдэд хүргэдэг байсан нь хуулийн төслийг сайжруулан боловсруулахад ашиглах нэг эх сурвалж болж байсан болов уу. Сайтын оргил үзэлтийн үед өдрийн хандалт 700-800 хүрч байсны дотор Нийтлэл, Эх сурвалж булангуудын хэрэглэгчийн тоо бусдаас харьцангуй өндөр хувьтай гардаг байв.

Өнгөрсөн 20 жилд www.forum.mn сайт ННФ-ын шинэ стратегиудын хүрээнд бүтэц, зохион байгуулалт, агуулга, дизайны хувьд гурвантаа өөрчлөгдөн өнөөгийн өнгө төрхөө олсон байдаг. Портал сайтын агуулга 2014 оноос видео контентоор баяжиж, *YouTube* суваг (@OpenSocietyForumStudio) хөгжүүлэн хурал, сургалт,

хэлэлцүүлгийнхээ бичлэгийг бүрэн эхээр нь байрлуулахаас гадна зарим сэдвээр богино хэмжээний баримтат нэвтрүүлэг бэлтгэн цацах болсон билээ. Харин сүүлийн үед электрон агуулгын төрлөө өргөжүүлж ННФ-аас гаргаж буй судалгаануудынхаа хүрээнд болон нийгэм, цаг үеийн тулгамдсан, сонирхолтой асуудлуудаар салбарын мэргэжилтнүүд, судлаачидтай ярилцан подкаст хэлбэрээр нийтэлж эхлээд байна.

Одоогоор манай портал сайтад нийт 5600 гаруй агуулга байгаагаас 1400 гаруй нь хэвлэмэл ном судалгаа, гарын авлага болон бусад богино хэмжээний хэвлэн нийтлэлийн бүтээгдэхүүний электрон хувилбар, 400 орчим нь бидний бүтээсэн аудио, видео хэлбэрийн богино бүтээлүүд байна.

"Форум ТВ" нэвтрүүлэг

Нийгмийн хөгжлийн болон бодлогын хүрээний тулгамдсан асуудлаар бодлогын болон иргэний нийгмийнхний төлөөлөл, бизнесийн хүрээнийхэн нүүр тулан уулзаж, хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэн аливаа тулгарч буй асуудлын гарц шийдлийг хэлэлцэх зорилготой ННФ-ын "Форум ТВ" нэвтрүүлэг 2004 оны 9 сараас телевизийн анхны дугаараа цацсан билээ. Энэхүү нэвтрүүлэгт оролцогчид нь сонгогдсон сэдвээр өөр өөрсдийн өнцгөөс санал

бодлоо чөлөөтэй уралдуулан мэтгэлцэх замаар тулгамдаж буй сэдэвт гарц шийдэл хэлэлцэх, үзэгч олонд хэлэлцэж буй асуудлаар мэдлэг мэдээлэл түгээдгээрээ онцлог байв. Уг нэвтрүүлэг нь *Talk Show* маягийн, гэхдээ бодлого боловсруулагчид, судлаач шинжээчид, иргэний нийгмийн төлөөлөл, иргэдийг нэг талбарт уулзуулах хэлэлцүүлгийн шинэ төрлийг телевизийн салбарт анх нэвтрүүлснийг дурдахад илүүдэхгүй болов уу.

Олон талын оролцоотой сонгосон нэвтрүүлгийн сэдэв, агуулга нь өргөн хүрээний асуудлуудыг хөндөж байсныг тоймлон дурдвал, төрийн ой санамж, хариуцлагатай төр, улс төрийн зөвшилцөл, сонгуулийн тогтолцоо, намын гишүүнчлэл, иргэдийн оролцоо бүхий нээлттэй засаглал, боловсролын шинэчлэл, татвар, нийгмийн даатгалын тогтолцоо, мэдээллийн эрх чөлөө болон хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалт, сонирхлын зөрчил,

ННФ-ын "Форум ТВ" нэвтрүүлгийн баг болон ОНРТ-ийн ажилтнууд, 2006 оны 3 дугаар сарын сүүлийн дугаарын дараа



авлигын эсрэг үйл ажиллагаа, тэрчлэн улс орны өрсөлдөх чадавхыг ахиулах тэргүүлэх салбарууд болох уул уурхай, аялал жуулчлалын асуудлууд зэргийг нэрлэж болно. Тухайлбал, 2003-2004 онд цаг агаарын хүнд нөхцөлөөс үүдэн малчдын амьдрал хүндэрч, хот руу шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсэн үед орон нутгийн засаг захиргааны шинэчлэлийн асуудлыг хөндөж “Үлдэх үү, хөгжих үү”; нийслэл хотын төлөвлөлт, агаарын бохирдлын асуудлыг хөндсөн “Хот төлөвлөлтийн бодит байдал”, “Газрын маргаан”, “Улаанбаатар уу, Утаанбаатар уу” хэмээх гурван цуврал нэвтрүүлэг; уул уурхайн гэрээний ил тод байдлыг хөндсөн “Оюутолгой бидэнд юу өгөх вэ?; иргэдийн шилжих хөдөлгөөн, ядуурлын асуудлыг хөндсөн “Монголчууд эргэж ирэх үү”, “Монгол хүний орлого” зэрэг нэвтрүүлэг нь яалт ч үгүй тухайн цаг үеийн халуун сэдвүүд байсан билээ. Зөвхөн 2005 онд 30 удаагийн нэвтрүүлэгт янз бүрийн

ажил мэргэжлийн 1000 орчим хүн биеэр оролцож байр сууриа илэрхийлэн мөн хэдэн мянган үзэгч нэвтрүүлгийн сэдвүүдээр утсаар саналаа өгсөн билээ. Эдгээр асуудлуудын зарим нь өнөө ч шийдэгдээгүй хэвээр, харин ч улам хурцаджээ.

Ийнхүү “Форум ТВ” нэвтрүүлгийн дэвшүүлсэн асуудлууд нь тухайн үедээ нийгмийн анхаарлыг нэлээд татаж, шийдэл олоход түлхэц үзүүлж, иргэний нийгмийн төлөвшил хөгжилд зохих хувь нэмэр оруулсан болов уу гэж бид дүгнэдэг. Ялангуяа орд газрын ашиглалт, шороон ордуудын олборлолтоос эдийн засагт үзүүлж байгаа үр ашгийн төвшин, уул уурхайн олборлолтоос үүдсэн экологийн хохирлыг хөндсөн цуврал нэвтрүүлэг нийгмийг ямар нэг хэмжээгээр “сэрээж”, байгаль хамгаалах, ус болон газрын хэвлийн баялгаа зөв зохистой ашиглахын төлөөх орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэн, санал бодлоо мэдээллийн

хэрэгслээр илэрхийлэх, ажиглалт, мониторинг хийх, түүнийхээ үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэх оролцооны шинэ механизмуудыг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэх үндэстэй.

Нэвтрүүлгийн баг дөрвөн сэтгүүлч, хоёр хөтлөгч, нэг туслахтайгаар нэвтрүүлгүүдээ бэлтгэн, Монголын үндэсний олон нийтийн телевизийн багтай хамтран, “Форум ТВ” нэвтрүүлэгт зориулан бэлтгэсэн тусгай студиес орон даяар нэвтрүүлж байсан. Тус нэвтрүүлэг нь Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс телевиз үзэгчдийн дунд тогтмол явуулдаг санал асуулгын дүнгээр 2005 оны телевизийн улс төр, нийгмийн шилдэг нэвтрүүлгээр шалгарч өндөр чансаатай нэвтрүүлгүүдийн нэг болж байлаа. Ийнхүү “Форум ТВ” нэвтрүүлэг гурван жил шахам хугацаанд нийтдээ 56 нэвтрүүлэг бэлтгэн, Монголын үндэсний телевизийн оргил цагаар, орон даяар цацагдсан түүхтэй.

Хэвлэн нийтлэл

ННФ нь өөрийн эрхлэн гүйцэтгэсэн бодлогын судалгаа, шинжилгээний тайлан, сонгуулийн болон төрийн үйлчилгээний мониторингийн дүн, иргэдэд зориулсан гарын авлага хэвлэн нийтэлж эхэлснээр Хэвлэн нийтлэлийн хөтөлбөрийнхөө эхийг тавьсан билээ.

Форумаас эрхлэн гаргасан бодлогын судалгааны тайлангууд, Төрийн үйлчилгээний мониторингийн үр дүн, Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм (цуврал), Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудал (судалгаа), Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдал, Төрийн бус байгууллагад зориулсан мониторингийн гарын авлага, Стратегийн өмгөөллийн болон Нийтийн сонсголын гарын авлагууд, иргэдэд зориулсан эрх зүйн хөтөч зэрэг нь тухайн үедээ хамгийн эрэлттэй бүтээгдэхүүнүүд байлаа. Мөн зарим чухал уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнг хэвлэн нийтэлж байсны дотор “Монгол Улсын Ерөнхий сайд нар ярьж байна” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлгийн эмхэтгэл тухайн жилийнхээ хамгийн эрэлттэй бүтээл болж байсан билээ.

Жилээс жилд хэвлэн нийтлэх бүтээгдэхүүний сэдэв, цар хүрээ өргөжин тэлэхийн хэрээр зарим төрлийн судалгаа, шинжилгээний дүнг ашиглахад хялбар байлгах үүднээс гол үр дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг онцлон хэвлэн нийтлэх шаардлага үүссэн бөгөөд үүний үр дүнд “Бодлогын асуудал”, “Монитор”, “Хуулийн шүүмж”, “Чухал сэдэв” нэрийн дор цувралаар гаргаж эхэлсэн бүтээгдэхүүнүүд өнөөдөр ч үргэлжлэн бодлогын чухал асуудлуудыг хөндөн, шийдэл санал болгосоор байна. Түүнчлэн төсвийн судалгаануудыг инфографикаар, хүний эрхийн төлөв байдлын тайлангуудыг сэдэвчлэн багцалж хэвлэн нийтлэн, олон нийтэд хүргэж ирлээ. Мөн зохион байгуулж буй хэлэлцүүлгүүдийн тэмдэглэлээ “Үзэл бодол” цувралаар нэгтгэн гаргаж байгаа нь хэлэлцүүлгийн дүнг нийтийн хүртээл болгох боломж бүрдүүлж буй юм.

Төрийн бодлого боловсруулах болон түүний хэрэгжилтийг хянах, эрхээ хамгаалахад нэг талаас мэдлэг мэдээлэлтэй иргэдийн оролцоо нэн чухал байсан хэдий ч нөгөө талаас тухайн хэлэлцэгдэж буй асуудлаарх бодит мэдээлэл,

тооцоо судалгаа, шинжилгээ үнэлгээ хомс, байгаа мэдээлэл нь хүртээмжгүй байсан үе буюу 20 жилийн өмнөөс эхэлсэн энэхүү хэвлэн нийтлэлийн хөтөлбөрийн хүрээнд бодлогын судалгаа, шинжилгээ, үнэлгээ, мониторингийн дүн, иргэдийн гарын авлага нийтдээ 1000 гаруй бүтээгдэхүүн хэвлэн нийтлэгдэж, www.forum.mn сайтад бүрэн эхээрээ байршжээ.



Орчуулгын төсөл

Нийгэм, эдийн засаг, улс төр, хөгжлийн сэдэвтэй, дэлхий нийтийн анхаарал татсан ном хэвлэлийг олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн монгол хэл рүү хөрвүүлэн шүүрхай хүргэх, нийгмийн сэтгэлгээний хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор ННФ нь орчуулгын төсөл хэрэгжүүлж эхэлсэн билээ.

2004-2007 онд Монсудар хэвлэлийн газартай хамтран 11 ном сонгож монгол хэлнээ хөрвүүлэн уншигч түмний хүртээл болгов. Үүнд:

1. Далайг хагалах нь: Хөгжиж буй дэлхий дэх далд нөөц баялгийг сэргээх нь (Майкл Фэйрбэнкс, Стэйс Линдсэй)
2. Төрийг төвхнүүлэх нь (Франсис Фукуяма)
3. Түүхийн төгсгөл ба Сүүлчийн хүн (Франсис Фукуяма)
4. Бодит ертөнцийг судлахуй (Колин Робсон)
5. Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам (Самуэл Хантингтон)
6. Үүсэл: хүн төрөлхтөн, амьдрал, газар дэлхийн болон ертөнцийн түүх (Айзак Азимов)
7. 1984 (Жорж Оруэлл)
8. Либертарианизм (Дэвид Боаз)
9. ХХ зууны улстөрийн философичид (Майкл Лесноф)
10. Нээлттэй Нийгэм ба түүний дайснууд (Карл Поппер)
11. Америк ардчиллын түршлага (Даниель Буурстин).

Тэрчлэн ННФ-ын хөтөлбөрүүдийн хүрээнд эдийн засаг, хөгжлийн сэдвээр хэд хэдэн ном орчуулан хэвлэн нийтэлснээс “Эдийн засаг энгийнээр”, “Сүйрэл”, “Адагт үлдсэн тэрбум” номууд уншигчдын хувьд өндөр эрэлттэй нь байв.



Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр

ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр нь бодлого боловсруулах, бодлогын шийдлүүдийг хэлэлцэх үйл явцад судлаачид үндэслэл нотолгоотой санал дэвшүүлэн оролцох чадавх, соёлыг төлөвшүүлэх зорилгоор анх хэрэгжиж эхэлсэн билээ. Түлгамдаж буй бодлогын асуудлыг шийдэх хувилбаруудыг харьцуулан, хамгийн оновчтой нэг шийдлийг бодлого болгож томъёолоод, хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт боловсруулах энэхүү арга зүй нь асуудлын шалтгааныг тогтоож, бодлогын шийдэл хайж олох, санал болгож буй шийдлийн үндэслэлийг тайлбарлахыг судлаачаас шаардана. Бодлогын судалгааны арга зүй бол бодлогын яриа хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээнд санал, дүгнэлтээ нэмэрлэх нэг арга зам юм.

ННФ бодлого судлаач, шинжээчдийн чадавхыг хөгжүүлэх, бодлогын асуудлаар иргэдэд чанартай мэдээлэл хүргэх, бодлого судлаач, шинжээчийн чадавхыг хөгжүүлэх, бодлогын шийдэл эрэлхийлэх хэлэлцүүлэг, мэтгэлцээний чанарыг дээшлүүлэх арга зам болгож Бодлогын судалгааны

тэтгэлэгт хөтөлбөрийг 2004-2013 онд хэрэгжүүлэв. Хөтөлбөрт хамрагдсан судлаач нь зургаагаас есөн сарын хугацаанд тодорхой сэдвээр бодлогын судалгаа хийж гүйцэтгэх явцдаа ННФ-аас санхүүгийн болон арга зүйн дэмжлэг авахаас гадна бодлогын судалгааны арга зүй, тайлан боловсруулах, нөлөөллийн ажил төлөвлөн хэрэгжүүлэх цуврал сургалтад хамрагдаж, судалгааны үе шат бүрдээ чиглүүлж туслах зөвлөхийн дэмжлэг авч байв. 10 жилийн хугацаанд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт нийт 96 судлаач хамрагдан, газрын харилцаа, уул уурхайн салбарын бодлого, татвар, төсөв санхүүгийн бодлого, худалдан авах үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчил, үлс төрийн санхүүжилт, мэдээллийн эрх чөлөө, иргэний оролцоо, шүүх эрх мэдлийн бие даасан байдал, хүнсний аюулгүй байдал, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, нийгмийн хамгаалал, халамжийн бодлого зэрэг асуудлаар судалгаа гүйцэтгэжээ. Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр эхэлж байх үетэй харьцуулахад эдүгээ манай улсад энэ төрлийн судалгаа хийж гүйцэтгэх чадавх бүрдсэн гэж найдаж буй.

Бодлогын сүлжээ бодлогын зөвлөхийн нүдээр



Бодлогын судалгааны хамрах хүрээ



Бодлогын мөчлөг



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ҮЕ ҮЕИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД БА АЖИЛТНУУД

Удирдах зөвлөлийн гишүүд

<i>Гишүүдийн нэр</i>	<i>Ажилласан хугацаа</i>	<i>Гишүүдийн нэр</i>	<i>Ажилласан хугацаа</i>
Ж.Үнэнбат	2011 оноос	Х.Тэмүүжин	2006 - 2008
Д.Энхжаргал	2019 оноос	С.Цэрэндорж	2007 - 2013
Ч.Болортуяа	2019 оноос	Г.Уранцоож	2007 - 2021
Х.Наранжаргал	2024 оноос	Н.Түяа	2007 - 2009
Н.Энхбаяр	2024 оноос	Ч.Хашчулуун	2009 - 2019
Т.Галбаатар	2004 - 2005	О.Энхтуяа	2009 - 2019
Д.Жаргалсайхан	2004 - 2006	Т.Ундаръяа	2009 - 2014
Саха Мияанатан	2004 - 2006	Г.Эрдэнэбат	2009 - 2013
Ж.Нарантуяа	2004 - 2007	Ц.Отгонбаатар	2013 - 2017
Ц.Ариунаа	2004 - 2007	Ч.Лодойравсал	2013 - 2021
П.Цэнгүүн	2004 - 2009	П.Наранбаяр	2017 - 2024
Л.Төр-Од	2004 - 2009	О.Мөнхсайхан	2017 - 2023
Д.Ганбат	2006 - 2011		

Гүйцэтгэх Захирал

П.Эрдэнэжаргал 2004 оноос

Ажилтнууд

Хөтөлбөрийн менежерүүд

	<i>Ажилласан хугацаа</i>
П.Бадамрагчаа	2004 оноос
А.Гэрэлмаа	2004 оноос
Д.Оюунбадам	2014 оноос
Д.Эрдэнэчимэг	2014 оноос
Д.Энхцэцэг	2006 оноос
Б.Хишигсайхан	2013 - 2022
Н.Дорждарь	2004 - 2013
Б.Мөнхсоёл	2004 - 2013
Ж.Баярцэцэг	2004 - 2008
Б.Цолмон	2013 - 2014
Ж.Оюунтүлхүүр	2013 - 2014
Б.Баттуул	2014 - 2015

Хөтөлбөрийн зохицуулагчид

	<i>Ажилласан хугацаа</i>
О.Сэлэнгэ	2011 оноос
Б.Ундармаа	2019 оноос
Р.Онон	2004 - 2004
Д.Сэнгэлмаа	2009 - 2009

Хөтөлбөрийн туслах ажилтнууд

	<i>Ажилласан хугацаа</i>
Ц.Ижилмөрөн	2004 - 2004
Б.Ичинхорлоо	2004 - 2005
Г.Биндэръяа	2004 - 2004
О.Хатанболд	2004 - 2005
Т.Цэцэгдарь	2005 - 2005
Д.Баярмаа	2006 - 2014
О.Оюунсаруул	2006 - 2010
Д.Долгорсүрэн	2006 - 2009
Б.Хажидмаа	2008 - 2008
Б.Үүрийнтүяа	2011 - 2022
У.Энхцэцэг	2014 - 2018
Б.Батзаяа	2018 - 2019

Мэдээлэл, хэвлэн нийтлэл эрхэлсэн ажилтнууд

	<i>Ажилласан хугацаа</i>
Б.Мөнхгэрэл	2014 оноос
Д.Балжид	2004 - 2022
Д.Гантуяа	2004 - 2012
Ш.Цог	2004 - 2005

Санхүүгийн захирал, менежер

В.Халиунцэцэг
Д.Жавхлан

Ажилласан хугацаа

2019 оноос
2004 - 2022

Санхүүгийн ажилтнууд

Ж.Алтанчимэг
Б.Лхагвацэрэн
Д.Аюуш
Г.Одонмижид

Ажилласан хугацаа

2010 оноос
2019 - 2020
2004 - 2016
2013 - 2016

Оффис менежер

Б.Амгалан

Ажилласан хугацаа

2016 оноос

Мэдээлэл, технологи хариуцсан ажилтнууд

Э.Сайнтүвшин
Д.Өлзийбадрах
Т.Батбаатар

Ажилласан хугацаа

2013 оноос
2004 - 2012
2004 - 2006

Захиргааны туслах ажилтнууд

Б.Бат-Эвлэл
Б.Баатар
Г.Цэдэвхүү
Ч.Саруул
Т.Отгонбаяр
Ш.Ганчимэг
С.Солонго
Д.Ганзул
Н.Хүрэлболд

Ажилласан хугацаа

2017 оноос
2004 - 2022
2004 - 2022
2004 - 2012
2004 - 2012
2005 - 2012
2013 - 2014
2013 - 2016
2014 - 2016

“Форум ТВ” нэвтрүүлгийн баг*Ажилтны нэр*

Д.Энхбат
Ц.Ганболд
Д.Цэрэнжав
Б.Нарантуяа
М.Амарбаяр
Г.Азжаргал

Ажилласан хугацаа

2004 - 2004
2004 - 2005
2004 - 2005
2004 - 2005
2004 - 2005
2004 - 2005

Энэхүү тайланд ННФ-ын үйл ажиллагааны зургууд болон манай тэтгэлгийн хүрээнд ажилласан төрийн бус байгууллагуудын мониторинг, нийтийн эрх ашгийн өмгөөллийн зургуудыг ашиглав. Түүнчлэн текстийн арын фон зургуудад хамтран ажилладаг фото зурагчдын зургаас ашиглав.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН 20 ЖИЛ

Нээлттэй Нийгэм Форум

Жамьян гүний гудамж - 5/3, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240, Монгол Улс

Утас: 76113207

<http://www.forum.mn>

<https://x.com/ForumOSF>

<http://facebook/OpenSocietyForum>

http://www.instagram.com/open_society_forum